ХАЙРТ МОНГОЛ ОРНОО МАНДУУЛЬЯ!

ХИЛ СУДЛАЛ

ДХИС-ИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ,
МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

19 ДЭХ ЖИЛДЭЭ **УЛИРАЛД НЭГ УДАА ГАРНА**

№ 02
2019 он

АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ, ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ТҮҮХТ 85 ЖИЛИЙН ОЙД

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

Д.Ганбаатар. Системийн онолын тухай

Ч.Сайнтөр. Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого ба мерит/чадахуйн/зарчим

О.Гантулга. Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үеийн эрх зүйн зохицуулалт

Б.Амармэнд. Монгол Улсын газрын хэвлийн хилийн хамгаалалт

ЦЭРГИЙН СУРГАЛТ

Б.Мөнгөнбагана. Барьцаалагчтай ярих хэлцэл хийх тактик ажиллагаа

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

Б.Эрдэнэ-Очир. Хүний сэтгэл санаанаы байдлыг судлах асуудалд

ХИЛИЙН ТҮҮХ

Ц.Ганболд. 1911 оны Цицикарын хилийн гэрээ

Х.Уянга. Газар дээр нь магадлан хэмжихэд Монголын төмөр зам 448 метр газартайгаа Хятадын нутагт орсон байсан

Ц.Ганболд. Манжийн дарлалын эсрэг тэмцэгч,Зүүнгарын хаан, Хойдын ноён Галсанданзангийн Амарсанаг гурвантаа оршуулсан түүхийг тодотгохуйд

АСУУДАЛ ДЭВШҮҮЛСЭН ӨГҮҮЛЭЛ

Ц.Ганболд. Хилчин эрс,хүлэг морь хоёр хүйн холбоотой

ГАДААДЫН ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

Т.Баяр-Эрдэнэ. Хятад,Тажикстаны хооронд үүссэн асуудлыг сонирхож үзвэл

ХИЛЧИН-УРАН БҮТЭЭЛ

Б.Эрдэнэ-Очир. Ээждээ. Амин Эрдэнэ. Хонгор нутаг

ХИЛЧНИЙ ШИРЭЭНИЙ НОМ

Ш.Доржбал. Булган хангайн хилчин баатар

Б.Эрдэнэ-Очир. Оюун ухааны чадавхын онцлог

Оюун ухааны онцлог чанар

АГУУЛГА

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ, ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ТҮҮХТ 85 ЖИЛИЙН ОЙД

БАЙЛДААНЫ БОЛОН ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНТ ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ



Хилийн албаны сургууль нь байгуулагдсан цагаасаа хойш улс эх орны аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах хууль ёсыг сахиулах хэрэгцээ шаардлагад нийцсэн дээд, тусгай дунд боловсролтой 7000 гаруй хилчин, офицер, эрх зүйчдийг бэлтгэн гаргажээ.

Монгол Улсын "Хилийн тухай хууль"-ийн *34 дүгээр зүйлийн 34.1-д "Хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги салбар, зэвсэглэл, техник, ар тал хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна"* гэсэн заалтыг хэрэгжүүлэн, Монгол Улсын Засгийн Газраас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, улсын хил хамгаалалтыг бэхжүүлэхэд цэргийн хэрэг, улс төр, хууль, эрх зүйн тусгай мэргэжлийн боловсролтой олон мянган офицер ахлагч нарыг бэлтгэж өгсөн түүхтэй.

БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1984 онд гаргасан зарлигаар эх орныхоо аюулгүй байдал, дархан хилийн хамгаалалтад оруулсан тус сургуулийн хувь нэмрийг үнэлж "Байлдааны гавъяаны одон"-гоор шагнасан бол Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2006 оны 6 дугаар сарын 14-ний 139 тоот тогтоолоор тус сургуулийн төгсөгч МУ-ын баатар С.Лхагвадоржийн нэрэмжит болгосон юм.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 229 тоот тогтоолоор хуучнаар Хилийн цэргийн дээд сургууль нь Цагдаагийн академитай нэгдэн Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургууль болон өргөжиж улмаар Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 141 тоот тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургууль нэрээр явж ирсэн бол өнөөдөр тус сургууль нь Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн а/126 дугаар тушаалаар

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургууль болж, Их сургуулийг хөгжүүлэх цогц бодлогын хүрээнд багш нарыг эрдэмжүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэн, Хил хамгаалах байгууллагын сургалтын нэгдсэн тогтолцоог бий болгох, сургалтын гадаад, дотоод орчны таатай нөхцлийг бүрдүүлэх, бакалаврын болон мэргэжлийн боловсролын түвшинд хөрвөх боломжтой шинэ мэргэжлүүдээр сургалтын агуулга хэлбэрийг өргөжүүлэх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу тус сургууль нь өнөөдрийн байдлаар Хилийн албаны сургуулийн захирлын ажлын алба, мэргэжлийн 7 тэнхимтэйгээр сургалтыг зохион байгуулж байна. Багшлах бүрэлдэхүүний 2 буюу 9.3% нь доктор, 6 буюу 18,9% нь докторант, 71,8% нь магистр зэрэгтэй байна.

ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал язгуур ашиг сонирхлыг хилийн орон зайд үнэнч шударгаар хамгаалдаг, эх оронч үндэсний үзэлтэй, өв тэгш хүмүүжилтэй, хилийн албаны болон цэргийн хэргийн өндөр боловсрол мэргэжил бүхий офицер, ахлагч нарыг бэлтгэдэг хил хамгаалах байгууллагын сургалт, судалгаа, хөгжлийн төв болоход оршино.

ЗОРИЛТ

Хилийн албаны сургууль 2019 онд "Сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд сонсогчдын сурах сургалтын орчин бүрдүүлж, бие бүрэлдэхүүний албаны чадавхийг нэмэгдүүлнэ." гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Хилийн албаны аюулгүй байдлыг хангах ажлын Шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн нэгдсэн инновацийн үр ашигтай тогтолцоог бий болгож, хөгжүүлэн Хил судлалын шинжлэх ухааны чиглэлд тэргүүлэх байр суурьтай, зөвлөх эрхтэй, сургалт судалгаа, оюуны төв байхад чиглэнэ.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

Хилийн сургууль нь 1933 онд "Хязгаарын ба гүйцэтгэх ажилтны курс" нэртэйгээр байгуулагдсан тусгай мэргэжлийн боловсрол олгох манай улсын ууган сургуулиудын нэг бөгөөд 1951 онд татан буугдаж 1974 онд дахин байгуулагдсан.

Тус сургууль нь:

- 1934 Дотоод Явдлын Яамны Төв Сургууль
- 1940-1950 онд Хязгаарын ба Дотоодын цэргийн төв сургууль
- 1974-1982 онд НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль
- 1982-1990 оноос НАХЯ-ны Цэргийн дээд сургууль
- 1990-1994 онд Цагдаагийн Дээд сургуулийн Хилийн албаны тэнхим
- 1994-1997 онд Цэргийн их сургуулийн Хилийн факультет
- 1997-1999 онд Цэргийн их сургуулийн харъяа Хилийн цэргийн сургууль
- 1999 онд Батлан хамгаалахын их сургуулийн Хилийн цэргийн сургууль
- 2001 онд Хилийн Цэргийн Дээд сургууль
- 2011 онд ДХИС-ийн Хилийн Албаны сургууль
- 2012 онд ХСИС-ийн Хилийн сургууль
- 2019 оноос ДХИС-ийн Хилийн албаны сургууль нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

БИДНИЙ БАХАРХАЛ

Манай сургуулийн сонсогч Монгол улсын баатар С.Лхагвадорж, Хилийн цэрэгт алба хааж эх орныхоо бүтээн байгуулалтад ялгуусан амжилт гаргаж, ард олондоо алдаршсан дэслэгч генерал Ж.Жамъян, гавъяат хуульч Б.Цэдэн-Иш, дархан аварга Б.Бат-Эрдэнэ нарын хөдөлмөрийн баатрууд, ардын жүжигчин С.Гэндэн, урлагийн гавъяат зүтгэлтэн Ш.Эрдэнэбат, гавъяат нисэгч Т.Сугар, гавъяат дасгалжуулагч Д.Дашжамц, шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн Ш.Арвай нарын хорь орчим гавъяат цолтнууд, Л.Намсрай, Б.Цэдэн-Иш, Ч.Сангишарав, Ш.Арвай, С.Гүржав, Я.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, М.Лхачинжав Т.Хүрэлбаатар, Ж.Бямбасүрэн нарын арав гаруй генералууд, Ш.Арвай, Т.Лхагвасүрэн, Б.Цэдэн-Иш, Ц.Энхжаргал, А.Осор, Ц.Пүрэв, А.Муратхан, Ч.Жазаг, Г.Дагважамц, П.Баттогтох, С.Гүржав, П.Даш, Б.Бат-Эрдэнэ, Ц.Ганболд, Д.Нямдорж, Б.Лхагва, Н.Наранжамц, И.Сэржхүү, Ж.Өвгөнбүргэд, В.Жавхланцогт, Ц.Батбаяр, Д.Дашдаваа, Д.Чойбаатар, Ё.Хадхүү нарын 40 гаруй эрдэмтэн докторууд, Д.Дорж, М.Банзрагч, Д.Жамъян, Ц.Уламбаяр, Ш.Доржбал нарын хорь орчим зохиолч, сэтгүүлчид төрснөөр бид бахархаж явдаг.






Тус сургуулийг улс орны ажуулгүй байдал, улсын хилийг хамгаалах их үйлс, бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмэр, эх оронч баатрууд, цэргийн олон шилдэг дарга нар, улс ардын аж ахуйн болон соёл урлаг, шинжлэх ухаан, спортын нэрт зүтгэлтнүүдийг төрүүлсэн гавъяаг үнэлэн Сайд нарын зөвлөлийн 1949 оны зарлигаар байлдааны туг олгож, 1979 онд МХЗЭ-ийн Төв хорооны "Цэргийн алдар" алтан медаль, 1980 онд НАХЯ-ны "Хүндэт чекист" тэмдэг, 1984 онд "Байлдааны гавъяаны одон"-гоор тус тус шагнасан байна.

ТОМООХОН ҮЙЛ ЯВДАЛ, БҮТЭЭЛЧ АЖЛУУД





Хил хамгаалах ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар тохижуулсан Хилийн сургуулийн лаборатори, танхимуудын нээлтийн үйл ажиллагааг 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Уг үйл ажиллагаанд Хууль сахиулахын их сургуулийн захирал, цагдаагийн хурандаа Ө.Энхтөр, Хил хамгаалах ерөнхий газрын дарга бөгөөд Хилийн цэргийн командлагч, хошууч генерал Ц.Сэргэлэн болон захирлын зөвлөл, даргын зөвлөлийн гишүүд оролцсон. Мөн Улаанбаатар хүрээний Хилийн 10 ангийн захирагч нар урилгаар оролцож, Их сургуулийн төв байр, Хилийн сургуулийн үйл ажиллагаатай /2017.11.17 өдөр/ танилцсан.






Сургалтын үйл ажиллагаанд ашиглах "Хийн буудлага"-ын лаборатори танхимыг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэн сургалтад ашиглаж эхэлсэн./2018.02.15 өдөр/






Хил хамгаалах ерөнхий газар, Хууль сахиулахын их сургууль хамтран ажиллах "Санамж бичиг" хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хамтран ажиллах санамж бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан.










Хил хамгаалах ерөнхий газраас Хилийн 0345 дугаар тусгай ангид шилжүүлсэн зэвсгийг 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан.





Хууль сахиулахын их сургуулийн "Марш-тусгай бэлтгэлийн аварга" шалгаруулах тэмцээнд тус сургуулийн албан хаагчдын баг тамирчид тэмцээнд амжилттай бэлтгэн оролцож, албан хаагчдын баг тэргүүн, онсогч бүрэлдэхүүний дэд байрт шалгарч, багийн дүнгээр тэргүүлсэн. /2018 оны 4 дүгээр сар/





Төгсөх дамжааны дамжааны онсогчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор "Их сорилго"-тактикийн сургуулийг жил бүрийн хавар Гүнжийн хоолой дахь хээрийн сургалт бэлтгэлийн төвд уламжлал болгон зохион байгуулдаг болсон.








Тус сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн бүрэлдэхүүн санаачилан, "Буудлагын иж бүрэн стандарт талбай" байгуулах ажлыг 2018 оны 06 дугаар сарын 08-наас 15-ны өдрүүдэд онсогчдын хамтаар гардан хийж гүйцэтгэсэн.






Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар, ахмад С.Лхагвадоржийн хөшөөг Хилийн албаны сургуулийн үүдэнд суурилуулж, нээлтийн үйл ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулж, С.Лхагвадоржийн мэндэлсэний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.





Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Холбооны Бүгд найрамдах Герман улсын Ханнс-Зайделийн сан хамтран зохион байгуулсан "Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлыг хамтран гүйцэтгэсэн.






Улсын Их Хурлын дэд дарга Я.Санжмятавын санаачлагаар Завхан аймгийн ерөнхий боловсролын 11,12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Бид Чингисийн үр сад, зөв тэмүүлэл, эх оронч манлайлал” сэдэвт цэрэг эх оронч сурагч хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг тус сургуулийн багш, сонсогчид амжилттай зохион байгуулж, Монгол Улсын ерөнхийлөгчийн тамгийн газар болон Их сургуулийн удирдлагад танилцуулсан. /2018.09.04-21/





Их сургуулиас зохион байгуулсан “Сонсогчийн жавхаа-2018” уралдаанд хилчин сонсогчид оролцож, Хууль сахиулахын их сургуулийн “Тэргүүний дамжаа”-аар 433 дугаар дамжаа, “Тэргүүний бага дарга”-аар бага дарга,түрүүч н.Батбаатар нар тус тус шалгарсан.





Дэлхийн болон олон улс, улсын чанартай тэмцээн, уралдаанд тус сургуулийн бие бүрэлдэхүүн амжилттай оролцож, тэргүүн байруудад шалгарсан.

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

СИСТЕМИЙН ОНОЛЫН ТУХАЙ

Д.Ганбаатар
Техникийн ухааны доктор (Ph.D), профессор

Системийн онолын үндэс, системийн шинжилгээний арга

Системийн онол нь техник, эдийн засгийн чиглэлийн нарийн төвөгтэй системүүдийн элемент хоорондын бүтцийн уялдаа холбоог тогтоох, тэдгээрийг үйлдлүүдийн дарааллаар нэгтгэх системийн шинжилгээ (хандлага)-ний арга зүйгээс бүрдэх танин мэдэхүйн шинжлэх ухааны онол ажээ. Тэрээр тухайн салбарын судалгааны мэдээллийг цуглуулан, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар уг судлагдаж байгаа асуудлынхаа хамгийн ашигтай зөв хувилбарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлонгаргажөгдгөөрөөонцгойач холбогдолтой бөгөөд шинжлэх ухааны туршилт, байгалийн шинжлэх ухааны статистикийн болон математикийн цогц аргуудад тулгуурладаг байна. Бидний бие организм, оюун ухаан гэхэд л биологи, нийгэм, эдийн засаг гэх мэтийн олон тооны системүүд бүхий нэгэн том сүлжээнд буй бие даасан дэд систем юм. Бид өөр хоорондоо харилцан холбоотой амьд болон амьгүй системүүдтэй (байгалийн болоод хүний гараар бүтээгдсэн) харилцан үйлчлэлцэж, амьдралаа төрөл бүрийн системүүдийн дунд өнгөрүүлдэг. Өөрөөр хэлбэл бид өөрсдөө тодорхой системд оршин байж, улмаар төрөл бүрийн системүүдтэй харилцан үйлчлэлцдэг гэсэн үг. Бид төрөл бүрийн системүүдээр хүрээлэгдэж, түүнд оршиж, бас түүний нэгээхэн хэсэг нь болж байдаг байна. Судлаач, нийтлэлч Р.Амарбаясгалангийн бичсэнээр "Энэ дэлхий өөрөө систем бөгөөд системүүдээр дүүрэн байх учир системийн онол нь зөвхөн эмч, математикч, физикчээр тогтохгүй бүх танин мэдэхүйн судлаач нарын мэдэх ёстой онол. Түүнчлэн хүний организм өөрөө системийн олон системүүдээс бүрэлдэн тогтдог. Жишээ нь: мэдрэлийн систем, зүрх судасны систем, яс үений систем гэх мэт. Системийн ерөнхий онол нь бодит байдлын механик загвараас зайлсхийн гоц үзэгдлүүдийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах .ухамсарлах, ойлгох гэсэн хичээл зүтгэлээс гарч иржээ. Австрийн нэрт биологич Людвиг фон Берталанфиг тодорхойлохдоо "Аливаа сонгодог шинжлэх ухаан нь аналитик, механик гэсэн нэг талт учир холбогдлын загвар юм" гэжээ.1956 онд Кеннеф Болдвин "Системийн ерөнхий онол нь эмх цэгцтэй, нягт нямбай мэдлэгийн бөөгнөрөл дээр тулгуурласан тодорхой салбар шинжлэх ухаан бөгөөд түүний эд эрхтэн, мах, цусыг өөртөө агуулж байдаг. Түүгээрээ системийн бүтэц, тогтолцоог бүрдүүлж өгөх зорилготой гэдэг утгаараа энэ нь бүх шинжлэх ухааны араг яс болдог" гэж тодорхойлсон юм. Системт сэтгэлгээ нь бүр эртээс үүсэлтэй бөгөөд Грекийн аугаа их сэтгэгч Аристотель (НТ 384-322) "Нэг бөөн юм гэдэг нь түүний

хэсгүүдийн нийлбэрээс их юм" гэсэн системийн үндсэн асуудлыг тодорхойлж байжээ. Ye үеийн аугаа их сэтгэгчид Жордана Бруно (1548-1600), Галило Галилей (1564-1630), Жоханез Кеплер (1571-1630), Рена Декарт (1596-1650) нар системийн онолыг дэвшүүлж, редакционизмийн сэтгэлгээ, метафизикийн таамаглалууд, аналитик аргууд парадигм, позтивизм баталгаанууд, термодинамикийн хуулиуд, харьцангуйн онол, квант механик онол гэх мэт эрдэмтдийн онол таамаглалууд нээлтүүд улам бүр эрчимтэй хэрэгжиж иржээ.

Системийн ерөнхий онолын олон улсын нийгэмлэг 1954 онд байгуулагджээ. Тус байгууллагын ерөнхийлөгч нь нийгмийн доторх янз бүрийн салбар шинжлэх ухааны ерөнхийлөгчдөөс сонгогдож байсан бөгөөд заримаас нь дурьдвал Кеннеф Болдвин, В.Росс Ашбай, Стафорд Бийр, Жеймс Миллер, Петр Чекланд, Русел Акофф, Вест Черман гэх мэт эрхмүүд байв" гэжээ.

Систем, түүний мөн чанарыг ойлгох үүднээс жишээ болгон хэд хэдэн системийг авч үзье. Наад зах нь бидний эргэн тойронд буй онгоц, автомашин, байшин барилга, компьютер, бугуйн цаг зэрэг бүхий л зүйлс нь системүүдийн жишээ болно. Үр тарианы аж ахуйг амьд (хүмүүс, үр тариа, мал амьтан, хорхой шавж, хогийн ургамал гэх мэт) ба амьд бус (машин, трактор, байшин, агуулах, хашаа саравч, усалгааны төхөөрөмж, химийн бордоо гэх мэт) дэд системүүдийг нэгтгэсэн систем гэж үзэж болох бол тракторыг гэрэлтүүлэг, удирдлага, хөдөлгүүр зэрэг олон тооны механик, цахилгаан болон электроникийн дэд системүүд бүхий тээврийн систем хэмээн үзэж болно. Тракторыг бүрэлдүүлэгч дэд системүүд өөр хоорондоо харилцан шүтэлцээтэйгээр холбогдон ажилласнаар трактор явах болон бусад үйлдлүүдийг гүйцэтгэх боломжтой болно. Цаашилбал тракторыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн системийн нэг хэсэг болгон үзэж болно. Өөр нэгэн жишээ авъя. Дунд сургууль нь амьд (багш, суралцагчид, ажилтнууд, тасалгааны цэцэгс гэх мэт) ба амьд бус (байшин барилга, анги танхим, самбар, шохой, хичээлийн бусад хэрэгсэл, үзүүлэн, компьютер, машин техник гэх мэт) дэд системүүдийг нэгтгэсэн боловсролын систем болно. Ийнхүү сургуулийг систем гэж үзвэл түүний заах аргын тэнхимүүд, удирдлага, санхүү, аж ахуй зэрэг нь түүний дэд системүүд болох ба нөгөө талаас авч үзвэл дунд сургууль маань өөрөө бага дунд боловсролын системийн дэд системүүдийн нэг болно. Сервер, компьютер, принтер, сүлжээний холболтууд, программ хангамжууд, хэрэглэгчид, үйлчилгээ зэрэг элементүүд нь компьютерын сүлжээний системийг бүрдүүлнэ гэх мэтчилэн олон тооны жишээг дурдаж болно.

Тэгвэл систем гэж юу вэ? Систем гэдэг нь нэгтгэх, нэг дор байрлуулах, хамтад нь авч үзэх, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгж хэсгүүдийн нийлбэр цогц гэсэн утга бүхий "systema" гэсэн грек үгнээс гаралтай үг ажээ. Энэ үгийг тайлбар толь бичгүүдэд дараах байдлаар тайлбарласан байдаг. "Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой буюу харилцан хамааралтай нэгжүүдийн цуглуулга. Харин дэд систем гэдэг нь ямар нэгэн системийн

хэсэг болж буй түүний доторх систем юм" хэмээн тайлбарласан байна. Систем гэсэн ойлголтыг бас хамгийн энгийнээр "Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой хэсгүүдийн олонлог" хэмээн бичсэн байх юм. Мөн "Нэгэн цогц байдлаар ажиллах зүйлс буюу хэсгүүдийн бүлэг" хэмээн тодорхойлсон байна. Дээрх тайлбарууд болон шинжлэх ухааны холбогдох заалтуудыг үндэслэн эрдэмтэд системийг дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал: "Тодорхой зорилгод хүрэхийн тулд хүрээлэн буй орчноосоо биет зүйл, өгөгдөл, мэдээллийг хүлээн авч боловсруулан, бүтээлч үр дүнг бий болгосноор өөрийн төлөв байдлаа илэрхийлдэг, тухайлсан зорилго ба үүрэг, бүтэц зохион байгуулалттай, зохицуулалтын дүрэм журам, зүй тогтол, шинж чанартай, зохих нөөцтэй, орчинтойгоо харилцан үйлчлэлцэлд оршдог цогц нэгдлийг систем гэнэ" гэжээ. Өөрөөр хэлбэл систем гэдэг нь нэг талаас байгууллагын болон түүний асуудлуудыг шийдвэрлэх арга зам, хэрэглэгдэх техникийн олонлог, нөгөө талаас тодорхой нэгж хэсгүүдийн хооронд бий болсон харилцаа холбоо юм. Мөн системийн оршин байх гол үндэс нь систем бүр нэг буюу түүнээс дээш зорилгод хүрэхээр загварчлагдсан байдагт оршино. Энд дурдагдсан нэгж хэсэг, харилцан холбоо, шийдвэрлэх арга зам буюу хэрэглэгдэх техникийн олонлог гэсэн ойлголтуудыг системийг хөгжүүлэх олон арга зүйн тусламжтайгаар тодорхойлж системд шинжилгээ, загварчилгаа хийж байгаа билээ. Системийг хөгжүүлэх арга зүйн ач холбогдол, түүгээр хийгдэх үйлдлүүд нь тодорхой боловч ямар аргачлал, хэрэгсэл ашиглан тавигдсан бодлогыг хэрхэн яаж шийдэж байна вэ гэдэг нь л чухал асуудал болон тавигдаж байгаа ажээ. Системүүдийг байгалийн болон хүний гараар бүтээгдсэн (загварчлагдсан) хэмээн хувааж үздэг байна. Хүний гараар бүтээгдсэн системүүд гол төлөв тодорхой зорилго, багц зорилтуудтай байдаг бол байгалийн системүүд нь тодорхой зорилгогүй хэр нь харьцангуй тогтвортой, уян хатан бөгөөд үр ашигтай байдаг. Байгалийн төрөл бүрийн системүүд байна. Систем бүр бие биеэсээ хамаарсан, уялдаа холбоотой элементүүд (дэд системүүд)-ээс бүрдэн оршин тогтнож, өөрийг нь хүрээлэн буй орчноос өгөгдөл мэдээлэл хүлээн авч, өөрийн төлөв байдлыг илэрхийлдэг аж. Системийг хүрээлж буй орчныг нь системийн орчин гэнэ. Аливаа систем нь орчинтойгоо байнга харилцан үйлчлэлцэж байдаг төдийгүй үйлчлэх орчноосоо хамааран байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Системийг орчноосоо хамаарах хамаарлаар нь нээлттэй ба хаалттай систем гэж хуваан үздэг. Нээлттэй систем нь гол төлөв өөрийн орчны зарим нэгжүүдтэй харилцан үйлчлэлцдэг бол хаалттай систем нь орчноосоо тусгаарлагдсан байдаг. Систем бүр өөрийн шинж чанартай байдаг бөгөөд оршин тогтнох хугацааны хувьд ч харилцан адилгүй байх ажээ. Бүх системүүд хүрээлэн буй орчноосоо ямар нэгэн биет зүйл, өгөгдөл, мэдээлэл хүлээн авч боловсруулдаг. Иймд системийг шалгахдаа эн түрүүнд юу өөрчлөгдсөн болон ямар боловсруулалт хийгдсэнийг авч үзэх хэрэгтэй. Юу ч өөрчлөгдөөгүй байвал ямар ч боловсруулалт хийгдээгүй байна гэсэн үг.

Тухайн систем нь тавигдсан

зорилгодоо хүрэх гарцыг бий болгох үүднээс хүрээлэн буй орчноосоо авч буй хэрэгцээт материаллаг зүйл, өгөгдөл, мэдээллийг системийн *оролт*, харин системийн боловсруулалтын үр дүн болон түүний төлөв байдлын илэрхийллийг системийн *гаралт* гэж үздэг байна. Системийн гаралтыг зөвхөн тодорхой боловсруулалтын үр дүнд бий болсон мэдээлэл, материаллаг зүйл хэмээн үзэж болохгүй. Үүнд системийн өөрийнх нь төлөв байдлын илэрхийлэл мөн багтана. Системийн оролт болон гаралтууд нь өөр хоорондоо салшгүй хамааралтай. Системийн гаралт нь оролтоосоо шууд хамаардаг бол оролт нь гаралтын шинж чанар, бодит байдлыг тодорхойлдог.

Бадарч Д., Мөнххүж нарын бичсэн "Системийн сэтгэлгээ" номонд системийн сэтгэлгээний хялбаршуулсан схемийг дараах байдлаар үзүүлжээ (1.1-р зураг).


Системийн сэтгэлгээний хялбаршуулсан схем




1.1-р зураг. Системийн сэтгэлгээний хялбаршуулсан загвар

Тэрээр бичихдээ "Системийн сэтгэлгээ (system thinking, системное мышление) нь судалж буй системийн бүрэн бүтэн байдал, харилцан уялдаа, үйлчлэлийг тал бүрээс нь системийн хандлагын үндсэн дээр авч үздэг сэтгэлгээний арга юм.

"Прикладной системный анализ" номонд "Системийн хандлага (system approach, системный подход) нь системийг судлах шинжлэх ухааны танин мэдэхүйн арга, хэрэгсэл. Аливаа үзэгдэл бие даасан байх авч өөр бусадтай харилцан хамааралтай бөгөөд өөрийн онцлог орчин бүхий нэгэн бүхэллэгийг үүсгэн хөдөлгөөнт шинжтэй байна гэдгийг үндэс болгодог" гэжээ. Системийн бүтцийн төрөл, хэлбэрийн график дүрслэлийг В.Н.Волковын "Теория систем и системный анализ" номонд "...тор, торлог бүтэц, иерарх бүтэц (мод, матриц, олон түвшинт)" гэж нэрлэсэн байна (1.2-р зураг).




1.2.а-р зураг. Системийн бүтцийн график дүрслэлийн тор, торлог бүтэц



1 2

1.2.б-р зураг. Системийн бүтцийн график дүрслэлийн иерархи *бүтэц (1-мод, 2-матриц хэлбэр)*



1.2.в-р зураг. Системийн бүтцийн график дүрслэлийн иерархи *бүтэц (олон түвшинт)*

Системийг төлөв байдал, зүй тогтлоос нь хамааруулан нээлттэй ба хаалттай, статик, динамик гэсэн үндсэн төрлүүдэд хувааж үздэг. Өмнө өгүүлсэн гадаад орчинтойгоо харилцан үйлчлэлцэж буй бүх системүүд нээлттэй систем болно. Ийм төрлийн системийн оршин тогтнох нь гадаад орчноосоо шууд болон шууд бусаар, эсвэл тодорхой хэмжээгээр хамаардаг. Харин гадаад орчноос хамаардаггүй буюу гадаад орчин нь тухайн системд ямар нэгэн нөлөө үзүүлж чадахгүй байвал тухайн системийг хаалттай систем гэнэ. Амьдрал дээр нээлттэй болон хаалттай системийн шинжийг агуулсан холимог шинжтэй системүүд ч түгээмэл байдаг байна. Системийн бүрэлдэхүүн хэсгүүд нь тогтвортой, өөрчлөгддөггүй системийг статик систем гэнэ. Харин системийн бүрэлдэхүүн хэсгүүд нь цаг хугацааны

хүчин нөлөөллөөр өөрчлөгдөж байвал динамик систем болно.

Системийн үндсэн агуулга нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Системийг бүрэлдүүлэгч үндсэн элементүүд нь өөр хоорондоо уялдаа холбоотой, бие биеэсээ шууд болон шууд бусаар хамааралтай байна. Өөр хоорондоо ямар ч харилцан холбоогүй, хамааралгүй, бие даасан элементүүд системийг бүрэлдүүлж чадахгүй. Иймээс аливаа системийг судлахад түүнийг бүрэлдүүлэгч элементүүд, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг тодорхойлох, шинжлэх нь чухал. Үүнд:

- Системийг бүхэлд нь авч үзэх шаардлагатай. Системийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг өөр хооронд нь салангид бие даасан тусдаа байдлаар авч үзэхэд тухайн системийн бүхэл байдал алдагдаж байвал түүнийг бүрэлдүүлэгч хэсгүүдэд хуваан үзэх шаардлагагүй.

- Систем нь чиглэсэн зорилготой байна. Зорилго ба түүний биелэлт нь системийн гаралтаар тодорхойлогдоно.

- Систем нь хүрээлэн буй орчноосоо биет зүйл, өгөгдөл, мэдээлэл хүлээн авах оролт ба өөрийн төлөв байдлаа илэрхийлсэн гаралттай байна. Систем нь харилцан үйлчлэлцэж байгаа бусад системүүдэд шаардагдах хэд хэдэн гаралтуудтай, мөн хэд хэдэн оролтуудтай байж болно. Тухайлбал: маркетингийн системийн гаралт нь үйлдвэрлэлийн системийн оролт, үйлдвэрлэлийн системийн гаралт нь маркетингийн системийн оролт болж байх жишээтэй.

- Систем өөрийгөө бүрэлдүүлж буй өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж, бие биедээ нөлөөлж байдаг элементүүдийг тохируулан зохицуулах өөрийн дүрэм, журам, зүй тогтолтой байж зорилгоо биелүүлдэг.

- Системүүд нь өөрийгөө бүрэлдүүлэгч дэд системүүдийг агуулдаг. Том системд жижиг системүүд агуулагддаг. Эдгээр жижиг системүүд нь тухайн системийн хувьд дэд системүүд болно.

- Нийлмэл системийн хувьд түүний бүрэлдэхүүнд буй дэд хэсэг буюу дэд систем тус бүр тодорхой үүрэгтэйгээр оролцож, тодорхой бодлогыг биелүүлж, бусадтайгаа харилцан хамааралтай оршдог.

- Системийн эцсийн зорилгод цорын ганц замаар бус, хэд хэдэн замаар хүрч болно. Иймээс зорилгодоо хүрэх боломжит арга зам, шийдлүүдийг зөв тодорхойлж, улмаар тэдгээрээс хамгийн оновчтой арга замыг сонгох нь юу юунаас чухал.

Системийн шинжилгээг тооцоолон бодох техникийн орчин үеийн хэрэгслүүдийг ашиглан явуулна. Системийн судалгааны үр дүн нь хөгжлийн төлөвлөгөө, техникийн систем, бүс нутаг, арилжааны бүтэц гэх мэт маш тодорхой хувилбаруудаас зөв сонголт хийхэд оршино. Тиймээс системийн шинжилгээний эх сурвалжууд болон түүний арга зүйн үзэл баримтлалууд нь үйл ажиллагааны онол, удирдлагын ерөнхий онол, системийн хандлагууд гэх мэт шийдвэр гаргахад тулгардаг асуудлуудыг судалдаг бие даасан шинжлэх ухаан системийн онолын салбар болно. Системийн онолын үүсэл хөгжлийн талаар эрдэмтэд өөр өөрсдийн өнцгөөс тухайн шинжлэх ухааны чиглэлээр нэвтэрсэн байдлаар тайлбарлах нь бий. Зарим эрдэмтэн судлаачдын

үзэж байгаагаар системийн задлан шинжлэх арга (Системный анализ. System analysis)-ыг XX зууны 30-аад оны үед байгалийн шинжлэх ухааны төлөөлөгчид боловсруулсан бөгөөд нийгмийн шинжлэх ухаанд харьцангуй хожуу хэрэглэж эхэлсэн- гэх нь бий. Энэ аргыг нийгмийн шинжлэх ухаанд нэвтрүүлэхэд физиологич У.Кэннон, биологич Л.Берталанфи, нийгэм судлаач, эдийн засагч Т.Парсонс, Ж.Хоманс, Р.Мертон нар томоохон хувь нэмрийг оруулсан гэж үздэг ажээ. Үүний үр дүнд тэд нийгмийг судлах арга зүйн чухал хандлага болсон бүтэц-үүргийн задлан шинжилгээний аргыг боловсруулсан байна. Системийн задлан шинжилгээний үүднээс авч үзвэл хүмүүсийн аливаа нэгдлийг нэлээд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй харьцангуй тогтмол шинжтэй нийтлэг асуудал гэж үзэж болох юм байна. Энэ нь хоорондоо харилцан холбоонд оршдог, задлан шинжилж, салган хуваарилж болдог элементүүдийн нэгдлээс бүрддэг онцлогтой. Ийм системүүд нэг нь нөгөөгөөс ялгардаг хил хязгаартай байдгийн хамт тодорхой тэнцвэрт байдлыг хадгалдаг онцлог шинж чанартай аж. Нийтлэлч khash-erdene-ийн бичсэнээр: "Системийн шинжилгээний эхлэлийг 1890 он буюу Фредрик Тейлорын (Frederick Winslow Taylor 1856–1915) зарчимтай холбон үздэг. Энэ зарчмын хандлага нь хүн хүчийг үр ашигтай зарцуулахад чиглэгдсэн байна. Гэхдээ Тейлоризмд дутагдалтай талууд байсан ба зөвхөн хүний физиологийн чадавхыг чухалд үзэж, ажлын сахилга батыг орхигдуулсан, удирдлагын шийдвэрийн ач холбогдлыг орхигдуулсан хэмээн зарим эрдэмтэд үздэг юм байна. Дэлхийн I дайны нөлөөгөөр хөдөлмөр хөнгөвчлөх, автоматжуулалт гэсэн ойлголт бий болжээ. Үүний үр дүнд барааг ялангуяа цэргийн хэрэгцээний зэвсэг, галт хэрэгсэл, эд материалыг түргэн, хямд өртөгтэйгөөр үйлдвэрлэх болсон байна. Энэ байдал 1950-иад он хүртэл үргэлжилжээ.

Оросын судлаач Оразбаев Б.Б., Курмангазиева Л.Т., Коданова Ш.К. нарын "Системийн шинжилгээний онол ба арга зүй" бүтээлд дурдсанаар, "Системийн шинжилгээ" гэдэг нэр томьёо нь цэргийн удирдлага, түүнд тавигдах зорилтуудыг шийдвэрлэх асуудалтай холбоотойгоор АНУ-ын RAND корпорацаас боловсруулан нээж анх 1948 онд гаргаж тавьсан ажээ. Ийнхүү "Систем" гэдэг утгаар боловсрогдож гарч ирсэн анхны бүтээл нь B-58 дуунаас хурдан бөмбөгдөгч онгоцны зураг төсөл байсан. Системийн шинжилгээний тухай анхны ном 1956 онд гарсан байна. Уг номыг RAND корпорац хэвлэн гаргасан ба зохиогчид нь Америкийн эрдэмтэд болох Кан, Манн нар байсан аж. С.Оптнерын "Бизнесийн болон аж үйлдвэрлэлийн асуудлуудын системийн шинжилгээ" (1967 он) номын орчуулга нийтийн хүртээл болсны дараа л системийн шинжилгээний ном бүтээлүүд ОХУ-д өргөн тархаж эхэлсэн байна. Системийн шинжилгээ нь их эртний үндэслэлтэй ч нэг бүрчилсэн болон ерөнхий судалгааны арга хэрэгслүүдийг өөртөө агуулсан, бүх л сэдэвчилсэн талбарт өргөн хэрэглэгддэг харьцангуй залуу шинжлэх ухаан ажээ. Энэхүү шинжлэх ухаан нь судалгааны объектуудын шинэ холбоо хамаарал болон харилцааг танин мэдэх явцдаа тухайн

объектуудын судалгааны мөн чанараас үл хамаарах системийн хандлагын зарчмыг хэрэгжүүлдгээрээ онцлог юм байна. Системийн шинжилгээний судалгаа болон практик ашиглалт нь хүний сэтгэлгээний үйл ажиллагаанд тодорхой шинэлэг ойлголтуудыг бий болгож, мэдлэгийн бүхий л салбарт шийдвэр гаргах нэгдсэн алгоритмуудыг боловсруулан гаргах боломжийг олгодог ажээ. Чухам энэ үед л хүний сэтгэлгээ нь логик дараалалтай байх, оновчтой байх, системтэй байх чадварыг эзэмшиж, шинээр тавигдах зорилтуудыг шийдвэрлэх чадвар нь дээшлэн, танин мэдэхүйн шинэ салбаруудад ажиллах чадвартай болж дасан зохицдог байх юм. Системийн шинжилгээ нь мөн хүрээлэн буй ертөнц болон түүний дотор өрнөж буй үйл явдлуудыг бодитоор танин мэдэхэд тусалдаг. Түүхийн үүднээс авч үзвэл системийн шинжилгээ нь кибернетикийн чиглэл, тооцоолон бодох төхөөрөмжийн оновчтой математик программчлал, нийгмийн хөгжлийн онол, математик статистик тоглолтын онол мэтийн судалгааны үйл ажиллагааны залгамжлагч нь юм. Нийгэм эдийн засаг, цэрэг-техник, захиргаа-удирдлага, үйлдвэрлэлийн болон бусад томоохон хэмжээний асуудлуудыг шийдвэрлэхэд ердийн үйл ажиллагаа үйлдвэрлэлийн аргууд нь төдийлөн үр дүнд хүрэхгүй байсан учир шалтгааны улмаас системийн шинжилгээний арга үүсэн бий болжээ. Өнөөгийн байдлаар системийн шинжилгээг системийн судалгаануудын чиглэлээс хамгийн бүтээлч нь хэмээн хүлээн зөвшөөрч байгаа юм байна.

ОХУ-ын Санкт-Петербург хотын Мэдээллийн технологи, механик-оптикийн их сургуулийн өөр нэг судлаач Горлушкина Н.Н. "Системийн шинжилгээ ба систем мэдээллийн процессуудын загварчлал" бүтээлдээ "Системийн шинжилгээ нь нарийн утгаараа – улс төр, цэрэг, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн шинжтэй нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэх шийдлүүдийн арга зүйн нийлбэр багц юм... Өргөн утгаараа "системийн шинжилгээ" гэдэг нэр томьёо нь зарим тохиолдолд, тухайлбал англи хэл дээр бичигдсэн ном бүтээлүүдэд системийн хандлагатай ижил утгаар хэрэглэгддэг" гэжээ. Түүний үзэж байгаагаар системийн ерөнхий онол болон системийн хандлагыг системийн шинжилгээний үндэс гэж үздэг байна. Тэдгээрийн үндсэн дээр ерөнхий суурь төсөөлөл болон урьдчилсан нөхцөлүүд үүсдэг аж. Системийн шинжилгээ нь орчин үеийн арга зүйн хавсарга чиглэлүүдийн үндсэн шинж чанарыг өөртөө агуулдаг байна. Тэрээр системийн шинжилгээ нь өөрийн өвөрмөц нарийн арга зүй, болон тодорхой журам, зарчмуудтай хэмээн дурдаад, "Системийн шинжилгээний үндсэн зарчмууд нь:

– аливаа асуудлыг бүхэлд нь нэгдсэн системээр нь авч үзэн, тодорхой нэг бүрчилсэн шийдвэрийг асуудал тус бүрийн бүх үр дүнгээр болон харилцан холбоотойгоор нээж гаргах;

– зорилгодоо хүрэхэд шаардлагатай өөр боломжит арга замуудыг судлан олж авч хэрэглэх, дүгнэн шинжлэх;

– хөтөлбөрийн нарийвчлалыг хийх үед уг хөтөлбөрийг бүрдүүлэгч хэсгүүд, тэдгээрийн зорилго болон аргууд нь нийт хөтөлбөртэй зөрчилдөх ёсгүй. Системтэй байх зарчим нь судлагдаж

буй объектын шинж чанараас үл хамаарсан системийн шинжилгээний үндсэн суурь нөхцөл юм" гэжээ.

1960-аад оноос системийн шинжилгээ хийх эрин үе эхэлсэн гэж үздэг. Системийн шинжээч нар нь энэ үед зэвсэг галт хэрэгсэл, материал техникийн системд үнэ, ашгийн шинжилгээ хийж бараа материал, хөрөнгийн гүйлгээг хяналтын тооцоолон бодох техник хэрэгслийг ашиглан зэр зэвсгийг хаана хэчнээн хэмжээгээр үйлдвэрлэх, хадгалагдаж байгааг тогтоодог болж эхэлсэн байна. Харин компьютер бий болсноор асуудлыг шийдэх аргачилалд эрс шинэчилэлт, эргэлт гарсан бөгөөд цахим техник хэрэгсэл, компьютерын тусламжтайгаар уг асуудлыг шийдэх хялбар төхөм арга замыг хайх болжээ. Ингэж системийн шинжээчдийн ажлын хандлагад шинэ нээлт өөрчлөлт бий болсон юм. Компьютерын ухааны салбар харьцангуй залуу салбар боловч асар хурдацтай хөгжиж байгаатай холбогдуулж өнөөгийн түвшинд системийг хөгжүүлэх нэлээд хэдэн аргачлалууд бий болсон ба зарим аргачлалууд нь хэд хэдэн шат дамжсан нэлээд боловсронгуй гэгдэх аргачлалууд байгаа аж.

Системийн шинжилгээний аргыг ойлгож мэдэхийн тулд системийн онолын тухай гүнзгий мэдлэгтэй байх шаардлагатай нь ойлгомжтой. Учир нь системийн шинжилгээ, системийн хандлага зэрэг нь системийн онолыг практикт хэрэгжүүлэх үндсэн арга нь юм. Аливаа асуудлыг шийдэхэд системийн шинжилгээ, системийн хандлагыг ашигласнаар үр дүнд нь системийн онол хэрэгжих зүй тогтолтой аж. Улс төр, нийгмийн тогтолцоо, цэрэг түүний хангалтын систем, улсын хил хамгаалалтын систем, боловсролын систем, эдийн засгийн тогтолцоо, мэдээллийн систем, банкны систем, санхүүгийн систем, нарны систем гэх мэтээр систем буюу *тогтолцоо* (цаашид систем гэх) гэдэг үгтэй бид өдөр тутам тааралддаг. Тэгэхээр систем гэдэг үгийг агуулгын хувьд дээр дурдсанчлан дэлхий дээрх амьдралыг өөр хоорондоо харилцан холбогдсон байгалийн болон хүний гараар бүтээгдсэн төрөл бүрийн системүүдийг нэгтгэсэн нэгэн нийлмэл аварга том сүлжээ хэмээх утгаар нь ойлгож болохоор байна.

Системийн шинжилгээний (системный анализ, system analysis) зорилго ба зарчим

Системийн шинжилгээний зорилго нь системийн хандлагад үндэслэн томоохон асуудлуудыг шийдвэрлэх үед хийгдэх үйл ажиллагааны дарааллыг зохицуулахад оршино. Нөгөө талаар системийн шинжилгээ нь тодорхой хугацааны зааг дахь тухайн системийн хүссэн төлөв байдал буюу түүний үйл ажиллагаагаар бий болгож болох үр дүн юм. Зорилгыг биелүүлэхийн тулд системүүдийг бий болгож хөгжүүлдэг. Системийн шинжилгээгээр асуудлыг шийдвэрлэх ажиллагаа нь уг системийн шинж чанарыг хадгалах эсвэл сайжруулах үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Системийн шинжилгээний арга нь асуудлыг шийдвэрлэх сонголтод хувилбаруудыг санал болгох, хувилбар тус бүрийн тодорхойгүй байдлын цар хүрээг тодорхойлох, хувилбаруудыг үр ашгийн үзүүлэлтээр нь харьцуулахад чиглэгдэнэ. Системийн шинжилгээг тодорхойлдог зарчим бол түүний

зорилго нь юм. Энэхүү зарчмын дагуу систем өмнөө тавигдсан зорилгын дагуу оршин тогтнож, хөгждөг. Зорилгын нэгдмэл байдал нь системийг тодорхойлж, хүрээлж, нэг бүхэл бүтэн үйл ажиллагаа болгон нэгтгэдэг. Системийн онцлог байдлаас үл хамааран системийн зорилго нь үргэлж тогтвортой байдал, хөгжил гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Тогтворжуулалтын зорилго нь нэг бол үнэ цэнтэй нөөц (жишээлбэл: мөнгө, эрчим хүч, мэдээлэл, тоног төхөөрөмж, ажиллах хүч)-ийн хэрэглээний болон үйлдвэрлэлийн түвшнийг, эсвэл нөхцөл байдал (жишээлбэл: хүмүүсийн тав тух, аюулгүй байдал, тогтвортой ажил эрхлэлт)-ын түвшнийг хадгалахад чиглэгдсэн болно.

Хөгжлийн зорилго нь тухайн системд байхгүй нөөцийг олж авах, эсвэл хүрэхийг хүссэн нөхцөл байдалд хүргэхэд чиглэгддэг. Үүнээс гадна, системийн үйл ажиллагааны зорилгуудыг *гүйцэтгэлийн хугацаагаар* хянаж байх ёстой. Энэ нь системийн хүрэхийг хүссэн эцсийн ерөнхий үр дүнг илүү богино хугацаанд шийдэгдэж болох тодорхой зорилтууд болгон хуваах ёстой ба тэдгээрийг шийдэх тогтоосон хугацааг тодорхойлох шаардлагатай. Хэрэв зорилгыг ерөнхийд нь амин чухал болон сонголтод гэсэн хоёр ангилалд хуваасан бол нөөц хуваарилах зорилтыг илүү хялбарчилж болно. Амин чухал зорилтуудыг зайлшгүй биелүүлэх ёстой, тиймээс нөөцөөр хангах хэрэгтэй гэж үздэг. Энэ нь нөөцийн хуваарилалтын үр дүнг тодорхойлдог багц үзүүлэлтүүдээс эдгээр зорилтуудад хүрч болох түвшнийг харуулсан үзүүлэлтүүдийг хасах боломжийг олгодог. Зорилгоо буруу сонгосон тохиолдолд цаашид зорилгодоо хүрэх арга замаа тодорхойлоход буруу хандлага тогтох болно. Зорилготоо хүрэх явдлыг ямар нэгэн туйлын үнэмлэхүй зүйл гэж ойлгож болохгүй, үйл ажиллагааг цаашид сайжруулсаар байх шаардлагатай байдаг. Зорилгоо биелүүлэх явдал нь байнга динамик хөдөлгөөнд байж, шаардлагатай төгс төгөлдөр байдалд ойртох хурдаар хэмжигддэг. Дараах хоёр нөхцөлийг хангасан тохиолдолд зорилгын зарчим үр дүнтэй байх болно:

- зорилгыг томьёолохдоо тухайн зорилгод хүрэх түвшнийг тоон үнэлгээгээр үнэлж болдог байхаар томьёолох;
- системд тухайн зорилгод хүрэх түвшнийг үнэлэх боломжтой механизм байх ёстой.

Системийн шинжилгээ нь дараах ерөнхий зарчимд тулгуурлана. Тухайлбал:

- дедуктив дарааллын зарчим - системийг үе шаттайгаар дараалуулан авч үзэх, хүрээлэн буй орчноос болон бүхлийн хэсгүүдийн холбоос хүртэл бүхэлтэй холбогдсон холбоосоос бүрдэнэ;
- нэгтгэн үзэх зарчим - систем бүр нь аливаа системийн дэд системүүдийг тус тусад нь авч үзсэн тохиолдолд ч салшгүй бүхэл байх ёстой;
- системийг авч үзэх ажиллагааны нөөц болон зорилгуудыг уялдуулан зохицуулах системийг чухалчлах зарчим;
- үл зөрчилдөх зарчим - бүхэл болон хэсгүүдийн хооронд бүхлийн зорилго, хэсгийн зорилготой зөрчилдөхөд хүргэх зөрчил байхгүй байх ёстой.

Системийн шинжилгээ, түүний хэрэглээ

Системийн шинжилгээний аргуудыг хэрэглэх хүрээ маш өргөн цар хүрээтэй байна. Бүх асуудлыг шийдвэрлэхэд системийн шинжилгээний аргуудыг хэрэглэж болдог ангилал байдаг ба уг ангиллыг гурав хуваадаг:

- маш сайн тодорхойлогдсон томоохон хамаарлууд бүхий сайн бүтэцлэгдсэн (well-structured), эсвэл тоогоор томьёологдсон асуудлууд;

- хамгийн чухал нөөц, шинж тэмдэг болон шинж чанаруудын тайлбар, огт тодорхойгүй тоон хамаарлууд бүхий бүтэцлэгдээгүй (unstructured), эсвэл чанартай илэрхийлэгдсэн асуудлууд;

- чанартай элементүүд болон давамгайлах хандлагатай бага танигдсан бөгөөд тодорхой бус талуудын аль алиныг нь агуулсан сул бүтэцлэгдсэн (ill-structured), эсвэл холимог асуудлууд байж болно.

Сайн бүтэцлэгдсэн тоон илэрхийллээр илэрхийлэгдсэн асуудлуудыг шийдвэрлэхийн тулд зохих математик загварыг бий болгох зорилготой үйл ажиллагаанд судалгааны арга зүйг ашигладаг (жишээ нь: шугаман, шугаман бус, динамик програмчлал, нийтийн үйлчилгээний онолын, тоглоомын онол гэх мэт асуудлууд) ба зорилго чиглэлтэй үйлдлүүдийг удирдах оновчтой удирдлагын стратегийг хайж олох аргуудыг хэрэглэх нь чухал.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд юуны түрүүнд шийдвэр гаргах явцад хатуу чанд тоон үнэлгээ хийх боломжгүй хүчин зүйлүүд байгаагаас болж үүссэн тодорхойгүй нөхцөл байдлуудад сонголт хийх хэрэгтэй болдог тул системийн шинжилгээний аргуудыг хэрэглэх шаардлагатай болдог. Энэ тохиолдолд бүх арга, ажиллагаа нь асуудлуудыг шийдвэрлэх сонголтод хувилбаруудыг санал болгох, хувилбар тус бүр дэх тодорхой бус байдлын цар хүрээг тодорхойлох, үр ашгийн аливаа нэгэн шалгуур үзүүлэлтийн хувилбаруудыг харьцуулахад чиглэгдсэн байдаг. Мэргэжилтнүүд зөвхөн шийдлийн хувилбаруудыг бэлтгэдэг эсвэл санал болгодог. Харин шийдвэр гаргах эрх нь харгалзах албан тушаалтан (эсвэл байгууллага)-ынх байх болно.

Сул бүтэцлэгдсэн болон бүтэцлэгдээгүй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд шийдвэр гаргах ажиллагааг дэмжих системийг ашигладаг. Ийм нарийн төвөгтэй асуудлуудыг шийдэх технологийг дараах журмаар тодорхойлж болно. Үүнд:

1. асуудалтай нөхцөл байдлыг томьёолох;
2. зорилгыг тодорхойлох;
3. зорилгод хүрэх шалгууруудыг тодорхойлох;
4. шийдлийн үндэслэлд зориулсан загваруудыг бий болгох;
5. шийдлийн хамгийн оновчтой (зөвшөөрөгдсөн) хувилбарыг хайх;
6. шийдвэрийг зөвшилцөх;
7. шийдлийг хэрэгжүүлэхэд бэлтгэх;
8. шийдвэрийг баталгаажуулах;
9. шийдлийг хэрэгжүүлэх явцыг удирдах;
10. шийдлийн үр ашгийг шалгах.

Системийн шинжилгээний үндсэн үйл ажиллагаа нь уг шийдлийг хэрэгжүүлэх явцад илэрч болзошгүй бодит нөхцөл байдлуудын бүх хүчин зүйлүүд болон харилцан хамаарлыг тусгасан ерөнхий загварыг бий болгох

явдал юм. Үйлдлүүдийн сонголтод хувилбаруудын аль нэгийг хэрэглэхэд гарсан үр дүн нь хүссэн үр дүнд ойртож чадсан эсэхийг тогтоох, хувилбар тус бүрийн нөөцийн харьцуулсан зардлууд болон тухайн загвар гаднын нөлөөлөлд автах эрсдэл хэр мэдрэг байгаа зэргийг тодруулах зорилгоор бий болгосон загварыг судалдаг.

Судалгаа нь удирдлагатай холбоотой орчин үеийн техникийн болон эдийн засгийн үйл ажиллагаанд өргөнөөр хэрэглэгддэг хэрэглээний математикийн хэд хэдэн чиглэл болон аргуудад тулгуурлана. Үүнд:

- удирдлагын онолын системүүдийн шинжилгээний болон нэгтгэлийн аргууд;
- шинжилгээний үнэлгээний арга;
- шийдвэрлэх чиглэлийг тодорхойлох арга;
- дарааллын онол гэх мэт.

Системийн шинжилгээний техникийн үндэс нь орчин үеийн тооцоолон бодох машинууд цахим техник хэрэгсэл болон тэдгээрт үндэслэн бүтээгдсэн мэдээллийн системүүд. Системийн шинжилгээг ашиглан асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэгддэг арга зүйн хэрэгслүүдийг зөвхөн нэг зорилготой байна уу, эсвэл хэд хэдэн багц зорилготой байна уу, шийдвэрийг нэг этгээд гаргаж байна уу, эсвэл хэд хэдэн этгээд гаргаж байна уу гэх мэтийн олон хүчин зүйлүүдээс хамааруулан тодорхойлдог. Хангалттай тодорхой илэрхийлэгдсэн, хүрэх түвшнийг нь нэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн тодорхойлж болох тийм ганцхан зорилготой байх нөхцөлд математик програмчилалын аргуудыг ашигладаг байна. Хэрэв зорилгод хүрэх түвшнийг хэд хэдэн шалгуурын үндсэн дээр үнэлэх ёстой бол шалгууруудыг дараалалд оруулж, тэдгээрийн ач холбогдлыг тодорхойлоход ашигладаг ашигтай байдлын онолын төхөөрөмжийг хэрэглэнэ. Үйл явдлын өрнөл нь тус бүр өөр өөрийн зорилготой, өөр өөрийн шийдвэрээ гаргадаг хэд хэдэн этгээдүүд эсвэл системүүдийн харилцан үйлчлэлээр тодорхойлогдохоор байгаа тохиолдолд тоглоомын онолыг ашигладаг аж. Системийн шинжилгээнд ашиглагддаг асуудлуудыг загварчлах болон шийдвэрлэх аргуудын цар хүрээ байнга өргөжин тэлсээр иржээ. Тэдгээр үйл ажиллагаанд удирдлагын практик асуудлуудыг шийдвэрлэхэд шинжлэх ухааны аргуудыг хэрэглэдэг бөгөөд энэ нь зайлшгүй шаардлагатай субьектив агшнуудыг хасалгүйгээр шийдвэр гаргах үйл явцыг оновчтой болгох зорилготой юм.

Системийн шинжилгээний логик элементүүд ба тэдгээрийн харилцан хамаарал

Системийн шинжилгээний онцлог шинж чанар нь аливаа асуудлын шинжилгээнд бараг байнга байдаг стандарт хэсгүүдийн тодорхой төрлүүд системийн шинжилгээнд байдагт оршино. Асуудлын бүтэц болон шалтгаан-үр дагаврын харилцан холбоогоор тодорхойлогддог тодорхой дараалал бүхий эдгээр шинж чанаруудын хослол нь асуудлыг *системтэйгээр шийдэх* боломжийг олгодог. *Системийн шинжилгээний* үндсэн элементүүд нь логик дарааллыг баримтлан *шинжилгээ* гэх нэгдсэн нэг "барилга"-ыг барьж байгуулахад шаардлагатай, зорилго – зорилгод хүрэх арга хэрэгсэл – шаардагдах нөөц,

эх үүсвэр гэсэн "тоосго"-нуудыг бий болгодог. Үүнээс гадна энэ логик гинжин хэлхээний зорилтуудыг шийдвэрлэхэд янз бүрийн загварууд болон шалгууруудыг өргөнөөр хэрэглэнэ. Ихэнх тохиолдолд аливаа нэгэн асуудлыг *шийдвэрлэхэд системийн шинжилгээний* логик элементүүдийг зөв ашиглах ур чадвар нь хүссэн үр дүнд хүрэх боломжийг урьдчилан тодорхойлж өгдөг. Тухайлбал: "Эрдэм шинжилгээ-судалгааны болон туршилт-зохион бүтээлтийн ажил амжилтгүй болох гол шалтгаан бол тодорхой томьёолсон зорилгогүй байх (26%), ажлын хөтөлбөрийн боловсруулалт болон түүнд тавих хяналт хангалтгүй байх (35%), нөөцийн хуваарилалт үндэслэлгүй, эдийн засгийн шинжилгээ хангалтгүй байх (26%) явдал юм. Амжилтгүй байдлын 13% нь л зөвхөн хувь хүний болон тусгай шинжтэй хүндрэлүүдтэй холбоотой байдаг байна.

Бидний үзэж байгаагаар системийн шинжилгээний аргачлалын үүднээс авч үзэхэд хамгийн сонирхолтой хэд хэдэн зүйлд анхаарлаа хандуулж, эдгээр элементүүдийн агуулгыг товч авч үзье. Ямар ч системийг судлах логик үндэслэл нь системийн зорилгыг нарийвчлан тодорхойлох, өөрөөр хэлбэл түүний оршин тогтнох учир утгыг тодорхойлох явдал юм.

Эдийн засгийн объектуудад системийн шинжилгээ хийхдээ стратегийн болон тактикийн шинж чанартай сонголтод болон сонголтод бус шинжүүдийн аль алиныг нь агуулсан хэд хэдэн өөр өөр арга замыг ашиглах замаар нэгэн ижил зорилгод хүрэх боломжтой байна. Иймд ашиг орлогоо өсгөх арга хэрэгслүүд нь бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах гэх мэт байж болно. Эдгээр ашиг орлого нэмэгдүүлэх арга замууд нь янз бүрийн чиг үүргийг гүйцэтгэх замаар бие биеэ нөхөж байдаг. Нэг зорилтын талаар шийдвэр гаргах болон шийдлийн өөр өөр хувилбаруудыг хэрэгжүүлэх (өөр өөр хэрэгсэл болон арга замуудыг ашиглах замаар нэг зорилгод хүрэх) боломж удирдлагын бүх талуудад байдаг. Зорилгод хүрэх хэд хэдэн өөр өөр хувилбар байж болох бөгөөд энэ нь тэдгээр хувилбаруудыг шинжлэн судалж, сонголт хийхэд хүндрэл учруулдаг. Энэ тохиолдолд үйл ажиллагааны илт оновчтой бус хувилбарууд хасагдах нөхцөлийг бүрдүүлсэн нарийвчилсан судалгааны хувилбаруудыг сонгох аргыг олох хэрэгтэй. Иймд тавигдсан зорилгод хүрэх хамгийн сайн арга замыг олох асуудлыг хоёр хэсэгт хуваадаг. Асуудлын эхний хэсэг нь боломжит олон хувилбаруудын дундаас хамгийн оновчтой бөгөөд давамгайлсан хувилбаруудыг сонгох хэрэгтэй. Харин хоёр дахь хэсэг нь харьцангуй цөөн тооны оновчтой хувилбаруудаас хамгийн сайныг нь сонгоход харьцангуй хялбар болно.

Шаардлагатай нөөц. Тавигдсан зорилгод хүрэхийн тулд сонгосон аль нэг аргыг хэрэгжүүлэхийн тулд тодорхой хэмжээний нөөц шаардлагатай болох нь ойлгомжтой. Тухайн зорилгод хүрэхийн тулд зарцуулагдсан нөөцийг бусад хэрэгцээнд ашиглах боломжгүй тул бусад хэрэгцээгээ харгалзан тооцож тухайн зорилгоо биелүүлэхэд шаардагдах нөөцийг тодорхойлох асуудал урган гарч ирдэг. Шаардлагатай

нөөцийг тодорхойлж, хуваарилахад харгалзан тооцох үндсэн нөхцөлүүдийн нэг бол түүний хязгаарлагдмал байдал бөгөөд энэ нь нөөцийн хуваарилалтын тэргүүлэх чиглэл тодорхойлох болон хэмнэлттэй ашиглах шаардлагыг бий болгодог. Ялангуяа маш ховор нөөцөд нэмэлт хязгаарлалт оруулах нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор нөөцийг харилцан орлуулах асуудал чухлаар тавигдах болно. Нөөц бол гарч буй шийдвэрүүдийг шүүн тунгаадаг шүүлтүүрийн адил юм. Хэрэв судалгаагаар шаардлагатай нөөц хангагдах боломжгүй нь тодорхой болсон бол зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц хангагдах хүртэл зорилго болон стратегиа дахин авч үзэх шаардлагатай. Ийм маягаар зорилго тодорхойлох, стратеги сонгох, шаардлагатай нөөцийг тодорхойлох ажлууд нь харилцан уялдаатай байна. Боломжит нөөц, түүнийг үйлдвэрлэх болон хэрэглэх аргууд, тавигдсан зорилгодоо хүрэх стратегийг хэрэгжүүлэх боломж зэрэг нь зорилгоо тодорхойлох үйл явцад эрчимтэй нөлөөлдөг. Нөгөө талаас нэг эсвэл хэд хэдэн төрлийн нөөц гүйцэд ашиглагдаагүй нь тодорхой болсон тохиолдолд зорилго болон стратегийг дахин авч үзэх боломжтой. Шаардлагатай нөөцийг тодорхойлох үед шийдвэрлэх ёстой гол асуудлуудыг дараах байдлаар томьёолж болно:

- нөөц тус бүр нь хэр хэмжээтэй болох,
-тавигдсан зорилго болон сонгосон стратегийг хэрэгжүүлэхэд ямар хугацаа шаардлагатай,
- аль нь эдгээр нөөцийг хэрэглэх,
- эдгээр нөөцийг бий болгох эсвэл олж авах оновчтой арга зам юу байгаа зэргийг тодорхойлох хэрэгтэй.

Системийн шинжилгээ хийх дарааллсан арга

Нарийн төвөгтэй системийг судлахын тулд нэгтгэх болон дүн шинжилгээ хийх ажиллагааны журмыг онцгойлон зохицуулж нэгтгэх шаардлагатай. Тэдгээрийг хослуулан зохицуулах олон төрлийн арга байж болох ажээ. Тухайлбал: нарийн төвөгтэй үйлдвэрлэлийн цогцолборыг үр дүнтэй судлахад дараах аргыг хэрэгжүүлэх замаар шийдвэрлэхийг эрдэмтэд санал болгосон байна.

а/ Судалгаанд хамрагдаж буй системийн хил хязгаарыг тодорхойлох.

Судлагдаж буй системийн хил хязгаар нь нөхцөлт байдалтай юм. Хэдийгээр бодитой мэт харагддаг боловч системийн хил хязгаар нь судалгааны ажлын тодорхой зорилтоор тодорхойлогддог. Жишээ нь: эхний тохиолдолд “корпорац” гэсэн системийн хил хязгаар байнгын орон тооны ажилтнуудын нэрсийн жагсаалтаар тодорхойлогдож болох бол, хоёр дахь тохиолдолд байнгын орон тооны ажилтнуудаас гадна мөн компанийн бүх хувьцаа эзэмшигчдээр тодорхойлогдож болно. Харин гурав дахь тохиолдолд энэ хил хязгаарт түр хугацаагаар ажиллаж буй мэргэжилтнүүд, шинжээчид, зөвлөхүүд гэх мэтээр өргөжин тэлэх болно. Дараа нь энэ хил хязгаарыг компанийн бүх ханган нийлүүлэгчид, хэрэглэгч-үйлчлүүлэгчид болон ямар нэгэн байдлаар компанитай холбогдсон субъектүүдээр өргөжүүлж болно.

б/ Судалгаанд хамрагдаж буй систем бүрэлдэхүүнд нь ордог бүх том системүүдийн тодорхойлолт.

Үнэндээ, систем болгон нь хязгааргүй тооны том системүүдэд

харьяалагддаг. Гэхдээ тодорхой зорилтуудын нөхцөлт шаардлагуудаас хамааран хамгийн ач холбогдолтой том системүүдээр хязгаарлах шаардлагатай байдаг. Хэрэв бид аж ахуйн нэгжид нөлөөлж буй эдийн засгийн орчны нөлөөллийг тодруулж байгаа бол аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг авч үзэх том систем нь зөвхөн эдийн засгийн орчин байх болно. Гэсэн хэдий ч системтэй хандлага нь бодит байдал дээр юу "нарийн" гэдгийг ойлгоход тусалдаг. Жишээ нь: экологийн асуудал бол бодит байдлыг хөнгөвчилсөн бас гажуудуулсан асуудал байдаг. Экологийн асуудлыг шийдвэрлэх оролдлого нь түүнтэй холбоотой эдийн засгийн, сэтгэл зүйн болон бусад асуудлыг зайлшгүй ойлгоход хүргэдэг. Тиймээс орчин үеийн нийгмийн амьдралын бүх хүрээний харилцан уялдаатай байдлыг харгалзан *аливаа объект, тухайлбал, аж ахуйн нэгж нь* эдийн засаг, улс төр, улс орон, бүс нутаг, нийгэм, экологи, олон улсын байдал зэрэг нь системүүдийн салшгүй хэсэг гэж авч үзэж судлах ёстой. Эдгээр том системүүд тус бүр нь /жишээлбэл: эдийн засгийн систем аж ахуйн нэгж, нийлүүлэгчид, хэрэглэгчид, өрсөлдөгчид, түншүүд, банкнууд гэх мэт/ олон тооны бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь мөн нийгэм-соёлын, экологийн гэх мэт өөр том системүүдэд хамаарагдана. Хэрэв эдгээр системүүд болон тэдгээрийн бүрдэл хэсгүүд нь хоорондоо зөрчилдсөн өөр өөрийн онцлог зорилгуудтай байдаг бол *аж ахуйн нэгжийг хүрээлж буй орчныг сайтар судлах шаардлагатай* гэдэг нь тодорхой болно. Энэ хүрээнд оновчтой менежмент хийгээгүй тохиолдолд том системүүдээс аж ахуйн нэгжид үзүүлж буй олон тооны нөлөөллүүд нь бүгд нийлээд эмх замбараагүй, урьдчилан таамаглах аргагүй хүнд байдалд оруулах магадлал өндөр билээ.

в/ Тухайн системд хамрагддаг бүх том системүүдийн үндсэн шинж чанар болон хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, тухайлбал, тэдгээрийн зорилго болон хоорондын зөрчлийг тодорхойлох.

г/ Судалгаанд хамрагдаж буй системийн зүгээс том систем тус бүрд гүйцэтгэж буй үүргийг тодорхойлох, ингэхдээ тухайн үүргийг том системийн зорилго биелэгдэх арга хэрэгсэл гэж үзэх.

Үүнд дараах хоёр асуудалтай уялдуулан авч үзэх хэрэгтэй:

- том системийн хувьд системийн зүгээс *хэрэгжүүлсэн, хүлээгдэж байсан үүрэг*, өөрөөр хэлбэл, том системийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэх ёстой үйл ажиллагаанууд,
- том системийн зорилгод хүрэхийн тулд системийн зүгээс гүйцэтгэх бодит үүрэг.

Ийм хоёр талт хандлагын нэг жишээ бол тодорхой төрлийн барааны эрэлт хэрэгцээ, түүний тоо хэмжээ болон чанарын үнэлгээ, нөгөө талаас – тодорхой аж ахуйн нэгжийн бодитоор үйлдвэрлэн гаргаж буй барааны параметрийн үнэлгээ юм. Хэрэглээний орчинд аж ахуйн нэгжээс хүлээж буй үүрэг болон аж ахуйн нэгжийн бодит үүргийг тодорхойлох, мөн түүнчлэн тэдгээрийн харьцуулалт нь компанийн амжилт болон алдагдалтай ажиллахын олон шалтгааныг ойлгох, компанийн үйл ажиллагааны онцлогийг ойлгох, цаашдын хөгжлийн бодит ирээдүйг урьдчилан харах боломжийг олгодог.

д/Системийн бүтцийг тодорхойлох, өөрөөр хэлбэл түүнийг бүрдүүлж байгаа хэсгүүдийг тодорхойлох.

Ихэнхдээ судалгааны ажлын зорилго нь системийг бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваахыг шаардаад зогсохгүй, мөн тэдгээр хэсгүүдийг бүрдүүлж байгаа бүрдэл хэсгүүдэд хуваахыг шаарддаг. Зарчмын хувьд ингэж хуваах үйл явц нь системийн гүн рүү хязгаргүйгээр нэвтрэн орох боломжтой ба энэ нь зөвхөн тодорхой зорилтын хүрээнд хязгаарлагддаг. Тиймээс шийдвэрлэгдэж буй асуудлаас хамаарч, ийм системийн бүтцийг аж ахуйн нэгжтэй адилтган авч үзэж, жишээлбэл: цех болон хэлтсүүдийн жагсаалтаар хязгаарлаж болно. Харин шаардлагатай тохиолдолд цех болон хэлтсүүдийг бригад, хэсэг, тодорхой ажилчид, тэдгээрийн үйл ажиллагааны элементүүд гэх мэт нарийвчлан хуваж хязгаарлаж болно.

е/ Системийн бүрэлдэхүүн хэсгүүд хоорондын холбоосны нийлбэр багц болох системийн бүтцийг тодорхойлох.

Бүтэц – энэ бол системийн дотоод хэлбэр, зүйрлэн хэлбэл системийн "дотоод зохион байгуулалт" юм. Үүнийг системийн бүрэлдэхүүнд, бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр багцад хамруулж болохгүй. Ямар ч систем олон бүтэцтэй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Жишээлбэл: аж ахуйн нэгжид зохион байгуулалтын бүтэц байдаг, өөрөөр хэлбэл захирах, захирагдах болон зохицуулах харилцаа байдаг. Байгууллагад мөн албан болон албан бус мэдээллийн урсгалаар илэрхийлэгддэг *мэдээллийн бүтэц* байдаг. Мөн өөрийн бүтцээ бүрдүүлдэг материал, түүхий эд, эд анги, эцсийн бүтээгдэхүүн гэж байдаг. Өмчийн харилцааны нийлбэр багц болох аж ахуйн нэгж дэх эдийн засгийн бүтцийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. *Ёс суртахуун-сэтгэл зүйн бүтцийг бүрдүүлдэг* ажиллагсдын хоорондох хүмүүний цэвэр харилцаа – таарамжтай байх эсэх нь хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Янз бүрийн бүлгүүдэд харьяалагддаг ажиллагсдын хооронд үүсдэг тусгай харилцааг, жишээлбэл: үйлдвэрчний эвлэл, нам, олон нийтийн хөдөлгөөний гишүүдийн хооронд үүсдэг улс төрийн шинжтэй харилцааг тодруулж болно. Аж ахуйн нэгжид өөр олон бүтэц байдаг шүү дээ.

ё/ Системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн чиг үүргийг тодорхойлох, өөрөөр хэлбэл бүрэлдэхүүн хэсгүүдийн зорилго чиглэлтэй үйл ажиллагаа, системийн үүргийг бүхэлд нь хэрэгжүүлэхэд тэдгээрийн оруулах "хувь нэмэр"-ийг тодорхойлох.

Бодит үйл явцын хувьд бүрэлдэхүүн хэсэг тус бүр нь системийн зорилгыг бүхэлд нь биелүүлэх боломжийг олгодог ашигтай эерэг шинж чанаруудыг агуулахаас гадна мөн саад учруулах сөрөг шинж чанаруудтай байдаг. Иймд системийг судлах, бий болгох явцдаа олон өөр ажиллагаануудын дундаас бүрэлдэхүүн хэсгүүдийн ашиг тустай бөгөөд үр ашигтай ажиллагаануудыг (өөрөөр хэлбэл чиг үүргүүдийг) ялгах шаардлагатай. Үүний тулд *бодитоор гүйцэтгэсэн чиг үүргүүдээс бүрэлдэхүүн хэсгүүдийн тунхаглан зарласан эсвэл тогтоосон чиг үүргүүдийг салгах шаардлагатай.* Янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн чиг үүргүүдийн зохицсон бөгөөд хоорондоо зөрчилдөөгүй хослол хамгийн чухал юм. *Чиг үүргүүдийн зөрчилдөөнгүй байдал болон уялдаа*

холбоо нь гармоник системийг эд зүйлс болон үйл явдлуудын эмх замбараагүй багцаас ялгаж өгдөг. Ингэхдээ чиг үүргүүд нь чанарын хувьд өөр өөр байх ёстой ба энэ нь бие биеэ нөхөх замаар системийн үүргийг бүхэлд нь гүйцэтгэхэд хангалттай өргөн хүрээг хамарсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг олгох болно. Үүний зэрэгцээ аливаа *бодит* системд бүрэлдэхүүн хэсгүүдийн чиг үүргүүд нь хоорондоо бүрэн зохицолдоогүй байдаг бөгөөд тэдгээр нь хоорондоо зөрчилддөг, энэ нь системийн үүргийн үр ашиг бүхэлдээ буурахад хүргэдэг. Тиймээс *бүрэлдэхүүн хэсгүүдийн чиг үүргүүдийг таньж мэдэхдээ тус тусад нь биш, харин тэдгээрийг нэгтгэн, тэдгээрийн харилцан уялдаа, хоорондох зөрчилдөөн, уялдаа холбооны зэрэг байдлыг таньж мэдэх шаардлагатай.* Энэ асуудал нь ялангуяа томоохон аж ахуйн нэгжүүдийн чиг үүргүүд нь ихэнхдээ "үл зохицолдсон", ерөнхий төлөвлөгөөнд хангалттай хамрагдаагүй салбар нэгжүүд болон цехүүдэд тулгардаг.

ж/Тусдаа хэсгүүдийг нэгтгэн нэг систем болгодог шалтгаануудыг тодруулах.

Ийм шалтгаануудыг нэгтгэх хүчин зүйлүүд гэж нэрлэдэг. Ерөнхийдөө *хүний үйл ажиллагаа нь системийг бий болгодог нэгтгэх хүчин зүйл юм.* Үйл ажиллагааны явцад хүн өөрийнхөө сонирхлыг ойлгож, зорилгоо тодорхойлж, практик үйл ажиллагаа явуулж, зорилгодоо хүрэхэд шаардлагатай арга хэрэгслүүдийн системийг бий болгодог. *Үндсэн, анхдагч, мөн түүнчлэн нэгтгэгч хүчин зүйл нь зорилго юм.*

Ямар нэгэн системийг бий болгоход хүргэсэн бодит зорилгыг тодорхойлох нь хялбар ажил биш нь мэдээж. Учир нь зорилго нь хэзээд үйл ажиллагааны ямар ч хүрээнд янз бүрийн зөрчилдөөнтэй ашиг сонирхлуудын нарийн төвөгтэй цогц нэгдэл юм. Тухайлбал- ашгийг хамгийн өндөр түвшинд хүргэх нь орчин үеийн аж ахуйн нэгжийн зорилго биш, энэ нь ашиг сонирхлуудын зөвхөн нэг нь юм. Өөр нэг багагүй ач холбогдолтой ашиг сонирхол бол *тогтвортой ашиг олох* явдал юм. Гурав дахь чухал ач холбогдолтой ашиг сонирхол бол аж ахуйн нэгжийн *нэр хүнд тогтвортой* байх явдал юм. Энэ мэтчилэн эдгээртэй төстэй ашиг сонирхол олон байдаг бөгөөд тэдгээрийн өвөрмөц хэлбэрийн хослол нь жинхэнэ зорилго болно. Бүх талын шинжилгээ нь системийн тогтвортой байдлын түвшин, үл зөрчилдөх байдал, бүрэн бүтэн байдлыг шүүн тунгааж, цаашдын хөгжлийн мөн чанарыг урьдчилан таамаглах боломжийг олгодог.

з/ Системийг гадаад орчинтой холбодог боломжит бүх харилцааг тодорхойлох.

Системийг бүх талаас нь, жинхэнэ утгаар нь гүн гүнзгий судлахад тухайн системийн харьяалагддаг бүх том системүүдтэй холбогддог харилцааг тодруулах нь хангалттай биш юм. Өөрөөр хэлбэл энэ жагсаалтын *б, в, г* - журмуудыг биелүүлэх нь хангалтгүй. Мөн түүнчлэн ийм системүүдийг судалгаанд хамрагдаж буй системийн бүрэлдэхүүн хэсгүүд харьяалагддаг гадна орчинд оруулан судлах шаардлагатай. Иймд аж ахуйн нэгжийн ажилчдын харьяалагддаг бүх системүүд - үйлдвэрчний эвлэл, улс төрийн намууд, гэр бүл, нийгэм-соёлын үнэт зүйлс

болон ёс суртахууны хэм хэмжээний системүүд, угсаатны бүлгүүд зэргийг тодорхойлох шаардлагатай. Мөн аж ахуйн нэгжийн бүтцийн салбар нэгжүүд болон ажилтнууд нь хэрэглэгчид, өрсөлдөгчид, ханган нийлүүлэгчид, гадаадын түншүүд гэх мэт этгээдүүдийн ашиг сонирхол болон зорилгын системүүдтэй ямар холбоотой байгааг сайн мэддэг байх шаардлагатай. Аж ахуйн нэгжид ашиглагдаж буй технологиуд болон шинжлэх ухаан-техникийн процессын "орон зай" зэргийн хоорондох холбоог мэдэх шаардлагатай. Аж ахуйн нэгжийн эргэн тойрон дахь бүх системийн нэгдэлд харшилдаг хэдий ч, түүний бүрэн бүтэн байдлын шалтгааныг ойлгож, задралд хүргэдэг үйл явцыг урьдчилан сэргийлэх боломжийг бидэнд олгодог органик нэгдлийг гүнзгийрүүлэн судалж ойлгох хэрэгтэй.

и/ Судалгаанд хамрагдаж буй системийн динамик хөдөлгөөн болон хөгжлийг авч үзэх.

Энэ нь системийн түүх, үүсэж бий болох эх сурвалж, оршин тогтнох үе шатууд, хөгжлийн чиг хандлага болон хэтийн төлөв, чанарын хувьд шинэ төлөвт шилжих шилжилтийг тодорхойлж томьёолох гэсэн үг юм. Системийн судалгаанд хандах динамик хандлагын шаардлагыг хугацааны ямар нэгэн агшинд, аль нэг параметрээр хэмжих нь ихээхэн өрөөсгөл дүгнэлт болно. Жишээ нь: борлуулалтын хэмжээ нь давхцаж таарсан хоёр аж ахуйн нэгжийг харьцуулах замаар хялбархан тайлбарлаж болно. Энэ давхцалаас тухайн хоёр аж ахуйн нэгж зах зээл дээр ижил байр суурь эзэлдэг гэсэн дүгнэлт хийж болохгүй. Учир нь энэ хоёр аж ахуйн нэгжийн нэг нь хүчирхэгжиж, хөгжин дэвжиж, харин нөгөөдөх нь эсрэгээр уналтад орох магадлалтай байдаг. Тиймээс аливаа системийг, тухайлбал, аж ахуйн нэгжийг зөвхөн "агшин зуурын гэрэл зураг"-аар, ямар нэгэн параметрийн нэг утгаар дүгнэж болохгүй; параметрүүдийг динамик хөдөлгөөнд авч үзэх замаар тэдгээрийн *өөрчлөлтийг* судлах шаардлагатай. Аливаа системийг гүн гүнзгий ойлгохын тулд тухайн системийн оршин тогтнол болон хөгжлийн тодорхой (богино) хугацаануудаар хязгаарлагдах ёсгүй. Боломжийн хэрээр тухайн системийн түүхийг *бүрэн хэмжээнд* судалж, тухайн системийг бий болгоход хүргэсэн шалтгаануудыг тодруулж, тухайн систем ямар системүүдээс үүсэж, оршин тогтносон тэр системүүдийг тодорхойлох нь зүйтэй юм. Зөвхөн системийн түүх эсвэл системийн өнөөгийн нөхцөл байдлын динамик хөдөлгөөнийг судлаад зогсохгүй, тусгай арга техникийг ашиглан системийн ирээдүйн хөгжлийг харах, өөрөөр хэлбэл ирээдүйн нөхцөл байдал, асуудал болон боломжуудыг урьдчилан таамаглахыг хичээх нь чухал. Энд тоочсон системийн шинжилгээний журмууд нь системийн судалгааны арга техникүүдийг бүрэн хэмжээнд ашигладаггүй. Үүнээс гадна эдгээр журмууд нь агуулгын гэхээсээ илүү албан ёсны шинжтэй байна. Эцсийн эцэст зөвхөн *тодорхой* системийг судлах явцад тусгай арга техникүүд бий болж, тухайн системийг судлах үед олж авсан мэдлэгийг цаашдын танин мэдэх үйл явцад хамгийн сайнаар ашиглах онцгой арга зүй бий болдог. Өөрөөр хэлбэл тодорхой системийн судалгааны явцад тухайн систем нь өөрөө өөрийг нь цааш судлах аргыг боловсруулахад

тусалдаг.

Энд дурдсан системийн шинжилгээний журмын дараалал нь зайлшгүй бөгөөд хууль ёсны зүйл биш юм. Журмын дараалал биш харин журмын жагсаалтыг л заавал дагаж мөрдөх ёстой. Системийн нэгдлийг бий болгохын тулд хэрэгжүүлэх шаардлагатай жагсаалтын эхний хэдэн журмаас бусдыг нь тодорхой системийн агуулгаас "үүдэлтэй" логик дээр үндэслэн гүйцэтгэх ёстой. Өмнө нь дурдсанчлан тодорхой системийн судалгаа нь судалгааны объектыг улам гүнзгийрүүлэн судлах боломжийг олгодог шинэ бөгөөд нэмэлт арга техникүүдээр судлаачийг зэвсэглэж өгдөг. Энд тайлбарласан орчин үеийн аж ахуйн нэгж, байгууллагын хангалтын судалгаанд ашигладаг системийн шинжилгээг хэрэглэснээр ямар нэгэн хэмжээгээр тухайн байгууллагын хангалтын үйл ажиллагааны мөн чанарт нэвтэрч, уг байгууллагын үйл ажиллагааны онцгой ач холбогдол бүхий дотоод, гадаад хүчин зүйлүүд болон талуудад анхаарлаа хандуулах боломжийг олгодог байна.

Системийн шинжилгээ нь компьютерын ухаан гарч ирэхээс бүр өмнө бий болсон талаар дээр дурдсан бөгөөд системийн шинжээч нарт олон төрлийн, тал бүрийн арга ухаан, ур чадварыг шаардагддаг байжээ. Харин компьютер, мэдээллийн технологитой холбоотойгоор системд шинжилгээ хийх хэв маяг өөрчлөгдөж, гайхамшигтай үр дүнд хүрсэн билээ.

Эрдэмтэдийн үзэж байгаагаар системийн шинжилгээг ашиглахын тулд:

- өөрийн мэддэг, илүү ашиглаж чадах кодчилох хэрэгслээс ихээхэн хамаарч шинжилгээ зохиомжоо гаргах сонголтыг зөв хийх;

- аливаа системд шинжилгээ хийж сурахдаа:

➢ системийн үндсэн тодорхойлолтыг эхлээд "цээжил", дараа нь үг бүрийг нь бясалган бодох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тухайн системийн аль хэсгийг дэд систем, аль хэсгийг нь бүрэлдэхүүн хэсэг, аль хэсгийг элемент гэх вэ гэдэгт тодорхойлолт өгөх ёстой,

➢ энгийн загваруудыг эхлээд маш сайн хэрэглэж сурах хэрэгтэй гэнэ.

➢ төрөл бүрийн хэрэгсэл, программуудын аль нэгийг төгс эзэмших шаардлагатай гэж эрдэмтэд сургасан байна.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО БА МЕРИТ /ЧАДАХУЙН/ ЗАРЧИМ

МУ-ын ЕТГ-ын ахлах референт,
Бригадын генерал Ч.Сайнтөр

Монгол улс анх 1994 онд Төрийн албаны тухай хуулиа баталж, 2002 онд шинэчлэн найруулж, 2008 онуудад нэмэлт өөрчлөлтийг оруулан, 2017 онд шинэчлэн батлагдан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Төрийн албаны тухай хууль нь төрийн албаны бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүнийг зохицуулсан стандартын хувьд цаашид шинэ нийгмийн эрэлт шаардлагыг хангахуйц загвартаа дөхсөн гэж хэлж болохоор бөгөөд иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах мерит зарчмыг шинээр тусгасан нь төрийн албыг мерит тогтолцоонд шилжүүлэх бодитой алхам болсон байна.

Аливаа улс орны иргэн бүр,тэдний төрөлх эх орон цэцэглэн хөгжиж,төрийн удирдлага,захиргаа чадвартай, ёс зүйтэй, шударга байх, өөрсдийгөө хөгжин дэвшсэн орны хүндтэй иргэн байхыг мөрөөддөг.

"Меротократия" гэдэг бол төрийн дээд удирдлагад хамгийн чадвартай, авьяаслаг хүмүүс шигшигдэн гарч ,улсынхаа нөөц баялгыг бүрдүүлж хөгжилд хүргэх, ард түмэн,нийгмээ бүхэлд нь сайн сайханд хүргэх тэр дэглэм, удирдлага юм.

Энэ нэр томьёог анх немцийн философич Ханна Арендт хэрэглэж ,улмаар английн социологич М.Янгу улс төрд оруулж ирэн баталгаажуулсан. Меротократийн тунхаглаж буй гол зарчмууд бол:

-Аливаа хүний нийгмийн гарал үүсэл төрийн албанд томилогдоход гол үүрэггүй байх,

- Авьяас чадвар,хөдөлмөрч,тэвчэ эртэй,шударга зан чанар л онц чухал байх,

- Чөлөөт өрсөлдөөн бий болгох,

- Засгийн эрхэнд гарах хүмүүст анхны гараа адил байх таатай орчин бий болгох зэрэг ордог.

Эртний Хятадад Чжао он тооллын үед энэ зарчмыг "Тухайн хүн өөрийн амьдарч, ажиллаж буй нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдсөн байх" гэж тодорхойлоод: үнэнч шударга, хүнлэг энэрэнгүй, ард түмэндээ үлгэр жишээ болохуйц, байнга сайтар боловсорч хөгжиж байх зан чанарыг удирдлага эзэмшиж байхыг сургасан байдаг.

Мерит зарчим төрийн албанд хэрхэн, яаж үйлчлэх вэ?, Мерит бол хувь хүний амжилт дээр тогтсон засаглал бөгөөд орчин үеийн хөгжингүй орнуудын төрийн албаны үндэс болдог. Төрийн албанд шилдэг нэр дэвшигчийг нээлттэй, ил тод өрсөлдөөнөөр хүссэн хүн бүрийг оролцуулан гаргаж ирдэг.

Сонгон шалгаруулалтыг хэрхэн хийх вэ?, Өндөр мэргэжлийн бие даасан хараат бус ажиглагчид, сонгон шалгаруулалтыг журам дагуу явж байгаа эсэхэд хяналт тавих, аль нэг албан тушаалд өрсөлдөгчид тэдгээрийн хөдөлмөр, гавьяаг үнэлэх бодит

шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах зэрэг болно.

Мерит зарчмыг шүүмжлэгчид нийгмийн өмнө тухайн хүний оруулсан гавьяа зүтгэлийг тодорхойлох цогц арга байхгүй гэж үздэг.

Аливаа улс орны төрийн алба хэдий чинээ мэргэшсэн, тогтвортой байх тусам тухайн орны улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн үр дүн төдий чинээ сайжирч, нийгмийн хөгжлийн хөтөч болж чаддаг байна.

1883 онд АНУ-ын Ардчилсан намын сенатч Жорж Пендлтоны санаачилж батлуулсан Төрийн албаны шинэтгэлийн акт ("Пендлтоны хууль" гэж алдаршсан)- аар тус улсад улс төрийн намуудад сонгуулийн үр дүнгээр төрийн албан тушаалыг хуваарилдаг, төрийн албанд улс төр хүчтэй нөлөөлдөг шударга бус тогтолцоог өөрчилсөн бөгөөд энэ үеэс эхлэн АНУ-д төрийн албаны мерит тогтолцоо бий болжээ.

Википедиа нэвтэрхий толь бичгийн тайлбарт "Меритократ бол Монголын их гүрний цэргийн жанжнуудаа сонгодог гол үзэл баримтлал нь байжээ. Чингис хааны давтагдашгүй амжилтын нэг чухал хүчин зүйл нь түүний цэргийн албанд тавигдах шаардлагад гавьяа, чадвараараа манлайлан шалгарсан хэнийг ч ялгалгүй сонгон томилж, зөв хүнийг зөв албан тушаалд зөв цагт нь язгуур угсаа, хүний өөрийн гэж ялгалгүй шударга ,төрд үнэнчээр зүтгэх нөхцөлийг бүрдүүлдэг байв. [2]

Пендлтоны хуулийн үзэл баримтлалыг авч хэрэгжүүлсэн Япон, Өмнөд Солонго зэрэг улсууд асар богино хугацаанд өндөр хөгжилд хүрч чадсан. Манай улс сүүлийн үед Канад, Австралийн төрийн албаны туршлагыг судалж, холбогдох байгууллагуудтай нь холбоо тогтоогоод байгаа нь мерит зарчмыг монгол хөрсөнд буулгах гэсэн санаачлагууд юм.

Төрийн албаны шинэтгэлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мерит зарчмыг тууштай хэрэгжүүлэх замаар аль болох түргэн урагшлуулах, олсон ололтоо бататган, цаашид улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой, чадварлаг төрийн албыг бэхжүүлэн хөгжүүлэх ашиг сонирхол төр засгийн түвшинд ч, олон нийтийн хүрээнд ч нэгдмэл байна.

Бид Олон улсын жишиг, Төрийн албаны тухай хууль болон одоо мөрдөгдөж буй бусад холбогдох хуулийн зарчим, мерит тогтолцооны үзэл санаатайгаа уялдуулан Хил хамгаалах байгууллагын алба хаагч бүр шатлан дэвших нөхцөл боломжоор хангагдсанаар байгууллагын алсын хараа, үндсэн зорилго, зорилтыг биелүүлэх мэдлэгтэй, боловсролтой, мэргэжилтэй, мэргэшсэн, ур чадвар, туршлагатай, ажлын үр дүнгээр өрсөлдөх чадвартай боловсон хүчнээр хангагдан, хүний нөөцийн чадавх сайжрах гол үзүүлэлт болох юм.

"Меритократ" буюу мерит гэдэг үгийг Монголчилбол "Гавьяа зүтгэл, чанар чансаа, сайн тал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал" гэх утгыг агуулах бөгөөд хүний нөөцийн тухайд энэ ойлголт нь төрийн аливаа албан тушаалд түүний зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй шалгуур, шаардлагуудыг бүх талаараа бүрэн хангасан шилмэл хүн томилогдох үйл явцыг илэрхийлдэг.

Мөн мерит тогтолцоо нь төрийн албан хаагчдыг улс төрийн хэлхээ холбоон дээр үндэслэж бус тэдний мэргэжил мэдлэг, ажил гүйцэтгэх ур чадвар дээр үндэслэж ажилд авах болон албан тушаал дэвшүүлэхийг хэлдэг байна. [3]

Харин аливаа байгууллага

зорилгодоо хүрэхийн тулд хүний нөөцийн хүчин зүйлийг үр ашиг, үр дүнтэй ашиглах зохицуулах үйл ажиллагаа, тогтолцоог хүний нөөцийн бодлого гэнэ. Өөрөөр хэлбэл хүний хүчин зүйлийг оновчтой удирдах үйл ажиллагааг хэлдэг. Хүний нөөц гэдэг нь байгууллага дах хувь хүмүүсийн туршлага, ур чадвар, мэдлэг, харилцаа авьяас, хувийн шинж чанар, эрсдэл хүлээх чадвар, хүсэл тэмүүлэл зэргийг багтаасан ойлголт юм. [4]

1992 онд батлагдсан Монгол улсын шинэ үндсэн хуульд төрийн жинхэнэ албаны эрх зүйн үндсийг цоо шинээр томьёолсон юм. Эрх зүйн энэ шинэ томьёололд нийцүүлэн,1994 онд Монгол улсад Төрийн албаны тухай шинэ хуулийг боловсруулж 1995 оноос мөрдөж эхэлсэн билээ.

Үүнээс хойш даруй 24 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд Төрийн албаны тухай хуулийг боловсронгуй болгож, төрийн албаны хүний нөөцийн бодлогын эрх зүйн орчныг сайжруулах үүднээс шат дараалсан олон арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.

Хамгийн сүүлчийн өөрчлөлтийг 2008 онд хийж, зарчмын шинжтэй хэд хэдэн томоохон нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Тухайлбал, энэ өөрчлөлтөөр төрийн улс төрийн албанаас бусад ангиллын төрийн албан хаагчдыг улс төрийн намын харьяалалгүй байлгах, улс төрийн албан тушаалаас бусад төрийн албан хаагчид улс төрийн сонгуулийн сурталчилгаанд ямар нэгэн хэлбэрээр оролцохгүй байх, төрийн албан хаагчдыг үндэслэлгүйгээр ажлаас нь халах, чөлөөлөхийг хориглох, Төрийн албаны төв байгууллагаас төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдон гарсан удирдах албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хариуцлага тооцож байх зэрэг төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын томилгоог хуулийн дагуу хийж байх, төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж багасгах, төрийн албыг зүй бус нөлөөллөөс ангид байлгах, төрийн мэргэшсэн, тогтвортой албыг цаашид төлөвшүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг оруулж өгсөн билээ.

Төрийн албаны тухай шинэчилсэн хуулиар улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмын өөрчлөлтийг шинээр тусгажээ. Тухайлбал, Монгол Улсын иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний ур чадвар, туршлага, ажлын үр дүнд буюу чадахуйн зарчимд /мерит/ тулгуурлана. Өөрөөр хэлбэл төрийн албанд чадахуйн зарчмыг үндсэн шалгууруа болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно гэсэн үг. Төрийн албанд нэгэнт томилогдсон албан хаагчийг шатлан дэвшүүлэх зохицуулалт оруулж өгсөн нь хуулийн нэг дэвшил гэж үзэж байна.[4]

Одоогийн мөрдөж буй Төрийн албаны тухай хуульд “Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно”.[5] гэж тусган, дэвшин томилоход баримтлах гол агуулгыг томьёолохдоо албан тушаал тус бүрээр ажилласан жилийн шалгуурыг нарийвчлан тодорхойлсон байх бөгөөд мэргэшүүлэх багц

сургалтад хамрагдаж, төгссөн байхаар эрх зүйн зохицуулалтуудыг тодорхой тусгаж өгсөн байна.

Хил Хамгаалах Байгууллагын хувьд Төрийн албаны тухай хуулийг батлан хэрэгжүүлэхээс өмнө буюу ХЦУГ-ын даргын 1995 оны А/21 дугаар тушаалаар баталсан "ХЦУГ-ын боловсон хүчний дүрэм" баталж, алба хаагчийн үйл ажиллагааны мэргэжлийн түвшинг үнэлэх, дүгнэх , жилийн эцэст алба хаагч нэг бүрийн хийсэн ажлыг газар, анги, албадын даргын зөвлөлийн хуралдаанаараа хэлэлцэн үнэлэлт, дүгнэлтийг өгч, албан тушаал дэвшүүлэх буюу нөөцөд авах"-ыг тусгасан. Мөн "Албан тушаал дэвшүүлэх, бууруулах асуудлыг тухайн албан тушаалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан албан тушаал дэвшүүлж, бууруулна".гэж тусгасан нь мерит зарчмыг агуулж байгаа бөгөөд дээрх шаардлагуудаас гадна албан тушаалд дэвшин томилогдох хугацааг нарийвчлан тусгаж зохицуулсан нь Хил Хамгаалах Байгууллага мерит тогтолцоог хуульд томьёолсон эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна.

Мөн ХЦУГ-ын даргын 1995-10-06-ны өдрийн 850 тоот тушаалаар ХЦУГ-ын дэргэдэх төрийн захиргааны албаны анхны салбар зөвлөл байгуулсан.

1996-11-30-ны өдрийн 1104 тоот тушаалаар ХЦ-ийн хэмжээнд боловсон хүчний ажиллагааг жигдрүүлж,боловсронгуй болгох журам,маягт батлагдсан.

ХХЕГ-ын даргын 2003-06-03-ны өдрийн А/11 тоот тушаалаар " Хүний нөөцийн талаар баримтлах бодлогын үндэс,хүнтэй ажиллах журам" батлагдсан зэрэг нь ХХБ-д хүний нөөцийн асуудалд ихэд анхаарч,албан тушаалын томилгоо улс төр,улс төрчдөөс ангид байх,шалгуур үзүүлэлтээ хангасан нь томилогдох нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон хандаж байсан,анхаарсаар байгаагийн илэрхийлэл болж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"- ын 4.10-т тусгагдсан үнэлгээний хуудсанд ёс зүйн талаарх тэмдэглэгээ хийн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалах зэргээр шинэлэг байдлаар ажиллаж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт:

1.en.wikipedia.org/Pendleton Civil Service Reform Act

2.https // mn.wikipedia.org. Их Монгол улс,Засаг захиргааны хуваарь,төрийн байгуулалт

3.Д.Зүмбэрэллхам.Монгол Улсын төрийн албаны шинэтгэл илтгэл.УБ.

4.А.Цог-Эрдэнэ.Байгууллагын амжилтад онцгой чадавхийн менежментийн үзүүлэх нөлөөлөл. УБ.2016.

5.Д.Тогтохсүрэн.Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга.УБ.,2018.

6.Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2382 дах заалт. УБ.,2019.

7. ХХЕГ-ын аргын 2003-06-03-ны өдрийн А/11 тоот тушаалаар батлагдсан "Хүний нөөцийн талаар баримтлах бодлогын үндэс, хүнтэй ажиллах журам.

ХИЛИЙН БООМТОД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Оронжавын Гантулга,
Хилийн 0101 дүгээр ангийн Алтанбулаг авто замын шалган нэвтрүүлэх заставын дарга,
Хил судлалын ухааны магистр, ахмад

Хилийн боомтын тухай ойлголт: Аливаа объект руу хүмүүс нэвтрэх, тээврийн хэрэгсэл, ачаа барааг оруулах, гаргах үед тэдгээрт хяналт тавих, шалгах зориулалттай, тодорхой эрх бүхий субъектүүдээс бүрдсэн, тусгай тоног төхөөрөмжтэй, хамгаалалттай газрыг шалган нэвтрүүлэх цэг, байр гэдэг түгээмэл ойлголт нийт ард иргэд, дэлхий даяар байдгийг бид сайн мэднэ.

Харин объект гэдэгт байгууллага, яам тамгын газраас авахуулаад үйлдвэр, тусгай газар, цэргийн анги, салбар, цаашлаад улс орны нутаг дэвсгэр бүхэлдээ багтаж байдаг зүй тогтолтой.

Иймд улсын хилийн шалган нэвтрүүлэх цэг (гарц) буюу боомт гэдэг нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа таваар нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг газар гэж тодорхойлж болох юм.

Я.Цэвэлийн тайлбар тольд: "Боомт" гэдэг үгийг 1.Явах зорчих замд тавьсан саад; 2.Хил хязгаарын орох, гарах зам нэвтэрсэн сүв; 3.Халхавч хэрэмд нэвтрэн орох хаалга; боомт хаалга; 4.Далайн эрэг дэх хөлөг онгоц зогсох буудаллахад зохицуулан бэлтгэсэн газар; далайн боомт гэж тайлбарласан байна.

Манай улсад мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд хилийн боомтыг дараах байдлаар томъёолсон байна:

Хилийн боомт гэж улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг[1] хэлнэ гэж заасан байна.

Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдын иргэний харьяалал, ажиллах цагийн хуваарь, ажиллагааны шинж чанараас хамааран боомтууд ялгаатай байна. Үүнд:

Олон улсын боомт гэж Монгол Улсын олон улсын гэрээний дагуу иргэний харьяаллыг үл харгалзан зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх боомтыг;

Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн нэгд "Хилийн боомт" болон "Боомт" нь адил утгатай байх бөгөөд Монгол, Хятадын хилийн 2 талд орших иргэд, тээврийн хэрэгсэл, бараа эд юмст хяналт шалгалт хийж бүртгэн хилээр нэвтрүүлэх зориулалтаар тусгайлан тогтоосон газрыг хэлнэ";

[1] Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.12 дахь хэсэг. //Терийн мэдээлэл. 2017. № 06.

Европын чуулган ба зөвлөлөөр 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан одоо Европын холбооны орнуудад мөрдөж буй "Хилийн тухай Шенгений тунхаглал" гэсэн баримт бичигт "Иргэд, тээврийн хэрэгсэл, объектуудад хилийн хяналт, шалгалт хийх, Европын холбооны улсуудын нутаг дэвсгэрт оруулах эсвэл орхин гаргах асуудлыг шийдвэрлэх тусгай талбай"-г хилийн боомт гэж үзнэ гэсэн байдаг.

Хилийн боомт нь агаарын замын, төмөр замын, авто замын гэсэн төрөлтэй, байнгын, түр гэсэн горимтой, олон улсын, хоёр талын гэсэн зэрэглэлтэй[2] байна.

Хилийн боомтын төрөл, горим, зэрэглэлийг Засгийн газар тогтооно.

Хилийн боомтыг түүний төрөл, олон улсын шинж чанар, ажиллах цагийн хуваариас нь шалтгаалан дараах байдлаар ангилна[3].

Хилийн боомтын эрх зүйн орчны өнөөгийн байдал: Хилийн боомтын талаар өнөөгийн байдлаар бие даасан, тусгайлан гаргасан ямар нэгэн хууль, тогтоомж манай улсад байхгүй байна. Хилийн боомтод ажиллаж буй хилийн хяналтын байгууллага болох хилийн шалган нэвтрүүлэх алба, гаалийн алба, хилийн мэргэжлийн хяналтын алба, гадаадын иргэн харъяатын асуудал эрхэлсэн албадууд өөр өөрсдийн үйл ажиллагаандаа тохируулан гаргасан ерөнхий хууль эрх зүйн орчинтой, босоо удирдлагатай, бие биенээс хараат бус байна.

Хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа боловч өнөөгийн мөрдөгдөж буй зарим хууль тогтоомжид хилийн боомт, түүний удирдлага, чиг үүрэг, боомтод мөрдөх журмын талаар туссан байдалд судалгаа хийж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр зүйлд: Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна;

Иймд улсын хилийн халдашгүй дархан байх нөхцөлийг хангах үйл ажиллагаа нь улсын хил хамгаалалт мөн бөгөөд тэр нь *"Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн"* гэж Монгол Улсын Хилийн тухай хуульд заасан байна.

Харин улсын хил хамгаалалтын үйл ажиллагааг хилийн албаны, шалган нэвтрүүлэх албаны, хилийн төлөөлөгчийн албаны, тагнуулын албаны аргаар зохион байгуулах талаар Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэмд оруулжээ.

Тиймээс хилийн боомтын буюу хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааны талаар бие даасан хууль байхгүй ч Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтыг үндэслэн Монгол Улсын Хилийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор тодорхой түвшинд зохицуулсан байна гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Шалган нэвтрүүлэх алба, түүний үйл ажиллагаа нь улсын хил хамгаалалтын арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг мөн учир хил хамгаалалтыг зохион байгуулан удирдах байгууллага нь хилийн шалган нэвтрүүлэх албыг удирдах байгууллага байх эрх зүйн үндэслэл болж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг

---

[2] Хилийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. //Төрийн мэдээлэл. 2017. № 06.

[3] Муратхан А. Хилийн боомтуудад судалгаа хийх шаардлага өнөөгийн байдал, эрх зүйн орчин судалгааны ажил. УБ., 2008. 15 дахь тал

хангах үйл ажиллагаанд дараах эрх зүйн баримт бичгийг удирдлага болгоно[4]. Үүнд:

1.Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ хэлэлцээр;

2.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;

3.Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого;

4.Монгол Улсын хилийн тухай хууль;

5.Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм /*Засгийн газрын тогтоол улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдсан дүрэм, журам/;*

6.Хилийн цэргийн командлагчийн улсын хил хамгаалах удирдамж тушаал;

7.Хилийн отряд /анги/-ын даргын улсын хил хамгаалах тушаалыг үндсэн удирдлага болгон хилийн боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмыг сахиулах гэсэн эрх зүйн зохицуулалт байна.

Алтанбулаг боомтын өнөөгийн байдал: Алтанбулаг авто замын шалган нэвтрүүлэх боомт нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт, Улаанбаатар хотоос 325, Сэлэнгэ аймгийн төвөөс 25 километрийн зайтай байрладаг бөгөөд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон аймгуудтай хатуу хучилттай замаар холбогдсон манай улсын авто замын томоохон боомтуудын нэг юм.

Алтанбулаг боомт нь Олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай боомт бөгөөд Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолын дагуу 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 24 цагийн горимд шилжин ажилласан бөгөөд Хил хамгаалах байгууллага, Гааль, Хилийн мэргэжлийн хяналтын алба, Гадаадын иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллага 4 ээлжийн бүрэлдэхүүнтэйгээр хяналт, шалгалтыг зохион байгуулан ажиллаж байсан.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум нь ОХУ-ын Хиагт хоттой хиллэдэг бөгөөд Хиагт хот нь 40 000 орчим хүн амтай. Хүн амын дийлэнх хэсэг нь төр захиргааны байгууллагад ажилладаг бол тодорхой хэсэг нь мал аж ахуй, газар тариалан, хилийн худалдаа наймаа эрхлэн аж төрдөг.

Оросын Холбооны Улсын Хиагт хилийн боомтын үйл ажиллагаа, дэг журам, хяналт шалгалтын чанар, шалгалтын горимыг мөрдөн ажиллах явдал сайн бөгөөд тус хилийн боомтыг өргөтгөн 2016 онд ашиглалтад орсоноор зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх, цаашид Алтанбулаг, Хиагт боомтуудын ачаалал ихсэх төлөвтэй байна.

Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилийн тухай хуульд заасны дагуу хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтод мөрдөх журмыг хэрэгжилтийг хариуцах ба боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед хамгаалалтад авч, холбогдох байгууллагуудтай хамтран тусгай дэглэм тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2014 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Иргэд харилцан зорчих тухай гэрээ хэлэлцээрийн дагуу хоёр улын иргэд

[4] "Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам". ХХЕГ-ын даргын 2017.11.30. А/271 дугаар тушаал. 3 тал

харилцан 90 хоног визгүй зорчих болсон бөгөөд уг гэрээ нь 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөж, хоёр улсын иргэд харилцан визгүй зорчиж эхлээд байна.

Сүүлийн 3 жилд Алтанбулаг боомтоор зорчих Монгол иргэдийн тоо илт өсөөд байгаа бөгөөд шалтгаан нь 24 цагийн горимд шилжсэн, Монгол-Орос улсын иргэд харилцан визгүй болсон, рублын ханш унасан, ОХУ-ын бараа, хүнсний бүтээгдэхүүн, шатахуун зэргийг хямд үнээр оруулах, ОХУ-д жуулчлах таатай нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг болно.

Зураг 1. Хилийн ШНА-ны сүүлийн 10 жилийн үр дүнгийн судалгаа: /



Эх Сурвалж: Судалгааны ажлын хүрээнд

Улсын хилийн эрх ашигт хамааралтай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил зөрчигчийг эрж олох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах болон шаардлагатай үед дээр дурдсан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Тагнуулын болон Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж болно гэж хуульчилсан байна.

Онцгой нөхцөл байдлын тухай ойлголт: Аюулгүй байдлын ухаан нь хүн, нийгэм, төр улс болон байгаль, дэлхийн оршин тогтнох зүй тогтол дахь үнэт зүйлсийг хамгаалан хөгжүүлэх шаардлагад тулгуурладаг бөгөөд аюулгүй байдал судлалыг учирч болох аюул, заналын шинж чанар өөрчлөгдөн хувьсаж, илүү даяарших шинжтэй болсон өнөөгийн цаг үед аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршигийг бууруулах, арилгах талаар бие даасан өвөрмөц судлагдахуун бүхий судлал болохын зэрэгцээ аюулгүй байдлын судалгааны обьект нь улс орны дотоод, гадаад байдал, улс төрийн бодлого, нийгэм, хүрээлэн буй орчин[5] гэж үзэх хандлага түгээмэл байдаг.

Монгол Улсад онцгой байдлын тухай ойлголт нь 1992 онд үндсэн хуулиар тодорхойлсон өргөн хүрээтэй асуудал бөгөөд 1940, 1960 оны үндсэн хуулиудад "БНМАУ-д халдан товтлох буюу харийн товтолгооноос харилцан бие биеэ хамгаалах талаар олон улсын гэрээгээр авсан үүргээ биелүүлэх хэрэг тохиолдвол Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт дайны байдал зарлана[6]" гэж зөвхөн дайн бүхий байдлаар хязгаарлан ойлгож байсан.

Тодорхой нутаг дэвсгэрт осол,

[5] Сүхбаатар А. Аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн стратеги, гадаад, дотоод бодлогын үндсэн асуудал. УБ., 2014. 54 дэх тал

[6] Амарсанаа Ж. Монгол Улсын үндсэн хуулиуд. эмхтгэл. УБ., 2002. 16 дахь тал

байгалийн аюулт үзэгдэл, сүйрэл, байгалийн бусад гамшгийн улмаас хүний амь нас үрэгдэх, хүмүүсийн эрүүл мэнд буюу хүрээлэн буй байгаль орчинд гэм хор учруулах, материалын үлэмж хохирол бий болох, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагаа алдагдахыг онцгой нөхцөл байдал[7] гэж ойлгоно.

Онцгой нөхцөл байдал нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд гамшгийн улмаас тухайн улс орны нийгэм, эдийн засаг, дэд бүтцэд учруулсан хор уршиг, эвдрэл сүйрэл, аврах, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа, зам, эрчим хүчний сүлжээ, барилга байгууламжийг засах, сэргээн босгоход гаргасан зардал, хүн ам, мал, газар тариаланд сүүлийн 15 жилд учирсан хохирлын 45 хувь нь Азид, 33 хувь нь Хойд америкт, 12 хувь нь Европ тивд тус тус ноогдож байна.[8]

Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 7-д "Онц байдал зарлах тухай санаачлагчийн төсөл, Улсын Их Хурлын шийдвэр, эсхүл Ерөнхийлөгчийн зарлигт дор дурдсан зүйлийг заавал тусгана" гэж 7 дугаар зүйлийг тодотгосон бөгөөд 7.1-д "Онц байдал зарлах үндэслэл болсон онцгой нөхцөл байдал гэсэн нэр томъёогоо тодорхойлоогүй бөгөөд гагцхүү онц байдал зарлах хоёр үндэслэлээ тусгасан байна.

Онц байдал зарласан үеийн нөхцөл байдлын бус, түүнээс өмнөх шатны нөхцөл байдлын үед тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагаанд хэрэглэгдэж байгаа нэр томъёоны талаар авч үзвэл.

- Хил хамгаалах байгууллага-*"Онцгой нөхцөл байдал"*
- Цагдаагийн байгууллага-*"Онцгой нөхцөл байдал"*
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага-*"Хямралт байдал"*
- Зэвсэгт хүчний байгууллага-*"Онцгой нөхцөл байдал"*
- Онцгой байдлын байгууллага-*"Гамшиг"* гэсэн нэр томъёогоор эрх зүйн зохицуулалтадаа оруулсан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаандаа хэрэглэгдэж байгаа хууль тогтоомж, эрх зүйн актанд "Онцгой нөхцөл байдал" гэсэн нэр томъёогоор юуг хамааруулан ойлгож байгааг нарийвчлан тодорхойлж өгөөгүй.

ЗХЖШ, ТЕГ, ЦЕГ, ХХЕГ, ОБЕГ-ын даргын 2009 оны хамтарсан тушаалаар баталсан *"Онцгой нөхцөл байдал үүссэн үед харилцан ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөө"* батлагдсан байдаг.

Өнөөдөр хууль сахиулах байгууллагууд өөр өөрсдийн чиг үүргийнхээ хүрээнд онцгой нөхцөл байдал гэсэн нэр томъёог нэгдсэн нэг ойлголтойгоор эрх зүйн зохицуулалтадаа оруулж өгөх нь зүйтэй гэж бид үзэж байна.

"Онцгой байдал" гэж Гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг онцгой ажиллагаа явуулж байгаа нөхцөлийг хэлнэ[9] гэжээ.

"Онцгой нөхцөл байдал" гэж тодорхойнутагдэвсгэртосол,байгалийн

[7] Нарангэрэл С. Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. УБ., 2015. дөрөв дэх хэвлэл

[8] Даваадорж Г. Гамшиг ослоос хамгаалах тухай гарын авлага. УБ., 2006. 5 дахь тал

[9] Жавхланцогт В. Өвгөнбүргэд Ж. Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь. УБ., 2017. 79 дэх тал

аюулт үзэгдэл бусад гамшгийн улмаас хүний амь нас үрэгдэх, хүмүүсийн эрүүл мэнд буюу хүрээлэн буй байгаль орчинд гэм хор учруулах, материалын үлэмж хохирол бий болох, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагаа алдагдах нөхцөлийг хэлнэ[10] хэмээн тодорхойлсон байна.

Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэх асуудал нь нэг талаасаа боомтын аюулгүй байдалтай холбоотой ойлголт юм. Боомтын аюулгүй байдлыг хангах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томъёолж оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал байдал, мэдээллийн аюулгүй байдал гэсэн зургаан чиглэлээр цогц хэлбэрээр харилцан уялдаатай хангах, нийгэм, иргэдийн хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах шаардлагатай болсон.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, дэг журмыг сахиулах зорилгоор тухайн боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэх, ерөнхий зохицуулалтаар хангах, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг улсын хил хамгаалах байгууллага хэрэгжүүлнэ[11] гэж Монгол Улсын хилийн тухай хуульд заасан байна.

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ хэлэлцээр Монгол Улсын хилийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хилийн хяналтын байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлэх, дэг журам сахиулах, хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчид болон зорчигчдын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод гарч болзошгүй хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх илрүүлэх, таслан зогсоох, хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед *"Тусгай дэглэм тогтооож"*, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг Хил хамгаалах байгууллага зохицуулана[12] гэж хуульчилсан ба хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хилийн отряд /анги/-ийн штаб хэрэгжүүлж, хилийн цэргийн штаб мэргэжлийн удирдлагаар хангадаг.

Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс

Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны12 дугаар сарын 28-ны өдөр батлагдаж, 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр нийт 46 боомт үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс байнгын 24, түр 15, дамжин 7 байгаагаас олон улсын 14, хоёр талын ажиллагаатай 32 боомт байгаа ба автозамын 39, төмөр замын 3, агаарын 4 боомтод Хил хамгаалах байгууллага буцаад зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэн, боомтын аюулгүй байдлыг сахиулж, алба үйл ажиллагааг хоёр хөрш улстайгаа хилийн төлөөлөгчийн шугамаар уулзалт хийж, хилийн хяналт, шалгалтын байгууллагуудтайгаа хамтран ажиллаж байгаа билээ.

Энгийн нэг жишээ дурдахад 1998 онд өдөрт 200 машин үйлчлэх хүчин

[10] Ганболд М. Хилийн нэр томьёоны тайлбар толь. УБ., 2010. 37 дахь тал

[11] Хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг. // Төрийн мэдээлэл. 2017. № 06.

[12] "Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам". ХХЕГ-ын даргын 2017.11.30. А/271 дугаар тушаал.

чадалтайгаар байгуулагдаж байсан авто замын *"Замын Үүд"* боомтын цогцолборт өдгөө жирийн үед өдөрт 400-500, томоохон баяр ёслолын өмнө өдөрт 700-800 машин орж, гардаг, ажлын байрны багтаамж хангалттай бус, байцаагч нарын ажлын цагийн ачаалал их, гаалиар нэвтрэх тээврийн хэрэгслүүдэд ялгаа зааг байхгүй, өөрөөр хэлбэл хүн тээвэрлэлт болон ачаа тээвэрлэлтийн гарах, орох нэг байдаг.

Энэ нь үйлчлүүлэгчдийн бухимдлыг төрүүлэх нэгэн шалтгаан болдог. Мөн хилийн цэрэг, гааль, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагууд нь нэг байранд хэтэрхий давчуу байрласанаар өөр өөр чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагын ажилтнуудыг дүрэмт хувцасаар нь л ялгахгүй бол өөр боломж байхгүй байна. Зарим ажилтан стандартын бус нөхцөлд стандартын бус шаардлагыг тавьж ажилладаг.

Хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед ажиллах бүлгүүдийн зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгслийг хадгалах өрөөг стандарт шаардлагын дагуу тохижуулаагүй;

Монгол Улсын эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн хойшлуулшгүй ажиллагаа явуулахад хилийн боомтод түр саатуулах байргүй;

Зорчигч хилийн хяналтын байгууллагын алба хаагчдын эрүүл мэнд гэнэт муудсан тохиодолд яаралтай эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх цэггүй;

Хилийн боомтын шалган нэвтрүүлэх өнөөгийн хүчин чадал нь жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ачааллыг даахгүйд хүрч, үүнтэй холбоотойгоор боомтуудад тулгамдаж буй асуудлууд ар араасаа гарч ирэх болсон байна. Судалгааны ажлын хүрээнд бидэнд олдсон материал, газар дээр нь очиж танилцсан байдал зэрэгт дүгнэлт хийж үзээд хилийн боомтууд дээр сөргөөр нөлөөлж буй дараах чиглэлийн асуудлууд байна гэж үзэв. Үүнд:

Улсын хилээр нэвтрүүлэх үед үүсэх зорчигч, тээврийн хэрэгслийн бөөгнөрөл: Энэ асуудал нь хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал хэрхэн шууд нөлөөлж байгаагийн нэг илрэл гэж үзэж байна. Монгол Улсын эдийн засгийн хөгжил, ялангуяа экспорт импортын өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн хэрэгцээг хилийн боомтуудын дийлэнх хувь нь нэвтрүүлэх хүчин чадлын хувьд хангахгүй байгаагаас албаны үйл ажиллагаа, шалгалтын тоног төхөөрөмжийн хоцрогдол, боомтын бүтэц, орон тооны хүрэлцээгүй байдал зэргээс бөөгнөрөл гэгч нь үүсэх болсон байна.

Хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны доголдол буюу хүнд суртал: Хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь өөр өөрийн гэсэн хууль, тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэдэг босоо удирдлагын тогтолцоотой. Хилийн боомтод хяналт, шалгалт явуулах байгууллагуудын үйл ажиллагааг зөвхөн Засгийн газрын тогтоолоор зохицуулсан хэдий ч харилцан уялдаа холбоогүй, зарим тохиолдолд зөрчилтэй байгаа нь нэг ижил нөхцөлд ажиллаж байгаа байгууллага, албан хаагчдын харилцан адилгүй ажлын нөхцөл, цалин хангамж, хөнгөлөлт,

ахуй хангамж зэргээс харагдаж байна.

Хилийн боомтуудын зарим барилга байгууламж, дэд бүтцийн асуудал бусдын хараат болсон: Өөдлөх айл үүднээсээ гэдэг. Тэгэхээр Монгол Улсын үүд, хаалга болсон хилийн боомтууд маань төрийн мэдэлд бус зарим нэг байдлаараа бусдаас хараат болсон явдал. Ялангуяа урд хил дээр байгаа хилийн боомтууд цахилгааны эх үүсвэрээ урд хөршөөс авч байна. Энэ асуудал нь өөрөө бусдаас хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулах гэсэн зарчмыг зөрчиж байна.

Хилийн боомтын аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлууд: Хилийн боомтын аюулгүй байдлын талаарх асуудал нь цоо шинэ ойлголт биш бөгөөд Хил хамгаалах байгууллага шалган нэвтрүүлэх албыг хэрэгжүүлэх явцдаа бусад харилцан ажиллагаа бүхий байгууллага болох цагдаа, тагнуулын байгууллагуудтай хамтран хилийн боомтын аюулгүй байдлыг давхар хангаж ирсэн[13].

Үүнээс харахад хэдийгээр хилийн боомтын аюулгүй байдлыг сахиулах нь бидний өмнө нь хийж байсан ажил боловч нөгөө талаас гадаад улс орнуудын цагийн байдал, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдлаас улбаатай учирч болзошгүй эрсдэлт асуудлаас урьдчилан сэргийлэх зорилготой олон шинэлэг ажлуудыг зохион байгуулж, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх шаардлага бид бүгдэд тулгараад байгааг нуугаад байх шаадлагагүй.

Улмаар *"Аюулгүй байдал"* **гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарласан байна. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэгдэж болох нийтлэг агуулагдаж байдаг.**

Улс төрийн нэвтэрхий тольд: **"Аюулгүй байдал- дэлхийн нийгэмлэг, улс нийгэм хүний амьдралын оршин тогтнох үндсэн чухал язгуур эрх ашиг сонирхол гадны болон дотоодын аюуд заналаас найдвартай хамгаалагдсан байдал",**

Британика нэвтэрхий тольд: **"Аюулгүй байдал амар тайван бат бэх итгэлтэй байх нөхцөл байдал аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх",**

Оксфордын Англи хэлний тольд: **"Аюулгүй байдал амар тайван бат бэх итгэлтэй байх нөхцөл",**

ХХЕГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны А/271 дугаар тушаалд: **Хилийн боомтын аюулгүй байдал гэж тухайн боомтоор улсын хил нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, хилийн хяналтын байгууллагуудын болон хилийн боомтод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчид хилийн боомтын хяналт шалгалтын бүсэд байх үедээ аливаа гэмт халдлагын болохгүй байх бололцоо бүрдэхийг хэлнэ гэж заасан байна.**

Тиймээс Хилийн цэргийн штабаас "Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам"-ыг боловсруулан Хилийн боомтын үндэсний зөвлөлийн тогтолоор батлуулсан. Уг нийтлэг журмыг үндэслэн хилийн боомт бүхий ангиуд "Хилийн боомтод мөрдөх журам"-ыг хилийн хяналтын байгууллагуудтайгаа хамтран боловсруулан батлаж, хилийн

[13] Пүрэвбаасан В. "Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах арга зам". УБ., 2015. Хилчин эмхэтгэл №3. 34 дахь тал.

боомтод мөрдүүлэн ажиллаж байна. Уг журам нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, онцгой нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх чухал арга хэмжээ юм.

"Хилийн боомтод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам" болон хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед хилийн ангиудын ажиллагааны урьдчилсан төлөвлөгөөг Хилийн цэргийн командлагчаар батлуулсан ба хилийн боомтуудын "Дохиолол-хяналт-хамгаалалтын нэгдсэн систем"-ийн бодлогыг боловсруулан хил хамгаалах байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмын хэрэгжилтийг хил хамгаалах байгууллага хариуцна[14];

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, дэг журмыг сахиулах зорилгоор тухайн боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэх, ерөнхий зохицуулалтаар хангах, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг улсын хил хамгаалах байгууллага[15] хэрэгжүүлнэ;

Боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага гарах, гоц халдварт өвчин тархах зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед боомтыг хил хамгаалах байгууллага хамгаалалтад авч, холбогдох байгууллагатай хамтран тусгай дэглэм тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулна[16];

Дээрх хууль эрх зүйн баримт бичгүүдэд заагдсан аюулгүй байдлын талаарх ойлголт, түүнд тохирсон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Дэлхийн улс орнуудын хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд гарч буй өөрчлөлт: Өнөөдөр дэлхийн улс орнууд хилийн боомтын хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулахад олон хүчин зүйлс нөлөөлж байгааг онцлоход террорист халдлага, хар тамхи, хүний наймаа, цагаачлалын зэрэг асуудлуудыг анхаарч үздэг байна. Үүний тод жишээ нь Европын холбооны улсуудын нээлттэй байдал буцаад хаагдмал хэлбэрт шилжиж байгаагаар илэрч байна.

Олон улсын хэмжээнд 2017 оны судалгаанаас харахад нийт 43 оронд 3205 террорист халдлага үйлдэгдсэн байдаг. Үүнийг объектоор нь ангилбал хүн ам олноор төвлөрсөн газарт 734, онц чухал объектод 1173, нийтийн барилга байгууламжид 597, хурал цуглаан шашны байгууллагын үеэр 220, нисэх, төмөр замын буудалд 481 террорист үйлдэл гарсан байгаа юм. Халдлагад өртсөн объектуудын 37.1 хувь нь онц чухал объект байсан.[17]

"Терроризм" гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг[18] хэлнэ.

[14] Хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. // Төрийн мэдээлэл. 2017. № 06.

[15] "Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам". ХХЕГ-ын даргын 2017.11.30. А/271 дугаар тушаал. 1 тал.

[16] Хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. // Төрийн мэдээлэл. 2017. № 06.

[17] http://ulsturch.mn/index.php?view

[18] Терроризмтой тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дахь хэсэг. 2004.04.23.

Орчин үеийн террористуудын халдлага үйлдэхээр санаархдаг объектууд нь хууль сахиулах байгууллагуудын барилга, олон нийтийн байгууллагууд, удирдлагын байр, дипломат болон бусад гадаадын төлөөлөгчийн газар, улс төрийн байгууллага, нам эвсэл, бүлэг, хүчний байр болоод байна. Сүүлийн үед террористууд улс төрийн болон шийдвэр гаргах, эрх мэдэл бүхий төрийн албан тушаалтан болон өндөр дээд хэмжээний зочин төлөөлөгчдөд халдах хандлага нэмэгдээд байгаа.

Дэлхийн олон улс орон уг эрсдэлт асуудлаас урьдчилан сэргийлэх үүднээс хилийн боомтын оюулгүй байдлыг хангах ажиллагааг цэрэг, цагдаагийн байгууллагад хариуцуулдаг нь доорх баримтаас харагдаж байна. Үүнд: АНУ, Европын холбооны улс, БНХАУ, ОХУ, тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн орнууд, Балтын тэнгисийн орнууд, Египед, Швейцарь, БНСУ, Болгар, Польш, Румын, Энэтхэг зэрэг 30 орны хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд судалгаа хийхэд хилийн албаар /Хилийн цэрэг, хилийн аюулгүй байдлын хүчин, хилийн харуулын алба/-14, хилийн цагдаагаар-11, цагаачлал, хилийн хяналтын байгууллагаар-5, хил хамгаалах, гаалийн товчоогоор-1 улс зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр шалган нэвтрүүлэх чиг үүргийг гүйцэтгүүлдэг[19] байна.

АНУ-ын жишээн дээр орон нутгийн болон хилийн аюулгүй байдлыг хангахын тулд улс төрчид холбогдох албаныхан шинэ байж болох гарцыг эрж хайсаар байна. Үндэсний Агаарын Хамгаалалтынхнаас зайнаас удирдах бичил нисдэг төхөөрөмжийг хил хамгаалах албанд хэрэглэн, үүнийг хэрэглэх нь хил хамгаалахад их тустай, ахицтай болохыг онцлоод, хилийн зөрчил, хилийн өөрчлөлтийг илрүүлэхээр тэнгисийн хар тамхитай тэмцэх албаныхан шийдвэр гаргагчидад анхаарч үзэхийг хүсээд байгаа юм байна.[20]

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй олон улсын 14 боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагааг олон улсын түвшинд хүргэх нөхцөл боломжийг тодорхойлоход дараах зүйлсийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Тагнуулын байгууллагын эх сурвалжаас авсан мэдээллээр сүүлийн 10 жилд манай улсад терроризмын шинжтэй 19 удаагийн гэмт хэрэг бүртгэгджээ. Хүний эрүүл мэнд, амь насанд аюул занал учруулж болзошгүй дээрх хэргүүдийн ихэнхийг ТЕГ, ЦЕГ-ын ажилтнууд урьдчилан илрүүлж, таслан зогсоосон юм.[21]

Хил хамгаалах байгууллагатай холбоотой ойрын гарсан жишээг дурдвал: Хэдэн жилийн өмнө бусдын нэр дээр бүртгэлтэй Юнителийн дугаарыг ашиглан "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудалд "тэсрэх бөмбөг тавьсан" гэх хуурамч дуудлага өгсөн иргэнийг цагдаагийнхан шалгасан. Мөн 2012 оны наймдугаар сард нисэх онгоцны буудлын олон улсын бүртгэлийн танхимд сургуулилтын тэсрэх бөмбөг тавьсан хэрэг гарсан. Хүчний бүхий л байгууллагыг түргэн авахуулсан энэ үйл явдлын буруутнаар манай улсад цэргийн хээрийн хамтын сургуулилт хийгээд тухайн өдөр

[19] Дорлигжав Д. "Монгол улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал". УБ., 2015.

[20] http://www.rand.org/pubs/research_reports/RR1016.html

[21] WWW.dornod.net/i/1616 "Монгол дахь бидний мэдээгүй террорист халдлагууд"

буцсан америк цэргүүд буруутай гэх юм билээ.[22] Бид бүгдэд зөвхөн гадаад улс орнуудад л гардаг гэсэн ойлголттой террорист үйлдэл нь өнөөдөр манай оронд, тэр дундаа хилийн боомтод гарахгүй гэх газаргүй болсон нь дээрх үйл явдлуудаас харагдаж байна.

Монгол улс 1990-2000 хүртлэх хугацаанд даяаршил нэгдэн, эдийн засгийг нээлттэй болгох, ашигтай үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс хилийн боомтоор зорчигч тээврийн хэрэгслийг "Хурдан шуурхай-аюулгүй" гэсэн дарааллаар нэвтрүүлдэг байсан бол 2000 оноос өнөөг хүртэл дэлхийн олон улс орны жишгийг дагаж "Аюулгүй-хурдан шуурхай" гэсэн бодлогыг барьж байгаа нь онцлог асуудал юм.

Сүүлийн жилүүдэд зарим хилийн боомтууд /Замын-Үүд АЗШНБ, Хавиргын боомт, Булган боомт, Алтанбулаг боомт, Ханх боомт/ хилийн төлөөлөгчийн шугамаар харилцан ажиллах төлөвлөгөөндөө тусган хөрш орнуудтайгаа хамтран боомтын болон иргэд зорчигчдын аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үйлдлийг таслан зогсоох дадлага, сургуулийг хийж байгаа нь хилчдийн мэдлэг, дадлага чадварыг дээшлүүлсэн, харилцан туршлага солилцсон, шинэлэг, өндөр ач холбогдолтой ажлууд болж байгаа билээ.

Телекамерын хэрэгслийг алба үйл ажиллагаандаа ашигласнаар боомтын хэсгийг бүрэн хяналтандаа авч, хууль бус үйлдлийг цаг тухайд нь илрүүлэх, баримтжуулах, боомтын аюулгүй байдлын эсрэг үйлдлийг таслан зогсоох ажиллагааг удирдах, зохион байгуулах боломжийг дээшлүүлсэн зэрэг ач холбогдлууд гарч байна.

Хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчдын аюулгүй байдал нь тухайн албан хаагч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн үзлэг шалгалт хийх бололцоо бүрдсэнээр;

Зорчигчдын аюулгүй байдал нь тухайн тээврийн хэрэгсэл, тээвэрлэж байгаа ачаа нь аливаа халдлагын обьект болохгүй байх бололцоотой болсоноор;

Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал нь тухайн тээврийн хэрэгсэл, тээвэрлэж байгаа ачаа нь аливаа гэмт халдлагын обьект болохгүй байх бололцоо бүрдсэнээр тус тус хангагдана.

Олон улсын боомтуудад хамгаалалт, аюулгүй байдлыг сахиулах чиг үүрэгтэй ажиллаж байгаа хилчдийн төлөөлөлтэй холбогдож зарим зүйлсийг тодруулахад боомт тус бүр дээр онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөг хоёроос дээш хувилбартайгаар боловсруулж, түүний дагуу дадлага сургууль хийж байгаа боловч хамгаалалтын тусгай хэрэгсэл, бусад техник хэрэгслийн хангалт дутмаг байгаагаас учирч болох эрсдэлт асуудлыг таслан зогсоох магадлал бага гэсэн дүгнэлт гарч байна. Мөн зарим хилийн боомтууд хамгаалалтын тусгай хэрэгслээр хангагдсан боловч түүнийг хэрэглэх эрх зүйн орчинг бүрэн судалж, ашиглаж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Хилийн боомтод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь хилийн хяналтын байгууллагын хяналт шалгалт явуулах бололцоог бүрдүүлэх, дэг журам сахиулах, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох,

[22] WWW.dornod.net/i/1616 "Монгол дахь бидний мэдээгүй террорист халдлагууд"

онцгой нөхцөл үүссэн үед хэрэгжүүлэх цогц арга хэмжээнээс бүрддэг.

Хөрш зэргэлдээ болон хөгжингүй зарим улс орнуудын хилийн боомтын эрх зүйн зохицуулалт

Оросын Холбооны Улсын хилийн боомтын эрх зүйн зохицуулалтын талаар:

ОХУ-ын хууль тогтоомжууд нь ерөнхий зарчим, үзэл баримтлалараа тусгаар тогтносон улсуудын холбооны *(Союз Независимых Государств)* хууль эрх зүйн хэм хэмжээнд ихээхэн нөлөөлдгөөрөө бусад улсуудын хууль эрх зүйн орчноос ялгаатай байдаг байна.

Оросын Холбооны Улс нь *"Хилийн боомтын тухай"* хуулийн төслийг 2011 оны 04 дүгээр сарын 27-нд өргөн барьсан.

ОХУ-ын улсын хилийн байгууламжийг хариуцах холбооны агентлагийн тухай: Тус холбооны агентлаг *(Росграница)*-ыг байгуулах талаар Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн № 734 тоот тогтоолоор баталсан байна.

Оросны Холбооны Улсын Ерөнхийлөгч Путин.В.И нь *(Росграница)*- агентлагийг 2016 оны 10 дугаар сарын 02-ны өдөр татан буугдаж, Зам тээврийн яаманд хариуцуулж өгсөнөөр *"Росгранстрой"* нэртэйгээр үйл ажиллагаа нь улам өргөжсөн байна.

БНХАУ-ын хилийн боомтын талаарх эрх зүйн орчны талаар:

БНХАУ-нь 9.6 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, газар нутгийн хэмжээгээр дэлхийд гуравдугаарт ордог. Хүн ам нь 1.3 тэрбум буюу дэлхийн хүн амын 22 хувийг эзэлдэг.

Хятад улс ОХУ-тай стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж, Европын Холбоотой харилцаагаа идэвхижүүлэн, АНУ-тай байнгын хэвийн харилцаа тогтоохыг эрмэлзэж байна.

БНХАУ нь хөрш зэргэлдээ улс орнуудтай хамтын ажиллагаа, харилцааг сайжруулахад онцгой анхааралд авч төрийн бодлогоор хил орчмын нутаг дэвсгэр, ард иргэдийг хил орчим суурьшуулах бодлогыг хэрэгжүүлж байгаа нь үр дүнгээ өгч байна.

БНХАУ нь хилийн боомтын талаарх хууль эрх зүйн орчинг Засгийн газрын тогтоолоор баталсан дүрмээр зохицуулан хэрэгжүүлдэг байна.

Хилийн шалган нэвтрүүлэх боомтыг усан, агаарын, авто болон төмөр замын буудал зэрэг хилийн нээлттэй гарцуудад байгуулна гэж тусгасан байна.

Хилийн боомтод эрх олгогдсон энэхүү байгууллагын үүргийг тодорхой тусгасан ба хуулийн хүрээнд үүргээ гүйцэтгэж буй ШНБ-ын ажилтанд ямарч байгууллага, хувь хүн саад хийх эрхгүй хэмээн бүрэн эрхийг тодорхойлж өгсөн байна.

Шенгений хэлэлцээрт нэгдэн орсон зарим орнуудын хилийн боомт, хяналт шалгалтын талаарх хууль эрх зүйн зохицуулалтын талаар:

Европын эдийн засгийн холбоог байгуулж, түүний оршин тогтнох гол зорилго нь дөрвөн эрх чөлөө гэж нэрлэгдэх бүх нийтийн зах зээлийг байгуулах, түүнд бараа таваарын шилжилт, эргэлт, хүмүүсийн хөдөлгөөн, хөрөнгө оруулалт, үйлчилгээг чөлөөтэй болгох явдал мөн гэж тунхагласан байдаг.

Хилийн хяналт шалгалтаас

алгуур татгалзах талаарх баримт бичгийг 1985 оны 6 дугаар сарын 14-нд Люксембург, Франц, Холбооны Герман Улсын хилийн заагт оршдог Мозел голын эрэгт“ Принцесса Мари-Астрид” хөлөг онгоцон дээр Бельги, Люксембург, Франц, Нидерланд, Герман улсуудын албаны төлөөлөгчид хоорондоо хэлэлцэж баталсан байна. Тус хэлэлцээр болсон газрын ойролцоох Шенген нэртэй тосгоны нэрээр уг хэлэлцээрийг Шенгений гэж нэрлэх болжээ. Дээрх хэлэлцээрийн үр дүнд эдгээр улсын хоорондын хил дээр хилийн хяналт шалгалтыг хөнгөвчилж улмаар татгалзах эрх зүйн орчныг бий болгож, Шенгений хэлэлцээрийг 1990 онд эдгээр 5 улс үйл ажиллагаандаа шууд нэвтрүүлэх талаар конвенцийг баталж мөрдөж эхэлсэн байна.

Словени Улсын хилийн боомтын талаарх хууль тогтоомж: Бид судалгаандаа Шенгений хэлэлцээрийн бүсэд багтах аль нэг орны хилийн боомтын тухай хууль эрх зүйн орчныг судлах ёстойгоос Словени улсыг сонгож авсан болно.

Шенгений хэлэлцээрийн бүсэд багтах бүх орон өөрийн үйл ажиллагаандаа Европын холбооноос гаргасан хууль тогтоомжуудыг мөрддөг бөгөөд дотооддоо гаргасан хууль тогтоомжууд нь ерөнхий зарчмын хувьд ойролцоо байна.

Словени улс нь Европ тивийн төвд оршдог, Европын холбоо, Европын зөвлөл, НҮБ-ын болон НАТО-гийн гишүүн орон, Шенгений хэлэлцээрийн бүсэд хамрагддаг. 2009 оны байдлаар 2 сая хүн амтай, 12 бүс, 210 нэгдлээс бүрдэнэ.

Словени улс нь “Улсын хилийн хяналтын тухай” хуулийг нэмэлт өөрчлөлт оруулан хамгийн сүүлд 2010 оны 4 дүгээр сарын 20-нд Үндэсний хурлаар батлан гаргасан.

Украйн Улсын хилийн боомтын тухай хууль эрх зүйн зохицуулалтын талаар:

Украйн улс нь Зүүн Европын орнуудын тоонд ордог, 1992 он хүртэл хуучин Зөвлөлт Холбоот улсын бүрэлдэхүүнд байгаад түүнээс хойш бие даан тусгаар тогтносон, 24 муж, улсын зэрэглэлийн 2 хот, Крымын автономит улсаас бүрдэнэ. 2012 оны 2 дугаар сарын байдлаар 45 сая 617 мянга 542 хүн амтай.

Украйн улс дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр дэлхийд 39-р байранд ордог ба экспортод чиглэсэн эдийн засагтай, 4500 км урт хилтэй. Улсын хилээ Украйн улсын хилийн албаны хүчээр хамгаалдаг. Улсын хилээр нэвтрүүлэх болон хилийн боомтуудыг тус улсын хилийн алба хариуцдаг. Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Европын холбоотой хамтын ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд “Хилийн тухай” Шенгений хуульд нийцүүлэн улсын хилийг нэвтрэх олон улсын норм, журам, хилийн боомтын үйл ажиллагааны нэгдсэн горим зэргийг энэхүү хуулиар зохицуулсан байна.

Уг хуулийг Европын холбоо, АНУ-ын төрийн департаментын санхүүжилт, Польшийн хуульч нарын оролцоотойгоор хоёр жилийн хугацаанд боловсруулсан байна. Украйн Улсын *“Хилийн хяналт шалгалтын тухай”* хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсанаар 2010 оны 12 дугаар сарын 02-нд баталсан байна.

Хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ, Европын холбоо болон түүний гишүүн Словен, Украйн улсуудын “Хилийн боомтын тухай хууль”-уудыг

харьцуулан судалж, дүн шинжилгээ хийхэд хилийн шалган нэвтрүүлэх албаны олон талт үйл ажиллагааг зохион байгуулахдаа хууль эрх зүйн зохицуулалтыг нь бүрэн гаргасан нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд хоёрдмол санаагүй байгаа нь харагдаж байна.

Хилийн боомтын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд

Дэлхийн улс орнуудын хилийн боомтууд ачааллыг хэрхэн яаж зохицуулж байна, шалган нэвтрүүлэх алба, ачааллыг яаж шуурхай нэвтрүүлж байна гэдгийг судлах, үүний үр дүнд манай улс хилийн боомтуудаа дэлхийн жишигт хүргэх арга замыг олох, түүнд хүрч чаддаггүй юмаа гэхэд хөрш орнуудынхаа хилийн боомтуудын шалган нэвтрүүлэх хүчин чадалд хүргэх үндсэн гол шаардлага гарч байна.

Дэлхийн даяаршилыг дагаад зарим улс орнууд нэгдмэл холбоо үүсгэн улсын хилээр хялбарчилсан журмаар өөр хоорондоо зорчих, тэр зарчмаар бусад улс оронтой гэрээ хэлэлцээр хийн, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч, эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Хэдийгээр энэ асуудалд зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг улсын хилээр шуурхай нэвтрүүлэх гол зарчмыг баримталж байгаа хэдий боловч, нөгөө талаараа хилийн аюулгүй байдал алдагдахад хүргэж болзошгүй юм. Энэ нь цаашлаад олон улсын шинжтэй үндэстэн дамнасан гэмт үйлдлүүдийг даамжруулах шалтгаан нь болж байна.

Сүүлийн үед харьцангуй хөгжилтэй улс орнууд өндөр техник технологи дээр тулгуурлан баримт бичгийн нууцлалыг нарийвчлан шалгах, хувь хүний бичиг баримтанд эзэмшигчийн тодорхой мэдээллийг агуулсан чипийг байрлуулж, улсын хилээр нэвтрэх үед нь мэдээллийн нэгдсэн сүлжээнээс эзэмшигчийн баримт бичиг мөн эсэхийг батлах, биометрийн багаж ашиглан улсын хилээр шалгаж нэвтрүүлэх зэрэг хяналт шалгалтын шинэ шинэ арга ажиллагаанд шилжиж байна.

Манай улсын хувьд эдгээр бэрхшээл, сөрөг үзэгдэл, төр засгийн бодлого, түүний хэрэгжилтийн алдаанууд нь асуудлын нэгээхэн хэсэг гэж ойлгох нь зүйтэй.

Өнөөдрийн байдлаар хилийн боомтод ажилладаг төрийн байгууллагууд нь босоо удирдлагатай, бие биенээс хараат бус, нэгдмэл ажиллагаа сул, эрх зүйн орчин нь тодорхойгүй байна.

Түүнээс гадна улсын хилээр зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг түргэн шуурхай нэвтрүүлэх олон төрлийн тоног төхөөрөмжийг боомтод суурилуулан үйл ажиллагаанд нь ашиглаж байна, мөн тэдгээрийг хөрш зэргэлдээ улс орнууд туршаад эхэлжээ. Иймд шинэ дэвшилтэт техник технологийг хилийн боомтдоо нэвтрүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

"Хилийн боомтын тухай хууль" 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнээс хойш Хил хамгаалах байгууллага тус хуулийн 7 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх үүргийг хүлээгээд өдгөө 3 дахь жилийнхээ нүүрийг үзэж, Монгол Улсын хилийн тухай хуулийг 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталж, 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлснээр *"Хилийн боомтын тухай хууль"* хүчингүй болсон;

Монгол Улсын хилийн тухай хуулийн 29.1, 29.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 93 дугаар тогтоолоор *"Хилийн боомтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн"*-ийг баталсанаар *"Боомтын үндэсний зөвлөл байгуулах тухай"* Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 44 дүгээр тогтоол, *"Боомтын нэгдсэн захиргаа байгуулах тухай"* Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсон;

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 139 дүгээр тогтоолын хавсралтаар *"Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дүрэм"***-ийг баталсан;**

Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2017 оны 001 дүгээр тогтоолоор *"Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам"*-ыг баталсан;

Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 001 дүгээр тогтоолыг үндэслэн Хилийн бүрэн эрхт төлөөлөгч "Хилийн боомтод мөрдөх журам"-ыг баталж, хилийн хяналтын байгууллагууд зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Хилийн боомтод үүссэн онцгой нөхцөл байдлын үеийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үеийн ажиллагаанд Монгол Улсын хилийн тухай хууль, Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны дүрэм, Хил хамгаалалтын дүрэм, Хил хамгаалах албаны бэлэн байдлын журам, Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам, Засгийн газрын 2015 оны 491 дүгээр тогтоолоор батлагдсан Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Тагнуул, Цагдаа, Онцгой байдал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгоно.

Улсын хилийн зурвас, хилийн боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, хүн барьцаалсан, тээврийн хэрэгсэл ашиглан бусдын аюулгүй байдалд эрсдэл үүсгэсэн, террорист халдлага гарсан, байгалийн гамшиг тохиолдсон, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үеийг онцгой нөхцөл үүссэн гэж ойлгоно.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-д Хилийн боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гамшиг, онцгой нөхцөл үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран тусгай дэглэм тогтоож, зохион байгуулалтын арга хэмжээ авна гэж заасан байна.

Хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үеийн ажиллагааны урьдчилсан төлөвлөгөөг боловсруулж, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай үүссэн цагийн байдлын үед ажиллах дадлага сургуулилтыг чанартай зохион байгуулснаар хангагдана.

Монгол Улсын Засгийн газраас хилийн боомтуудын талаар гаргасан тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх: Засгийн газраас батлан гаргасан "Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай" 2010 оны 06 дугаар тогтоол, "Боомтуудын ерөнхий төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт батлах тухай" мөн оны 102 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын сайд,

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 201/164 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгийн "Боомтуудыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний санал", 2010 оны 04 дүгээр сард хилийн зарим боомтын үйл ажиллагаа, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээр, дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан УИХ-ын Дэд дарга Г.Батхүүгээр ахлуулсан ажлын хэсгээс гаргасан санал байсан;

Одоо мөрдөж буй Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 139 дүгээр тогтоолын хавсралтаар *"Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дүрэм"*-**ийг баталсан;**

Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2017 оны 001 дүгээр тогтоолоор *"Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам"*-ыг баталсан;

Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 001 дүгээр тогтоолыг үндэслэн Хилийн бүрэн эрхт төлөөлөгч "Хилийн боомтод мөрдөх журам"-ыг баталж, хилийн хяналтын байгууллагууд зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа баримт бичгүүд өнөөдрийн байдлаар байгаа боловч хэрэгжилт нь тун удаан, үр дүн нь тийм тодорхой харагдахгүй байна.

Хилийн боомтуудыг олон улсын болон Монгол Улсын авто ба төмөр зам, тээврийн сүлжээнд холбох асуудлыг одоогийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийх бүрэн боломжтой ч энэ ажлыг эрс эрчимжүүлэхийг улсын эдийн засаг, уул уурхайн өсөн нэмэгдэж буй экспорт, импортын бүтээгдэхүүний эргэлт шаардаж байна.

Монгол Улсын хувьд Хилийн боомтын тухай хуулийг хүчингүй болгож, Хилийн тухай хуульд зүйл, заалтаар нь оруулсан хэдий ч хилийн шалган нэвтрүүлэх албаны олон талт үйл ажиллагааны зохицуулалт бүрэн тусгаагүй учир дутагдалтай байна.

Одоо хилийн боомтын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах Монгол Улсын засгийн газрын 2 тогтоол байдаг, зөвлөлийн даргаар сангийн сайд томилогдсон боловч боомтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, техник технологийн шинэчлэл хийх талаар дорвитой ажил хийгдээгүй.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид дээрх орнуудын хилийн боомтын тухай хуулийн дэвшилтэд шинэлэг зүйл заалтуудыг тусгах, эсвэл тусдаа хилийн боомтын тухай хуультай болох нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Олон улсад үзүүлж буй шашны хэт даврагсадын террорист халдлага бидэнд алс хол сонсогдож байсан бол өнөөдөр уг үйлдэл хил хязгааргүй, хаана, хэзээ гарах эсэх нь эргэлзээтэй асуудал болж байгаад хилчид бид дүгнэлт хийн цаашид шат дараалсан тодорхой ажлуудыг зохион байгуулах цаг нь болсон гэж бид үзэж байна. Үүнд:

1. Боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөг тогтсон хэв загвараас гадна гадаад улс орнуудын боомтуудад гарч өнгөрсөн гэмт хэрэг, хууль бус үйлдлийн эсрэг авч хэрэгжүүлсэн жишээг судлаж, олон хувилбартайгаар боловсруулах;

2. Боомтын хамгаалалт, аюулгүй байдлын чиглэлээр холбогдох албан

тушаалтанг сургаж, дадлагажуулах замаар мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, түүнчлэн олон улсад ашиглагдаж байгаа чанарын шаардлага хангасан тусгай хэрэгсэл, техникээр хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр боомтын хамгаалалтын бүлгүүдийн үүрэг гүйцэтгэх чадамжийг дээшлүүлэх;

3. Боомтуудын хяналт шалгалтын бүсийг телекамерын хяналтад бүрэн оруулах, мэргэжлийн оператор хянагчийг ажиллуулах нь журам дэглэмийг хянах, түргэн шуурхай шийдвэр гаргах, эмх замбараагүй байдал үүссэн үед түүнийг баримтжуулах зэрэг олон ашигтай давуу талуудтай.

Дээрх шат дараалсан ажлуудыг үр дүнтэйгээр зохион байгуулснаар хилийн боомтын аюулгүй байдлыг хангагдаж онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлнэ гэж бид дүгнэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ., 2001 он
3. Монгол Улсын Батлан хамгаалахын тухай хууль. УБ., 2016 он
4. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2017 он
5. Монгол Улсын Терроризмтой тэмцэх тухай хууль. УБ., 2004 он
6. Онц байдлын тухай хууль. УБ., 1995 он
7. Дайны байдлын тухай хууль. УБ., 1998 он
8. Гамшгаас хамгаалах тухай хууль. УБ., 2003 он
9. Тагнуулын байгууллагын тухай хууль. УБ., 1999 он
10. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002 он
11. Хилчин эмхэтгэл. УБ., №3. 2015 он
12. Арвай.Ш Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого.
13. Монгол хэлний их тайлбар толь. УБ., 2016 он
14. Монгол Улсын засгийн газрын тогтоол. Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дүрэм. Дугаар 174. УБ., 2017 он
15. Боомтын үндэсний зөвлөлийн тогтоол. Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам. УБ., 2017 он
16. "Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам". ХХЕГ-ын даргын А/271 дугаар тушаал. УБ., 2017 он

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээлүүд:

1. Монгол улсын хил хамгаалалтын дүрэм I" Хилийн отряд. УБ., 2007 он
2. ЖавхланцогтВ.,Өвгөнбүргэд.Ж Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь. УБ., 2017 он
3. Ганболд М. Хилийн нэр томьёоны тайлбар толь. УБ., 2010 он
4. Пүрэвбаасан В., Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах арга зам. Хилчин эмхэтгэл. УБ., 2015 он
5. Хилийн боомтын үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах арга зам. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017он
6. Ганболд Ц., Хилийн төлөөлөгчийн ажиллагаа. УБ., 2006 он
7. Муратхан А., Хилийн боомтуудад судалгаа хийх шаардлага өнөөгийн байдал, эрх зүйн орчин судалгааны ажил. УБ., 2008 он

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ХЭВЛИЙН ХИЛИЙН ХАМГААЛАЛТ

Б.Амармэнд
Магистр, хошууч
Хилийн 0168 дугаар анги

Дэлхийн аль ч улс оронд хилийнхээ хүрээнд төрийн тодорхой хүчин чармайлтын үндсэн чиглэл, арга зам, түүний хилкйн аюулгүй байдлыг хангах системийн нөхцөл, шинжлэх ухааны үндэстэй хилийн бодлого, стратеги хэрэгжиж байдаг.

Монгол Улс газар зүйн байршлаараа дэлхийн геополитикийн сонирхлын хүрээнд багтсаар иржээ. Монгол Улс "Атлантаас Номхон далай хүрэх" геополотикийн шугам, "Дэлхийн зүрхэн газар" Ази тивийн геостратегийн чухал түшиц нутаг, их гүрнүүдийн геополитик, эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын уулзвар, цэрэг, стратегийн бодлого, дэлхийн том шашнуудын нөлөөллийн зах нийлсэн бүсэд оршиж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын харилцааны шинж чанар, уур амьсгал нааштгайгаар өөрчлөгдөж хилийн аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болсон ч газрын хэвлийн хилийн аюулгүй байдлын талаар нэгдсэн ойлголт дутмаг байгаагаас ашиг сонирхлын бүлэглэлүүд улс хоорондын газрын хэвлийн хилийг зөрчих асуудлууд гарсаар байна.

Монгол Улс нь өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангаж үндэсний язгуур эрх ашгаа урьтал болгосон, тогтвортой хөгжлийн асуудлаа шийдвэрлэх бие даасан бодлого баримталж байгаа боловч дэлхий дахинд эдийн засаг, хүн ам, техник технологи, цэрэг техникийн хүчээр тэргүүлэх хэмжээний хоёр улсын дунд оршдог геополитикийн өвөрмөц онцлогтой бөгөөд хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах орчин үеийн шинэ техник технологийн ололтыг тухай нийгмийн хөгжилд нийцүүлэн нэвтрүүлж, хил хамгаалалтыг боловсронгуй болгох, хилийн аюулгүй байдлыг найдвартай хангах үндсэн үүргийг хэрэгжүүлж байгаа ч газрын хэвлийн хилийг хамгаалах түүний бүрэн бүтэн байдлыг цаашид хангах талаар дутмаг байгаа нь зайлшгүй судлах шаардлага үүссэж байна.

"Чухам энэ үүднээс улс орон бүр хил хязгаарын аюулгүй байдалдаа онцгой анхаарч төрийн бодлогодоо хилийн асуудлыг тусгайлан авч үзэж, дэлхий дахины асуудлыг эрхлэн байдаг НҮБ-аар хил хязгаараа баталгаажуулан, ул орныхоо хаяа хатавчийг сахин хамгаалж ирсэн бөгөөд тусгаар байх, бүрэн эрхт байх явдалд учирч болох аюул заналыг улс орон бүр янз бүрийн түвшинд авч үзэж байгаа боловч нэгэнтэй хил хязгаарын бүрэн бүтэн халдашгүй байдал түүнтэй холбогдох олон талт асуудлыг бүхэлд нь авч үзэж буй "Хилийн аюулгүй байдал" хэмээх

ухагдахууныг дийлэнх улс орнууд хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдлынхаа нэгэн чухал асуудал болсон"[1] ч газрын хэвлийн хил гэдэг ойлголтыг шинжлэх ухааны түвшинд судлан эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, газрын хэвлийд буюу хил дамнасан байгалийн баялгийг хамгаалах түүнд хяналт тавих, газрын хэвлийн хил зөрчигдөхгүй байхад анхаарах нь өнөө үед тулгамдаж байгаа асуудал мөн болно. "Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг"[2] мөн бөгөөд газрын харилцаатай холбоотой манай улсын хуульд доорх байдлаар газрын хэвлийг тодорхойлсон байна. Үүнд:

Газрын хэвлийн тухай хуульд: Газрын хэвлий гэж. "Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай түүний эзлэх орших материалаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ[3].

Газар болон газрын харилцаатай холбоотой Газрын тухай[4], Газрын хэвлийн тухай[5], Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай[6] зэрэг хуулиуд батлагдан гарч Монгол Улсад газрын эрх зүйн харилцаа бэхжсэн гэж үзэж болохоор байна. Гэвч зах зээлийн эдийн засагт эргэлт буцалтгүй орсон манай улсын хувьд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялагаа ашиглах зэрэг газартай холбоотой олон талт үйл ажиллагаа явагдаж эхэлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд хилийн бүс, зурваст байгалийн баялаг олборлох, зорилго бүхий аж ахуйн нэгж байгууллага, уул уурхай, нефть боловсруулах үйлдвэрүүд эрс нэмэгдсээр байна.

Цаашид ашигт малтмалын орд газар эрчим хүчний нөөцийг ашиглах, газар доорхи барилга байгууламж барих, үйлдвэрийн хаягдал, нефть хий бусад бүтээгдэхүүнийг хаях, булах, хадгалах, дулааны шугам сүлжээ байгуулах зэргээр хоёр улсын аж ахуйн нэгж байгууллага, уул уурхайн компани, нефть боловсруулах үйлдвэрүүд төрөл бүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулсаны улмаас газрын хэвлийн хилийг зөрчих, зөрчил гарч болзошгүй байгаа тул газрын хэвлийг хамгаалах, гарч байгаа зөрчлийг илрүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тусгайлан авч судлах, онол, практикийн хэрэгцээ шаардлага байна.

Газар, газрын хэвлийн тухай онол эрх зүй.

Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс түүхт соёлынхоо өв уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн оаюлтыг хүндэтгш, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон хуульчилсан билээ.

"Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна" гэж Үндсэн хуулиндаа зааснаар, зэргэддээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх

[1] Н.Наранжамц "Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 8 дахь тал
[2] Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016.
[3] Монгол Улсын газрын хэвлийн тухай хууль. УБ., 1988.
[4] Төрийн мэдээлэл. 2016. № 12
[5] Төрийн мэдээлэл. 2015. № 9
[6] Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль. УБ., 2002.

тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого барималж байна.

Дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор харилцан уялдаа холбоогоо бэхжүүлж байгаа боловч үндсэрхэг үзэл газар авч, үндэстэн ястан, шашин хоорондын зөрчил, мөргөлдөөн гарсаарбайна. МУ оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд газар нутгийн төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад Монгол Улсад тал бүрээс учирч байсан аюул заналыг сөрөн давж, хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд эртний Монгол Улсын оруулсан хувь нэмрийг өнөө цагт дэлхийн түүхчид онцлон тэмдэглэх болж, тэр дундаа байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, түүний онгон дагшин байдлыг хэвээр хадгалаж ирсэн уламжлал ихээхэн онцлог юм. Нүүдэлчин амьдралын хэв маяг нь өнөөдөр судлаачдын үзэж байгаагаар байгаль дэлхий, газар нутагтайгаа зөв харьцах, эх дэлхий, газар нутгаа хайрлан хамгаалах нарийн арга ухааныг эрт үеэс уламжлан ирсэн байжээ. Монгол Улс түүхэндээ энэ уламжлалаа хадгалах, цаашид өвлүүлэх талаар энгийн бөгөөд ухаалаг арга ухаанаар уул ус, газар нутгаа дархлан хамгаалж ирсэн бана.

Газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн байдал нь өнөөдөр шинжлэх ухааны хэмжээнд судлагдаж, газар гэдэг ойлголт нь өөрийн шинжүүдээрээ дараах төрлийн чиг үүргийг биелүүлдэг байна.

Газрын тухай ойлголт: Шинжлэх ухаан газрыг газрын ертөнц буюу газрын бүрхэвч бүхий л нутаг дэвсгэр, ертөнцийн гадаргуу буюу хөрс гэсэн 3 хэсэгт хуваж үздэг. Газар нь байгалийн бусад нөөцийн дотор бие даасан өвөрмөц байдалтай бөгөөд өөрийн шинжүүдээрээ экологи, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, ёс суртахууны чиг үүргийг биелүүлдэг байна.

Газрыг шинжлэх ухааны үүднээс: Газрын хэвлий, дээд давхарга, газрын ертөнц, газрын бүрхэгч, бүхий л нутаг дэвсгэр, ертөнцийн гадаргуу буюу хөрс гэсэн утгыг агуулдаг бөгөөд газрын хэвлийн тухай ойлголт буюу түүнийг судлахдаа агаар мандлын дээд хязгаарыг газрын гадаргаас эгц дээш 100-110 км гэж үздэг бол байгалийн чухал бүрэлдэхүүн, газрын гадаргуугийн суурь хэсэг нь газрын хэвлий юм. "Дэлхийн хамгийн гадна талын давхраас үе бол царцдас бөгөөд царцдас нь хүрмэн чулуулгийн үе буюу /суурьлаг чулуу/, боржин чулуулгийн үе буюу /хүчилэг чулуу/, тунамал чулуулгийн үе буюу /тунаж хуримтлагдаж бий болсон чулуу/ гэсэн 3 үеээс тогтож бүрэлдсэн эхгазраас доош чулуулаг бүрхүүл нь газрын хэвлий рүү 25-70 км үргэлжилдэг өөрөөр хэлбэл газрын гүний үргэлжлэх орон зайг газрын хэвлий гэж ойлгож болох бөгөөд түүнд байгалийн төрөл бүрийн элементүүдээс тогтсон эрдэс чулуулгаас бүрдсэн эрчим хүчний болон байгалийн бусад нөөцөөс гадна хүний эрүүл мэндэд хэрэгтэй эмчилгээний зориулалт бүхий элемент, түүх соёлын дурсгалт зүйлүүд хадаглагдаж байна. Монгол орны хэмжээнд чулуулаг бүрхүүлийн зөвхөн дээд өнгөн хэсгийг сайн судлагдаж түүний гүнд орших хэсгийг геофизикийн тандалт, судалгааг одоог хүртэл хийсээр байгаа"[7] "Газрын хэвлий" гэж шимт хөрснөөс доош, шимт хөрс байхгүй тохиолдолд газрын гадарга, нуур, голын ёроолоос

[7] Б.Лувсанданзан., "Геологийн үндсүүд"., УБ 2011 он

доош үргэлжлэх орон зайд орших бүх төрлийн байгалийн тогтоц, барилга байгууламжийг хэлдэг бөгөөд газрын хэвлий нь түүний ашиглаж байгаа эсэхээс үл хамааран улсын нэгдмэл санг бүрдүүлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулиудад газрыг хуульчилж ирсэн байдал: 1924 оны Үндсэн хуульд 1-р бүлгийн 3-р зүйлийн 1-д: "БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялагууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан сургаал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно." гэж, 2-р бүлгийн 10-т: "Газар эдлэх нийтийн дүрмийг батлах, аймаг хошуудын нутгийн хил хязгаарыг байгуулах, дэлхийн баялагийг ашиглах дүрэм заавар тогтоох" гэж заасан байна.

1940 оны Үндсэн хуулийн 1-р бүлгийн 5-р зүйлд: "Бүх газар шороо ба түүний хөрсөнд доторх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик, завод, төмөрлөгийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр, авто тээврийн зам усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд нь улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно." гэж заасан.

1960 оны Үндсэн хуулийн 2-р бүлгийн 10-р зүйлд: "Бүх газар, түүний хөрсөнд доорх баялаг, ой мод, гол ус, тэдгээрийн баялаг, улсын фабрик, завод, уурхай, цахилгаан станц, төмөр зам, автомашин, усан ба агаарын тээвэр, засмал зам, холбооны хэрэгсэл, банк, улсын хөдөө аж ахуйн үйлдвэрийн газар (сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станц зэрэг), улсын нийгэм ахуйн газар, хот, суурин газрын рөрон сууцын улсын үндсэн фонд, улсын үйлдвэрүүдийн түүхий эд материал, бүтээгдэхүүн, улсын худалдаа бэлтгэлийн ба соёл, шинжлэх ухааны газрууд, мөн улсын бүх байгууллагын эд хөрөнгө энэ бүхэн бол улсын өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө юм" гэж заасан нь газар ашиглах эрх чөлөөг нарийвчлан тусгаж өгсөн.

Газрын хэвлийн тухай хуулийг анх БНМАУ-ын Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн зарлигаар баталжээ. Энэхүү хууль нь тухайн үед газрын харилцаа, ашигт малтмал хайх, олборлох, газрын гүнд барилга байгууламж барих үйл ажиллагаа, түүнтэй холбогдсон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах харилцааг зохицуулахад зайлшгүй шаардлагатай хууль эрх зүйн үндсэн баримт бичиг болж байжээ. 1994 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Гэхдээ энэ нь хуульд байх шаардлагагүй гэж үзсэн ганц нэг үндэслэлийг хасаад өөр нэмэлт өөрчлөлт ороогүй гэж хэлж болно. Энэ хууль нь хуучин "эцэг" хууль гэж нэрлэж болно. Тухай үедээ үйлчилж байсан маш сайн хуулиудын нэг гэж хэлж болно.

Монгол Улс нь 1992 оны шинэ Үндсэн хуулийн 1-р бүлгийн 6-р зүйлд газрын тухай ойлголтыг тодорхой заасан байдаг. "Үүнд:

1.6.1.Монгол улс газар түүний хэвлий ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтанд байна.

1.6.2.Монгол иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой усны нөөц ан амьтан төрийн өмч мөн.

1.6.3.Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба усны тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах арилжих, бэлтгэх, барьцаалах зэрэг гадаадын иргэн, харъяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглахыг хориглоно.

1.6.4.Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай рсэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг солих буюу эгүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

1.6.5.Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүнд газрыг төлбөр хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол журмаар дамжуулж болно." "Ашигт малтмалын тухай хуулийн 5.1 Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн" гэж тус тус заасан. Уг Үндсэн хуульд газрыг хэрэгцээ тус бүрээр нь ялган зааглаж нарийвчлан заасан байна. Хуульд "бүх газар, түүний хөрсөнд доорхи баялаг" гэсэн нэр томъёо орсон нь зөвхөн газар төдийгүй, түүний хэвлийн тухай ойлголтыг нэгэн адил илэрхийлсэн гэж үзэж болно.

Монгол Улс нь газрын хэвлийн баялгаар баян орон хэмээгддэг бөгөөд сүүлийн 20 жилийн хугацаанд газрын хэвлийг зүй зохисгүй, хууль бусаар ашиглах нь нэмэгдэж 2002 онд Газрын тухай хууль батлагдан гарснаас хойшхи хугацаанд байгалийн болон хүний нөлөөллийн улмаас 1 сая гаруй талбай газар хөрсний элэгдэл, эвдрэлд орж, бэлчээрийн 70 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр талхалагдаж, газар тариалангийн талбайн 565,0 мянган га газар атаршиж ашиглалтаас хасагдсан, одоо ашиглагдаж байгаа тариалангийн талбайн хөрс элэгдэлд орж үржил шим нь буурсан, говь, цөлөрхөг нутгийн 40 гаруй хувь нь цөлжилтөнд нэрвэгдсэн байна. "Олборлох үйлдэрлэлийн ил тод байдлын санаачлагч төслийн тайланд дурдсанаар манай улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр 3786 тусгай зөвшөөрөл байна. Үүнээс хайгуулын 2224, ашиглалтын 1562 лицеэз байгаа бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 9.4 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл ашигт малтмалын лицензтэй бүх талбайг улсын нийт нутаг дэвсгэртэй талбайнуудыг хилийн бүсийн хэмжээтэй харьцуулах юм бол их хэмжээний байна"[8].

Монгол Улсын газрын хэвлийн хилийн тухай онол эрх зүй

Газар, газрын хэвлийн хилийг авч үзэхээс өмнө **"Хилийн аюулгүй байдал"** хэмээх ухагдахууныг дийлэнх улс орнууд хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдлынхаа нэгэн чухал чиглэл, хэсэг болгон авч үзэж байна.

Улс гүрнүүдийн оршин байгаа газар нутаг, хил хязгаар нь тусгаар тогтнолын баталгаа буюу тусгаар тогтнохын үндэс болдог мөнхөд оршин байх, эзэмшин байх нь улс бүрийн язгуур ашиг сонирхол байдаг төдийгүй хүн амын амьдран байх үндэс, баялгын эх

[8] Ж.Өвгөнбүргэд ""Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 22 дахь тал

сурвалж болж үйлдвэрлэл, үйлчилгээ, хууль ёс сахих эх талбар, өөрийнхөө доорх баялаг нууцлагаараа бусдын ашиг сонирхолыг татаж байдаг юутай ч зүйрлэшгүй үнэт баялаг мөн бөгөөд түүнийг тодорхойлогч хил хязгаарын аюулгүй байдлын асуудал нь ач холбогдлоор туйлын чухал болох нь нэгэнт тодорхой болсон байна.

Монгол Улс нь геополиткийн хувьд харьцангуй түгжигдмэл орон зайд оршин байгаа боловч аливаа глобал болон бүс нутгийн аюул заналаас харьцангуй хол байх боломжийг давхар агуулж байгаа болно. Энэ нь угтаа Монгол Улс нь хоёр их гүрэн их хөрштэйгээ баланслуулсан буюу хоёр том эрх ашгийг өөрийн эрх ашиг, ашиг сонирхолдоо тэнцвэртэй харилцан уяалдуулсан бодлого нөхцлийг бий болгохыг шаардаж байгаа юм[9].

Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн тогтолцоонд Монгол Улсын үндсэн хууль, бусад хуулиас эхлээд ХХЕГ-ын даргын тугаал заавар, журам хүртэлх шат дараалалтай эрх зүйн акт, баримт бичгүүд хамаарах бөгөөд тэдгээрт хилийн аюулгүй байдлын асуудал тодорхой тусгалаа олсон байдаг. Жишээлбэл үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг нь Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого бөгөөд "уг бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уяалдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ" гэж заасан. Өөрөөр хэлбэл энэхүү баримт бичиг нь хилийн аюулгүй байдлыг хилийн орон зайд хангах эрх зүйн акт мөн.

Хилийн тухай хуулийн 5.2-т **Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ**[10] гэж тодорхойлсон байдаг.

Газрын тухай хуульд Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт улсын хилийн зурвас газар хамаарна. Хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байна[11].

Ашигт малтмалын тухай хуульд эрх бүхий байгууллагаас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрыг тусгай хэрэгцээний газарт тооцно[12]. Гэж тус тус заасан байна. Дээрх хуулиудад дурдагдсан ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглахыг хязгаарласан дараах тусгай хамгаалалтай 13 газрыг нэрлэж хуульд тусгасан. Үүнд:

- улсын хилийн зурвас;
- хилийн боомтын бүс;
- чөлөөт бүсийн газар;
- батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;
- гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар;
- цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар;
- үндэсний бүтээн байгуулалт, дэд бүтцийг хэрэгжүүлэх газар;
- аюултай хог хаягдлын

[9] Н.Наранжамц "Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 11 дахь тал

[10] Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016

[11] Газрын тухай хууль. УБ., 2002

[12] Ашигт малтмалын тухай хууль. УБ., 2006

төвлөрсөн байгууламж барих газар;

- бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул хийх газрын тосны талбай;
- цаг агаарын төлөв байдлын байнгын ашиглалтын талбай;
- бичил уурхайн зориулалтаар олгосон газар;
- улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;
- аймаг дундын отрын бэлчээр тус тус ордог байна.

Хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашгийг хангах асуудал учир Монгол Улсын хувьд хилийн орон зайн улсын хилийн шугамаас хуулиар тогтоосон газах нутгийн гүний хязгаар түүний агаар мандал, хэвлийн хэсгийг хил залгаа улсын хил орчмын нутаг дэвсгэрийн / агаар, газрийн хэвлий/ хамт хамтатган авч үздэг орон зай юм.

Өнөөдөр олон улс, бүс нутгийн түвшинд иргэний дайн, дүрвэгсэд хууль бус цагаачлал, салан тусгаарлагчид болон зэвсэгт бүлэглэл, хар тамхи мансуурлах бодисын худалдаа, зэвсэг галт хэрэгсэл, хүний наймаа, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, газар нутгийн маргаанаас үүдэлтэй хилийн зөрчил будлиан гарсаар байна. Энэхүү аюул занал нь Монгол Улсын хувьд анхааранд зогсохгүй зохих бэлтгэлтэй байхыг шаардаж байгаа болно. Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учирч байгаа аюул занал болох зэвсэг галт хэрэгсэл хууль бусаар хил нэвтрүүлэх, хар тамхи, мансууруулах бодис хил нэвтрүүлэх, зөөврлөх, улмаар хадгалах, худалдаалах түүний хэрэгцээ хэрэглэгчийн тоо өсөн нэмэгдсээр байна[13].

Улсын хил дээр үйлдэгдэж буй хилийн зөрчил нь зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, түүний хэрэглэж буй арга, тактик нь улам нарийсч, ашиглаж буй техник хэрэгсэл нь орчин үеийн хүчин чадалтай болсноор гаргаж буй хууль бус үйлдэл нь хил залгаа улстай байгуулсан хилийн харилцаанд таагүй нөлөө үзүүлж, гадаад талд сөрөг хандлага төрүүлж болзошгүй байгаа бөгөөд байгалийн баялаг ихтэй хил орчмын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалтай үйлдвэрүүд олноор байгуулагдсанаар газрын хэвлийг зүй зохисгүй ашиглах, тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодисын хадгалалт, хамгаалалтын журам зөрчигдөх, ус агаар, газрын хөрс, хэвлий химийн бохирдолд автах, химийн хорт хаягдлыг газрын хэвлий, хил дамнан булах зэрэг газрын хэвлийн хил зөрчигдөх магадлал өндөр байна[14].

"Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна" гэсэн суурь ойлголтоор улсын хил ба хил хамгаалалтын агуулгатай холбогдоно"[15]. Улсын хил гэсэн ойлголтыг *"Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил /цаашид "улсын хил" гэх/ гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна."*[16] гэж

[13] Н.Наранжамц "Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 11 12 дахь тал

[14] Ж.Өвгөнбүргэд "Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 20 22 дахь тал

[15] О.Үржин "Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 34 35 37 дахь тал

[16] Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 4.1 дүгээр зааллт

хуульчилсан байдаг.

Энэ тодорхойлолтыг системийн хандлагын өнцгөөс шинжилбэл улсын хил гурван бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн хоорондын хамаарлаас тогтсон бүтцийн систем болохыг харж болно үүнийг математикаар илэрхийлвэл:

"Манай улс нь мөнхийн хөрш ОХУ, БНХАУ-тай андын холбоогоо улам бэхжүүлж "Нэг хил, хоёр улс" гэдэг зарчмыг хангах үүднээс хилийн аюулгүй байдлыг хангахад ашиглагдаж байгаа техник технологи, нисэх онгоц, нисдэг тэрэг, нисгэгчгүй аппарат, цахим хэрэгслийг буцалтгүй тусламжаар, хөнгөлттэй зээлээр авч, хилийн цэрэг, хил хамгаалах байгууллагын хөгжил дэвшлийг дээшлүүлэх арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлсээр байна"[17].

Газрын хэвлийн хил нь хуурай газрын болон усан хилийн шугамаас эгц доош орших бөгөөд түүний гүний хэмжээг тогтоосон олон улсын эрх зүйн баримт бичиг гараагүй. Монголчууд хил хязгаарын тухай уламжлалт мэдлэг, ойлголт, нэр томъёо байсан ба түүнийг хэрэглэж баримталж ирсээр одоог хүрсэн.

Монгол Улсын хилийн үүсэл хөгжил, газрын хэвлийн агуулга, бүтэц

Аливаа улсын хил нь тухайн улс орны нутаг дэвсгэрийн зах хязгаарыг хөрш улс орны нутаг дэвсгэрээс нарийвчлан зааглаж тогтоосон шугам байдаг. Улсын хил бүрэлдэн тогтох нь хэдхэн жилийн хэрэг явдал бус, түүхийн урт хугацаанд хөрш орнуудын улс төрийн харилцааны явцад аажим алгуур бүрэлддэг бөгөөд зэрэгцэн оршдог субъектүүдийн болон олон улсын хэлэлцээрээр баталгаажиж, улс орны үндэсний тусгаар тогтнолын эрхэм чухал шалгуур болдог.

Монгол Улс нь "Ази тивийн нутаг дэвсгэрт 1 сая 565 мян км2 газар нутгийг эзэмшин суурьшсан, 3 сая гаруй хүн амтай, 8252,6 км хил хязгаартай, газар нутгийн хэмжээгээр 16, хил хязгаарын уртаараа 11 багтдаг, эх газрын эрс тэс уур амьсгал, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон эргэх дөрвөн цагийн улиралтай, далайн түрлэгээс тогтсон

Монгол улс газрын хэвлий буюу газар доор 80 гаруй төрлийн батлагдсан ашигт малтмал эрдэс баялагтай, үүнд нүүрс, зэс, вольфрам, флор, алт, мөнгө, молиблени, хөнгөн цагаан, тугалга, төмөр, хар тугалга, цайр, уран, манган, фосфор, давс, газрын тос гэх мэт. Түүнчлэн нүүрсний нөөц ойролцоогоор 50-152 тэрбум тонн байдаг. Түүнчлэн флорын нөөц ойролцоогоор 8сая тонн, төмрийн нөөц 2 тэрбум тонн, фосфорын нөөц 200 сая тонн, зэсийн нөөц 8 сая тонн, молибдены нөөц 240000 тонн, цайрын нөөц 60000 тнн, алтны нөөц 300 тонн, мөнгөний нөөц 700 тонн, газрын тосны нөөц 1.5 тэрбум тонн байна. Эрдэнэтийн Зэс молибденын уурхай нь дэлхийн хэмжээний зэс молиблены 10 том уурхайн нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд түүний зэрэглэл нь Азийн хэмжээнд ижил төрлийн үйлдвэрлэлүүдийн нэгдүгээрт бичигддэг. Ойн бүс 18.3 сая га, нийт газар нутгийн хэмжээнд ойн эзлэх харьцаа 8.2%, ургаж байгаа ойн сангийн эзэлхүүн нь 1.2 куб метр байна.

[17] Ц.Ганболд "Хил судлал сэтгүүл"., УБ., 2019 он. 30 дах тал

Газрын хэвлийн агуулга, бүтэц

Дэлхийн дотоод тогтоц: Геофизикийн тухайлбал, чичирхийллийн (сейсмийн) аргыг ашиглан (өөрөөр хэлбэл дагуу Р ба хөндлөн S долгионоор) дэлхийн дотоод тогтоц нь бүслүүрлэг болохыг тогтоосон. Энэ нь ямарваа нэгэн долгио физикийн нэг биеийн дотор нэг хурдтайгаар тархах бөгөөд хоёр биетийн зааг дээр хугарч задран зарим нь цааш нэвтрэх ба бусад нь буцдаг. Үүнийг ашиглан тайлбарласан.

Газрын гадаргаас тархсан дагуу долгион 6.5-аас 7.5 км/с, хөндлөн долгион 3.7-3.8 км/с хурдтайгаар чулуулаг дундуур нэвтрэх бөгөөд дунджаар 33 км яваад эрс өсч дагуу долгионы хурд 7.9 км/с, заримдаа 8.2-8.3 км/с, хөндлөн долгионы хурд 4.7 км/с хүрдэг. Энэ нь чулуулаг бүрхүүлийг дээд мантиас зааглаж буй хил бөгөөд анх Югославын геофизикч С. Мохоровичич тогтоосон учир Мохын хил гэж нэрлэдэг. Энэ нь дэлхийн царцдас (земная кора-) болон мантийн зааг болно. Дагуу долгион цааш 2900 км гүн хүртэл 7.9-өөс 13.8 км/с хүртэл өсөх бөгөөд эндээс долгионы хурд эрс өөрчлөгдөж 7.4 км/с болтлоо буурч хөндлөн долгион тархахгүй болно. Энэ нь манти цөм хоёрын зааг болно. Геофизикийн энэ судалгаагаар манти цөм хоёр нь хоёр хуваагддаг болох нь тогтоогдсон бөгөөд мантийг дээд доод, цөмийг дотоод гадаад гэж ангилсан. Тэдгээрийн зааг нь 900-1000 км, 5100 км болно[18].

[18] "Газрын хэвлийн геофизик"

Зураг 1. Дэлхийн дотоод бүтэц



Хүснэгт 1. Газрын давхаргын ангилал

Газрын давхарга
Дэлхийн хамгийн гадна талын бүрхэвчийг газрын давхарга гэнэ.

Газрын давхарга	
Эх газрын давхарга 65 хувь	Далайн давхарга 35 хувь

Эх сурвалж: Дэлхийн үүсэл хөгжил-2004

Эх газрын давхарга нь: дэлхийн гадаргын 65%- ийг бүрхэнэ. Зузаан нь дунджаар 10-70 км, газрын давхаргад O 2, Si, AI, K, Na нилээд хувийг эзлэх ба нягт багатай хөнгөн, цайвар өнгөтэй чулуулгаас тогтоно.


Чулуулаг үелэл		
Тунамал 15-20 км	Боржин 40 км	Хүрмэн 15-35 км

Эх сурвалж: Дэлхийн үүсэл хөгжил-2004

Газрын давхарга мантиас /Мохын гадарга/-аар тусгаарлагдана. 1909 онд Югославын физикч А. Мохоровичич нь газар хөдлөлтийн сейсмисийн бичлэгийг судалж 50 км орчим гүнд долгионы хурд эрс өсөж 8 км/с хүрдэгийг тодорхойлсноор газрын давхаргын бодисууд мантиас бага нягттай болохыг баталсан.

Монгол Улсын газрын хэвлийн хилийн өнөөгийн байдал: Улсын хил хамгаалалт зөвхөн газрын гадаргуун хилийн шугамын уртаар хязгаарлагдах бус, харин түүнээс эгц дээш болон эгц доош үргэлжилсэн босоо хавтгайн талбайн хүрээнд яригдана. Улсын хил хамгаалалтын систем буюу цогц байдлын зургаар зургаар илэрхийлбэл дараах байдалтай байна[19].

Хүснэт 3. Улсын хилийн системийн зураглал



Эх сурвалж: "Хил судлал сэтгүүл"-2019.

"Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.

"Газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална"[20], хил хамгаалах байгууллагын үүрэгт "агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаарх мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах"[21] гэсэн эрх зүйн зохицуулалтын өнцгөөс харвал газрын хэвлийн хил хамгаалалт ямарч зохицуулалтгүй, хариуцах эзэнгүй байгааг харж болно. "Харин хилийн тухай хуулийн "хилийн зөрчил"-ийн жагсаалтанд "улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн"[22] гэсэн заалт байгаа нь газрын хэвлийн хилийн хамгаалалт зарим талаар хил хамгаалах байгууллагын үүрэг хамаарах ойлголтыг бий болгож байна.

Монгол Улс нь газрын хэвлийдэх баялгаараа хэмжээлшгүй их бөгөөд алт, хүдэр, уран, мөнгө, газрын тос зэрэг нь хилийн зурвас болон хоёр улсын хил дамнасан газрын хэвлийд оршин байгаа байгалийн баялаг болох судалгаагаар тогтоогдсон бөгөөд хэтийн төлвийн судалгаа хийхэд одоогийн байдлаар 13 компани газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн 33% нь Монголын аж ахуйн нэгжүүд, 39% нь БНХАУ-ын компани, 28% нь бусад орны компаниуд байна. Үүнээс газрын тосны үйл ажиллагаа явуулж байгаа БНХАУ-ын төрийн өмчит компани болох "Петрочайна дачин тамсаг" ХХК үйл ажиллагааг авч үзвэл.


19

20 Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 31 дүгээр зүйл.

21 Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016,35.1.9 дүгээр зүйл.

22 Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 22.1.3 дугаар заалт.


Зураг 2. Газрын тосны байршлын зураг.



Эх сурвалж: "Газрын тосны хэрэг эрхлэх газрын тайлан"-2017

Тамсагийн Сав Газар дахь Гэрээт Талбай 19-н гидрогеологийн судалгааны төслийн ажиллагаа нь Монгол улсын нутаг дэвсгэрийн зүүн хэсгийн тал нутагт явагдах бөгөөд энэ нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу бол Монгол улсын Дорнод аймагт харьяалдагдаг. Энэ нь Монгол улсын зүүн захын аймгийн төв Чойбалсан хотоос баруун зүгт 180 км, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Гсинбархүзүо сууринаас зүүн хойд зүгт 200 км, Өвөр Монголын өөртөө Засах Орны Донгвүжүмүкин сууринаас өмнө зүгт 160 км-т байрлана. Газар зүйн координат: 116°04'34"-116°21'34"E, болон 46°50'01"-47°04'17"N, бөгөөд төслийн бүсэд хамаарах нутаг дэвсгэр нь 381 км^2 талбай байна. Судалгаагаар 300-1300 метрийн гүнтэй 524 цооног, 30 метрийн гүнтэй 3 цооногоос газрын тос татан авч, цооног хоорондын зай 500-2000 метр, 1 цооног нь 500-1500 метрийн радиусыг хамардаг байна.

Зураг 3. Улсын хилийн шугамд тулсан газрын тосны цооногийн байршлын зураг





Эх сурвалж: Судалгааны ажлын хүрээнд хийсэн судалгаа

Газрын тосны цооногууд нь Монгол Улсын хилийн шугамаас 1200 метрт, БНХАУ-ын хилийн шугамаас 100-500 метрт байралдаг байна. Үүнээс үзэхэд "Петрочайна дачин тамсаг" ХХК-ны газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа газар нь хоёр улсын газрын хэвлийн сав газрын байгалийн баялаг юм.

Мөн Монгол Улсын хөгжлийн бодлогод чухал ач холбогдол бүхий 15 орд бий. Эдгээрийн нэг болох Асгат-ын мөнгө, холимог металлын орд нь Монгол орны баруун хэсэгт, Баян-Өлгий аймгийн Ногоон-Нуур сумын нутагт, ОХУ-ын Алтайн хязгаартай хиллэн оршдог. далайн төвшнөөс дээш 2500-иас 3500 м хүртэл

өргөгдсөн. Монросцветмет компани "Асгат"-ын ордын 4 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг байна.

Энэ мөнгөний орд нь хоёр улсын хил дамнасан байгалийн баялаг бөгөөд манай улс нь ашиглах үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд хөрш ОХУ нь өөрийн талаас 2 нүхэн туннель гарган ашиглаж дууссан гэх албан бус мэдээлэл байгаа нь тухайн уурхайн туннелийн гүний хэмжээ, ашиглалтын байдал тодрхой бус ашиглалт хийгдэж дууссан бол газрын хэвлийн хилийг зөрчсөн үү үгүй юу гэдэг асуудал урган гарч ирж байна.

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК болон Асгатын мөнгөний орд буюу энэ 2 компаний үйл ажиллагаанаас гадна цөөнгүй уул уурхай, ашигт малтмалын компаниуд хилийн зурваст үйл ажиллагаа явуулах мөн БНХАУ-ын талаас хилийн дагуу газрын тос болон уул уурхай, ашигт малтмал олборлох үйл ажиллгаа нэмэгдсээр байгаа нь судалгааны үр дүнд харагдаж байна.

Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн онцлог, газрын хэвлийн хилийн байдал


ОХУ нь Монгол Улсын хойд хэсгээр хиллэдэг бөгөөд сүүлийн жилүүдэд ОХУ-ын эдийн засгийн хөгжил нэлээд тогтворжиж хөгжлийн хурд нь хөгжингүй орнуудаас дээгүүр, Хятад, Энэтхэгээс арай доогуур түвшинд байна. ИТАР-ТАСС агентлагийн мэдээлж буйгаар ОХУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн жилээс жилд нэмэгдэж байгаа аж. Өнгөрсөн жилүүдийн өсөлтийн гол хүчин зүйл нь газрын тос, байгалийн хийн эрчимтэй хөгжил, рублийн ханшийн гүйцэтгэх үүрэг, нөөц бололцоо байсан. Гэтэл эдгээрийн нөөц шавхагдаж байгаа тул хөгжлийг түргэтгэх гол гарц нь хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, эдийн засгаа төрөлжүүлэх явдал болсон юм. Ойрын жилүүдэд газрын тосны үнэ огцом өсч, эрчим хүчний эх сурвалжийн төлөөх дэлхийн хэмжээний өрсөлдөөн улам ихсэж байна.

ОХУ нь дэлхийн байгалийн хийн нөөцийн 26,7%, олборлолтын 22,1%, экспортын 29%, газрын тосны нөөцийн 6%, олборлолтын 11,4%, экспортын 9,3% эзэлдэг томоохон нийлүүлэгч бөгөөд эдүгээ эрчим хүчний дипломат бодлого явуулж байна. Стратеги бодлогын хүрээнд Монгол Ултай хиллэдэг хэсгийн газар орон, газрын хэвлийд байгалийн баялаг ихээр олборлох нь сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа юм.

Монгол-Хятадын хилийн урт нь 4709.658 км нутгаах хиллэдэг. Хуурай газраар 4488.6 км, усан хил 221.058 км тус тус хиллэдэг бөгөөд өмнөд их хөрш Хятадын эрчим хүчний болон аж үйлдвэрийн түүхий эдийн импорт жилээс жилд өссөөр байна. БНХАУ-ын статистикийн мэдээгээр тус улс жилд 2.19 тэрбум тн нүүрс, 181 сая тн төмрийн хүдэр, 352 сая тн ган, 16.3 сая тн төрлийн өнгөт төмөрлөг олборлодог, харин 126,8 сая тн газрын тос, 275.2 сая тн төмрийн хүдэр, 4.58 сая тн марганцын хүдэр, 3.02 сая тн хром,, 4.06 сая тн зэсийн хүдэр импортоор авсан байна. Ийм болохоор эрчим хүч болон аж үйлдвэрт нэн шаардлагатай эрдэс түүхий эдийн найдвартай эх үүсвэр олох, улс орноо тогтвортой хангах Хятадын төрийн бодлогын томоохон зорилтуудын нэг, улс орон нь эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой амин чухал эрх ашиг болоод байна.

БНХАУ дотоодынхоо нөөц бололцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрдэс түүхий эдийн гадаад эх үүсвэрээ бэхжүүлэх талаар идэвхитэй ажиллаж байна. Эрчим хүч, түүхий эдийн нөөц баялаг ихтэй орнууд тухайлбал Монгол Улсаас гадна ОХУ, Казакстан, Чили, Австрали, Саудын Араб, Иран, Нигери, Венесуэл зэрэг орнуудтай харилцаагаа идэвхжүүлж байна. БНХАУ нь Монгол Улстай хиллэдэг хэсгийнхээ хилийн чанад дахь эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, томоохон компани болон уул уурхай, газрын тос, хийн том ордуудыг оруулах талаар тууштай ажиллаж байна.

Хятад улс: Түлш, Эрчим хүч, Эрдэс баялагийн тойм зураг



Боловсруулах үйлдвэр

- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Шатдаг занар боловсруулах үйлдвэр
- Газрын тосны талбай
- Байгалийн хийн талбай
- Түүхий газрын тосны бассейн
- Томоохон нүүрсний уурхайнууд

Цахилгаан станц

- Дулааны цахилгаан станц
- Усан цахилгаан станц
- Дамжуулалтын шугам

Металл бус ашигт малтмал

- Sb Газрын ховор элемент
- Cu Зэс
- Pb Цайр болон хар тугалга
- M Монгол ус
- Hg Цайр болон хар тугалга
- Sn Цагаан тугалга

Металл ашигт малтмал


- Fe Төмрийн хүдэр
- Mn Манган
- Mo Молибден
- W Вольфрам

Эдийн засгийн бүс нутгийн хил


БНХАУ-ын “Доншэн газрын тос” компани Монгол-Австралийн “Рок Ойл” компанийг 2003 оны 3 дугаар сард, АНУ-ын “Соко Тамсаг Монголиа ЛЛС” компанийн гэрээлэгчийн эрхийг БНХАУ-ын “Петро Чайна-Дайчин Тамсаг”-д 2005 оноос 100% шилжүүлэн өгсөн тодорхой хэмжээний газар нутаг түүний асар их баялгийг манай нутагт ажиллаж байгаа гадаадын иргэд, компанид өмчлүүлэх нь Монгол төрийн бодлого мөн эсэх нь тодорхойгүй байгаа юм. Ингэснээр Монголын газрын тосны идэвхтэй хайгуул, олборлолт хийж буй орд газрууд бүгд Хятадын компаниудын мэдэлд орсон байна.


Газрын хэвлийн хилийг зөрчсөн болон зөрчиж болзошгүй нөхцөл байдал, шийдвэрлэвэл зохих зарим асуудлууд

Газрын хэвлийн хилийг зөрчсөн үйлдлүүд: Газрын хэвлийн хилийг зөрчих асуудлыг олон улсын хил хязгаарын зөрчлөөс авч үзэхэд АНУ болон Мексик улс хоёрыг зааглагдаг хил нь Мексикийн хойд хэсэгт оршдог бөгөөд 3,169 км үргэлжилдэг энэхүү хилээр жилд 250 сая хүн орж гардаг тул Дэлхийн хамгийн олон хүн зорчдог хилд тооцогддог хяналт султай хилийн бүс нутагт зүй ёсоор ордог. Мексикийн зэвсэгт хүчин АНУ-ын хилийн орчимд хар тамхи зөөвөрлөдөг туннелийг 2009 онд илрүүлсэн бөгөөд газарт 20 метрийн гүнд 230 метр үргэлжлэх энэ суваг нь Мексикийн Сан-Луис хотын цэвэр усны дэлгүүрийг Аризона мужийн мөн цэвэршүүлсэн усны дэлгүүртэй холбосон байсан бөгөөд туннелийг цахилгаан болон агааржуулах системээр тоноглон, тэр бүү хэл хар тамхи зөөвөрлөх жижиг тэрэг хүртэл тавьсан нь газрын хэвлийг ухаж хэвлийн хилийг зөрчсөн байна. АНУ-ын Засаг захиргаа 1990 оноос хойш 150 гаруй ийм төрлийн хэвлийн хилийг зөрчсөн туннелийн сувгийг илрүүлээд байгаа юм.



Мөн Израйль газын зурвасын Египтэй /Синайн хойг/ хиллэдэг хэсгээр хууль бусаар газрын хэвлийд туннель байгуулан түүгээр зэр зэвсэг, тэсрэх бодис орж ирдэг хэмээн АНУ, Англи, Франц зэрэг улсуудтай хамтран Америкийн тусламжтайгаар Египтчүүдээр 2009 онд хилийн дагуу хамгаалалтын хана босгуулж эхэлсэн. Энэ төмөр ханын өндөр нь 18 метр, урт нь хилийн дагуу 11 км, газрын гүн рүү 4.5 метр хийгдсэн бөгөөд цаашид шаардлагатай гэж үзвэл бусад газрын хэвлийд болон усан доогуур хамгаалалтын хана туннель бий болгох талаар шийдвэрлэсэн байна.





Өмнөдийн газрын туннель нь Бүгд Найрамдах Солонгос Ардчилсан Бүгд Найрамдах Солонгос Улсыг дайран довтлох зорилгоор барьсан цэргийн туннель юм. Туннелийг байгуулахдаа газрын хэвлийн хилийг зөрчсөн бөгөөд 1997 онд АНУ-ын Тэнгисийн Корпорациас хэвлэгдсэн "Хойд Солонгос гарын авлага" -аас үзэхэд өмнөдөд буух туннельд нийтдээ 20 орчим байна гэж тооцоолсон байна. Газрын хэвлийд нүхэн гарц буюу туннелийн байгууламж хийж зорилго нь өмнөд солонгосын эзлэх байлдааны арга тактикийн томоохон байгууламж байсан бөгөөд Үнэндээ газар доорх хонгил дэлхийн дайны түүхэн дэх нэгэн төрлийн стратеги юм. 1904 оны Орос-Японы дайны үед 6 том газар доорх нуувч ухан Манжид нэвтрэх бэлтгэл хийсэн. Вьетнамын дайнд алдартай газар доорх агуй битконы ялалтын гол хэрэглэгдэхүүн байлаа. 2500000 км газар доорх хонгилоор дайтсаны үр дүнд биткончууд америкчуудыг үлдэн хөөж, төсөөлшгүй ялалтад хүрсэн билээ. Газар доорх хонгилын стратегийн ялалт байлаа[23].

Солонгосын дайны үед америкийн дайралтаас газар доорх суваг ухаж амь гарсан Ким Илсон нь газар доорх суваг буюу хонгил хэр зэрэг хэрэгтэйг мэдсэн бөгөөд вьетнамын дайны үед дайны талбарт очиж газар доорх сувгийн талаар өөрийн биеэр танилцсан байна. Тэгээд Ким Илсон дайны гал зогссон тайван байдлыг ашиглан газар доорх суваг ухахаар шийдсэн байна.

Нэгдүгээр туннель нь 1974 оны 11 дүгээр сард Кёнги мужийн өмнөд хэсэгт нээгдсэн бөгөөд өглөө цэргүүд бүсийг шалгаж явсан 25-р салааныхан сонин үзэгдэлтэй тулгарлаа. -6 хэмд хогийн ургамал ургасан байхыг хараад ухаж эхэлснээр газар доорх сувгийг илрүүлэв. Харин ухаж байсан цэргүүд хоолоо ч идэлгүй, хонгил ухаж байсан техник төхөөрөмжөө тэр чигт нь хаяад зугатацгаав. Тэдний үлдээсэн ул мөр нь хэр удаан, төлөвлөгөөтэйгээр хонгил ухаж ирснийг илтгэсэн байна.

Хоёрдугаар туннель нь 1975 оны 3 дугаар сард Гангвон хотод байрладаг Cheongwon-gun хотын Gongdong талбайд нээгдсэн. 2-р газар доорх сувгийг олох тийм ч амар байсангүй "Шөнийн загасчлал" нэртэйгээр эхэлж, тухайн орчинд ямар нэгэн онцгой шинж тэмдэг илэрвэл газрыг өрөмдөж байсан. Ингээд 1975 оны 2 сард 45 газар өрөмдлөгө хийн шалгах явцад 10 дугаар өрөмдлөгийн хэсгээс дулаан уур болон утааны үнэр гарч, мөн өрөмдлөгийн үед өрөмөнд чулуулаг наалддаг бөгөөд тухайн өрөмний үзүүрт 1 метр орчим юу ч байхгүй хоосон байв. Ингээд камер суурилуулсан өрмөөр шалгаж

[23] https://www.aladin.co.kr/m/mproduct.aspx?ItemId


эхлэхэд камер 58 метр доошлоход эргэн тойрон цагаан харагдсан энэ нь чулуулгаар дүүрэн байсан ба 59 дэх метрээс эхлэн харлаж эхэлсэн мөн 61 дэх метрт хүрэхэд хоосон орон байгааг илтгэж байсан. Ийнхүү газар доорх хонгилын хажуу талаас нь угтаж ухаж эхэлсэн бөгөөд 20 өдрийн дараа 2 дугаар газар доорх сувагтай холбогдов. 2 дугаар сувгийн өргөн 2 метрээс их, өндөр нь 2 метр гаруй бөгөөд хилийн зурвасаас 1 км орчим нэвтэрсэн байв. Ийм хонгилоор 1 цагийн дотор 30,000 цэрэг мөн танк болон цэргийн зориулалтын автомашиныг нэвтрүүлэх боломжтой байв.


Гуравдугаар туннель нь 1978 оны 10 дугаар сард Гёнги муж улсын Паван хотод Жандан-Яне хотод нээгдсэн бөгөөд уг туннель нь Сөүлийн ойролцоо бөгөөд 435 метр хүртэл урагшаа чиглэсэн байсан 3 дугаар газар доорх суваг нь өргөн 2 метр, өндөр 2 метр, урт нь 1530 метр том хэмжээтэй байлаа. 3 дугаар суваг нь хойд солонгосоос өмнөд солонгос руу 300,000 цэргийг 1 цагийн дотор нэвтрүүлэх маш аюултай газар доорх суваг байлаа. Энэ суваг нь Панмүнжомоос баруун тийш 4 км-т цэрэггүй бүсэд хилийн зурвасаас 435 метр нэвтэрсэн бөгөөд энэ байршил нь сөүл рүү орсон зам байсан нь сөүлээс 52 км зайтай бөгөөд автомашинаар 40 минутанд сөүлд орж ирэх маш ойрхон газар доорх суваг байсан

Дөрөвдүгээр туннель нь 1990 оны 3 дугаар сард Ганвон мужийн Yanggu-gun арлын эрэг дээр байгуулагдсан зэрэг 20 орчим туннельн гарцыг бий болгож байсан бөгөөд 1974 онд дайны чиглэлээр байгуулсан туннель нь Өмөд Солонгос Улсын хил рүү нэвтрэн орж 4 км ухсан цагт 30-40 мянган цэрэг зэвсэглэн орох хэмжээний том туннель бөгөөд тухай үеийн цэргийн удирдагч нь Ким Илсон байсан[24].

[24] Солонгос улсын түүх "http://korea318.com/client/board/view.asp?sEtpnum"

Зураг 4. Бүгд Найрамдах Солонгос Ардчилсан Бүгд Найрамдах Солонгос Улсыг дайран довтлох зорилго бүхий туннелийн схем зураг





Эх сурвалж: "http://korea318.com/client/board/view.asp?sEtpnum

Газрын хэвлийн хилийг зөрчиж болзошгүй нөхцөл байдал: Манай улсад голчлон хууль бусаар газрын хэвлийг ашиглах, газрын хөрсийг гэмтээх хэргүүд цаашид өсөн нэмэгдэх хандлагатай байна. Хүн амын амжиргааны түвшин доройтохын хэрээр байгаль дэлхийн нөөц баялаг руу халддаг зүй бус үзэгдэл газар авч байгаа ч газрын хэвлийн хилийг байгалийн баялаг ашиглах зорилгоор зөрчсөн үйлдэл гараагүй байх үндэслэл байхгүй байна.

Хэдийгээр манай улсын газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар баримтлах үндэсний бодлого,

хөтөлбөрүүдийг батлан гаргаж хэрэгжүүлж эхэлсэн гэх боловч бодит амьдрал дээр төдийлөн өөрчлөлт гарахгүй байна. Тухайлбал: 1997 онд төрөөс экологийн талаар баримтлах бодлого", 2002 онд "Байгалийн нөхөн сэргээлт боловсронгуй болох хөтөлбөр" "экологийн боловсролын үндэсний хөтөлбөр" 2004 онд "Газрын хэвлий зөв зохистой ашиглах хөтөлбөр" зэргийг батлан хэрэгжүүлж байгааг дурьдаж болно. Хамгийн сүүлд л гэхэд 2006 оны 12 сард Монгол Германы техникийн хамтын ажиллагааны хүрээнд уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах төсөл 2015 оноос өнгөрсөн оноос хэрэгжиж эхэлсэн билээ. Уг төсөлд: Газрын хэвлий түүний нөхөн сэргээлтийн үйл ажиллгааг сайжруулах, техник хангамжийг нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг ажлыг тус тус зохион байгуулж ажиллаж байна. Сүүлийн үед хилийн зурваст байгалийн баялагтай холбогдуулан ихээхэн хэмжээний газар нутагт лиценз олгосон нь цаашид газрын хэвлийн хилийг зөрчин байгалийн баялагыг нууцаар боловсруулах, хулгайлах, гаргаж авсан эрдэс, түүхий эдийг хууль бусаар ашиглах, газрыг эвдэх, хөрсийг гэмтээх, экологийн аюултай хог хаягдал авчирж булах, газрын гүнд аюултай техник технологийг ашиглах их хэмжээгээр үйлдвэрлэл явуулах зэрэг үйлдлүүд гарах хандлагатай боллоо.

ДҮГНЭЛТ

1. Монгол Улс нь нүүдэлчдийн анхны төр улс Хүннү улсын нутаг дэвсгэрээс эхлэн газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн байдлын төлөө тэмцэж, өнөөдрийн Монгол Улсын газар нутаг, хил хязгаарыг тогтоон олон улсад баталгаажуулсан бөгөөд нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр газрын хэвлийд байгаа байгалийн баялгийг ашиглах нь ихэсч байна. Үүнтэй зэрэгцэн газрын хэвлийн хилийн асуудал хөндөгдөж, хэвлийн гүнийг ямар байх, хэр хэмжээтэй байх нь олон улсын хэмжээний ойлголтонд одоог хүртэл хүрээгүй байна.

2. Монгол Улс нь 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудад газрын харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжинд тусгайлан зааж ирсэн бөгөөд нийгэм, эдийн засаг хурдтай хөгжихийн зэрэгцээ хууль тогтоомжийн заалт суларч, шинийг илэрхийлэх болсон бөгөөд газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг уул уурхайн яамны стратегийн бодлого төлөвлөлтийн газраас томилогдон ажиллаж байгаатай холбогдуулан газрын хэвлийн хилийн талаарх холбогдох заалтуудыг судлан тусгах шаардлага зүй ёсоор гарч байна.

3. Газрын хэвлийн хил нь хуурай газрын болон усан хилийн шугамаас эгц доош орших бөгөөд түүний гүний хэмжээг тогтоосон олон улсын эрх зүйн баримт бичиг гараагүй. Монголчуудын хил хязгаарын тухай уламжлалт мэдлэг, ойлголт, нэр томъёо байсан ба түүнийг хэрэглэж баримталж ирсээр одоог хүрсэн байна.

4. Хилийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4.1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор газрын хэвлийг хамгаалах, түүнд тавих хяналт, тандалтыг зохих түвшинд явуулах шаардлага зүй ёсоор гарч байна.

5. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 22.1.3-т "Улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн" гэсэн заалт байгаа ч газрын хэвлийн хилийг зөрчсөн

тохиолдолд түүнийг шийдвэрлэх талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаад дүгнэлт хийж, шийдвэрлэх талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах.

5. Монгол Улсад газрын тос олборлож байгаа компаниуд нь 2500-3000 метрт чөлөөтэй өрөмдөх, өрөмдлөгийн угаас цацраг байдлаар хэд хэдэн цооног өрөмдлөг хийх хүчин чадал бүхий техник хэрэгсэлтэй байгаа нь газрын хэвлийн хилийг зөрчиж газар доорх баялгийг татан авч байх магадлал өндөр байна.

6. Монгол Улсын хилийн зурвас, хоёр улсын хил дамнасан байгалийн баялаг олборлох уул уурхай, ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд газрын доор далд малталт, тунель байгуулан ашгийн төлөө газрын хэвлийн хилийг зөрчих магадлал цаашид гарч болзошгүй байна.

7. Бусад орнуудын баримт болон бодит үйлдлүүдээс харахад газрын хэвлийн хилийг дайн байлдааны зориулалтаар мөн хууль бус наймаа хийх зорилгоор газар доор тунель байгуулан хэвлийн хилийг зөрчих асуудал гарч байгаа нь цаашид анхаарах асуудал бөгөөд Монгол Улсын хувьд газар доорх байгалийн баялгаа хууль бусаар газрын хэвлийгээр алдах, хөрш орнуудаас газрын хэвлий хил зөрчин хийн хоолой, туннель байгуулж химийн хорт бодис түүнтэй нийцүүлсэн химийн хаягдал зэргийг хаях, булах асуудал гарч болзошгүй байна.

Монгол Улсын газрын хэвлийн хилийг хамгаалах талаарх санал. Үүнд:

1.Хил залгаа улстай шинээр байгуулах хилийн дэглэмийн гэрээнд газрын хэвлий асуудлыг тусгайлан хэлэлцэж тусгах.

2.Газрын хэвлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын ажлын хэсэгт ХХБ-аас комисс томилон хамтран ажиллуулах /хуулийг шинэчлэх тохиолдолд газрын хэвлийн хилийн талаар холбогдох заалтуудыг судлан тусгах/.

3.Хил хамгаалах байгууллагаас мэргэжлийн байгууллагатай хамтран ажлын хэсэг томилон хилийн зурваст олборлолт явуулж байгаа хэсгүүдэд газрын гүний тандалт зохион байгуулж, шалгах.

4.Газрын хэвлийн хилийг зөрчигдөж байгаа үйлдлийг илрүүлэх шинэ техник технологийг хил хамгаалах байгууллагад нэвтрүүлэх.

5.Улсын хилд ойролцоо үйлдвэр, үйлчилгээ, ашигт малтмалын олборлолт явуулж байгаа аж ахуйн нэгж компаниудад тавих хяналт шалгалтыг тодорхой хугацаанд төлөвлөгөөт болон гэнэтийн байдлаар явуулах.

6.Хилийн тухай хуулийн 4.1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх, газрын хэвлийн хилийг хамгаалах, хяналт тавих, тандалт хийх зорилгоор Өмнөд, Хойд хилийн газрын хэвлийн хил хариулцсан шинэ орон тоо гаргах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, /геологи, геофизикийн мэргэжлийн сургууль төгссөн байх/.

7.Хил хамгаалалтын оперативын байгууламж буюу инженерийн байгууламжийг газрын гадаргуун хэсгийг хамгаалах зориулалтыг газрын хөрсний гүн рүү чиглэсэн байдлаар тодорхой хэсгийг нэмэгдүүлэх.

8.Цаашид газрын хэвлийн хилийн тухай хил судлалын ухааны судалгаа, шинжилгээний чиглэлийг бий болгож, гүнзгийрүүлэн судлах зүй ёсны шаардлага гарч байна.

ЦЭРГИЙН СУРГАЛТ

БАРЬЦААЛАГЧТАЙ ЯРИА ХЭЛЦЭЛ ХИЙХ ТАКТИК АЖИЛЛАГАА

Б.Мөнгөнбагана
ХАС, Хилийн боомтын аюулгүй байдал, ШНА-ны тэнхимийн ахлах багш хошууч

ОХУ-д барьцаалагдагчтай холбоотой асуудлыг шийдвэрлэх аргыг боловсруулах шаардлага XX зуунд тулгамдсан асуудал болж ирсэн бөгөөд 1997-2003 онд Дотоод хэргийн яамны харъяа байгууллагуудад хүн барьцаалсан хэргийн 956 тохиолдол бүртгэгдэж, барьцаалагдсан хүний тоо 2064 хүрч байжээ. Террорист шинжтэй ийм төрлийн гэмт хэргүүд нь нягт харилцан уялдаатай эрүүгийн болон улс төрийн зорилго, барьцаалагдагч нартай хэрцгий хандах онцлогийг агуулж байсан. Үүний тод жишээ нь 1995 онд Будёновскд, 2002 онд Дубровкед, 2004 онд Бесланд болсон террорист ажиллагаанууд болж байна.

Энэ үед террористуудтай хийх яриа хэлцэлийг депутат, өндөр албан тушаалтан, эмч, сэтгүүлч зэрэг мэргэжлийн бус хүмүүс явуулж байсан. Эдгээр үйл явдлууд нь ОХУ-ын Парламент, Засгийн газарт барьцаалагдагчтай холбоотой асуудлаар яриа хэлцэл хийх зайлшгүй шаардлага, боломжуудыг авч хэлэлцэхэд хүргэж, улмаар 2006 оны 03 дугаар сарын 06-ны өдөр № 35-ФЗ "Терроризмтой тэмцэх тухай" холбооны хуулийг баталсанаар барьцаалагч этгээдтэй яриа хэлцэл хийх ажиллагааны эрх зүйн үндсийг албан ёсоор тогтоож өгсөн байдаг.

Энэ асуудлаар ОХУ-д В.П.Илларионов "Переговоры с преступниками" /1993 он/ нэртэй хуулийн сэтгэл судлалын сурах бичигт дэлгэрэнгүй хөндөж авч үзсэн байдаг нь энэ чиглэлээр судлагдах томоохон эх сурвалж болсон байна. Тэрээр яриа хэлцэлийн үйл явцад оролцогч талууд болох барьцаалагч, барьцаалагдагч, хууль сахиулах байгууллагаас яриа хэлцэл хийгчийн үүргийг гүйцэтгэж буй алба хаагч, тусгай ажиллагааны удирдагч, бусад оролцогчдын сэтгэл зүйн онцог, түргэн өөрчлөгдөх онцгой нөхцөл байдал яриа хэлцэл хийх арга, яриа хэлцэлийн явцад нөлөөлөх хүчин зүйлс, анхаарах асуудлыг нарийн судалж, анхаарах шаардлагатай зарим зөвлөмжийг гаргаж дэвшүүлсэн байдаг.

Барьцаалагчтай яриа хэлцэл хийх тактик ажиллагаа

Барьцаалагчтай яриа хэлцэл хийх нь тусгай ажиллагааг амжилттай явуулах үндэс болдог. Яриа хэлцэл нь барьцаалагдагчийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, цаг хугацаа хожих, барьцаалагчдыг төөрөгдөлд оруулах, тэднийг тайвшруулж, барьцаалагдагчдыг устгуулахгүй байх, тусгай ажиллагааны удирдагчид шаардлагатай хүч, хэрэгслийг төлөвлөж, бэлтгэх боломж олгох, цагийн байдлыг газар орон дээр нь нарийн судлах, барьцаалагчдын тоо, бүрэлдэхүүн, зэвсэглэл, байрлал, сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох, бусад шаардлагатай мэдээллийг авах, мөн

түүнчлэнгэмтхэргийнгазраасөөргазарт байрлаж буй тэдний хамсаатнуудыг тогтоож илрүүлэх, гэмт үйлдлээс учирч болох материалын хохирлыг багасгах, урьдчилан сэргийлэх зэрэг үүргүүдийг хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Эдгээр үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь оператив тоглолт явуулах тактикийг хэрхэн зөв сонгосон, тусгай ажиллагаанд оролцож буй ажилтнуудаас барьцаалагчдад "тэдний тавьсан шаардлага биелэх болно" гэж итгүүлэх чадвараас шалтгаална. Жишээ нь барьцаалагчдад харагдахаар байдлаар ажиллагаанд оролцож буй зарим хүч хэрэгслийг газар орноос холдуулах, шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэнээр тэдний шаардлагыг хүлээн авч, хэрэгжүүлж эхэлсэн гэсэн итгүүлийг төрүүлнэ.

Яриа хэлцэл хийх үйл явцыг боловсронгуй болгох нь яриа хэлцэл хийгчдийг бэлтгэх, яриа хэлцэлийг бодит байдлаар явуулах гэсэн үндсэн хоёр үйл ажиллагаанаас хамаарна. Иймд яриа хэлцэл хийгчдийг урьдчилан бэлтгэх шаардлага тулгардаг. Сэтгэл зүйн онцлогийн хувьд барьцаалагчтай яриа хэлцэл хийх чадвартай этгээдийг сонгон авч, батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулдаг. Яриа хэлцэл хийх нь шинэ мэдээллийг шуурхай авах боломжоор хангадаг. Яриа хэлцэл хийгч нь ажиллагааны удирдагчтай байнга холбоотой байж, түүний өгсөн үүргийн дагуу ажилладаг. Мөн түүнчлэн яриа хэлцэл хийх бүлэгт яриа хэлцэлийн явцад хөндлөнгөөс хяналт тавьж, яриа хэлцэл хийгчид зөвлөгөө өгөх зөвлөгч-мэргэжилтнүүд хамтран үүрэг гүйцэтгэдэг.

Хүн барьцаалсан талаар мэдээлэл авагдсан үед барьцаалагчдын зорилго, тэднийг ийм үйлдэл хийхэд хүргэсэн шалтгаан, гадны дэмжлэг байгаа эсэхийг нэн тэргүүнд тогтоох шаардлагатай.

Шуурхай үйл ажиллагааны явцад барьцаалагчдын тоо, тавьсан шаардлага, хувь хүний, насны, биеийн, сэтгэл зүйн онцлог, ял шийтгэл эдэлж байсан эсэх, тэдний сонгож эзэлсэн байр объект, өөрсдийн аюулгүй байдлыг хэрхэн хангасан, барьцаалагдагчдын саатуулж буй бодит нөхцөл, тэдэнтэй холбоотой эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх боломжтой этгээдүүдийг тодруулна.

Хүн барьцаалсан мэдээлэл авагдсан даруйд тусгай ажиллагаа явуулах шуурхай штаб байгуулагдан үйл ажиллагаа явуулах ба тусгай ажиллагаанд прокурор, тагнуул, хууль сахиулах байгууллага, цэрэг, материал-техникийн хангалт, эмнэлгийн ажилтнууд оролцож болно.

Барьцаалагдагчийн амь нас, эрүүл мэндэд учирч болох аюул, занал, байршил, цаг хугацаа болон цагийн байдалд нөлөө үзүүлэх боломжтой бусад чухал хүчин зүйлсээс хамаарч тусгай ажиллагаанд анхан шатны тактикийн төрөл бүрийн аргыг ашиглаж болно.

Эдгээрийн нэг нь тактикийн зөв яриа хэлцэл хийж, тэднийг хууль бус үйлдлээс нь татгалзуулах зорилгоор нь барьцаалагчидтай сэтгэл зүйн холбоо тогтоох арга юм. Энэ тохиолдолд яриа хэлцэл хийгчийн дүрд сонгогдох этгээд нь онцгой нөхцөл байдалд харилцан яриа явуулж, стандарт бус нөхцөл байдалд эсрэг талаас тавьсан саналыг судалж, зөв дүгнэж, бие даан шийдвэр гаргах, хүнтэй холбоо тогтоох чадвартай, сэтгэл зүйн хувьд тогтвортой

ажилтан байх шаардлагатай.

Яриа хэлцэлийн явцад барьцаалагчдаас цаг хожих зорилгоор оператив тоглолт явуулна. Барьцаалагчдын тавьсан шаардлагад тээврийн хэрэгсэл бэлэн бус байна, дээд удирдлагаас зөвшөөрөл авна гэх мэтээр төрөл бүрийн шалтаг тоочиж, маш удаан хугацаанд биелүүлэх шаардлагатай болдог.

Оператив тоглолтын нэгэн чухал хэсэг нь барьцаалагчийн зарим шаардлагыг биелүүлснийхээ төлөө барьцаалагдагчдаас тодорхой хэсгийг чөлөөлүүлэх арга байдаг.

Барьцаалагдагчдыг солилцож чадсан, эсвэл барьцаалагдагчдын хэсгийг чөлөөлж чадсан тохиолдолд тэднээс барьцаалагчид болон тэдний зэвсэглэл, үйл ажиллагааны цаашдын төлөвийг тодруулах зорилгоор мэдүүлэг авна.

Оператив тоглолтын үндсэн үүрэг нь барьцаалагдагчдыг чөлөөлөх тусгай ажиллагааг үр дүнтэй явуулахад оршдог бөгөөд агуулга нь барьцаалагчдын зарим шаардлагыг биелүүлэх ажиллагааг удаашруулах, дуурайлган үзүүлэх, эсвэл гэмтэлтэй зэвсэг, галт хэрэгсэл, унтуулах болон тайвшруулах бодистой хүнсний хэрэглэл, хар тамхи өгөх /хуурмаглал илрэх эрсдэлийг бууруулах зорилгоор эдгээрийг зөвхөн барьцаалагдагчдыг чөлөөлөх ажиллагааг эхлэхийн өмнө өгнө/, тэдний байрлал руу нууцаар дөхөх, нэвтрэх боломжтой газар, нөхцөл байдлыг тогтмол судлах, тавьсан шаардлагын дагуу бэлтгэсэн авто тээврийн болон нисэх хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэж байгааг тэдэнд харагдахаар гүйцэтгэх, зарим хүч, хэрэгслийг ажиллагааны бүсээс гаргах үйл ажиллагааг тэдэнд харагдахаар гүйцэтгэх үйл ажиллагаа, арга хэмжээнүүдээс бүрдэнэ.

Барьцаалагдагчдыг чөлөөлөлж, барьцаалагчдыг саатуулах ажиллагааг эхлэхийн өмнө барьцаалагчдын анхаарал, сонор сэрэмжийг сарниулж, ажиллагааг гэнэтийн байдлаар явуулах нөхцөлийг хангах зорилгоор яриа хэлцэл, оператив тоглолтыг улам идэвхжүүлдэг.

Барьцаалагчидтай яриа хэлцэл хийх үед дараах хүчин зүйлс[1]-д онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд:

- Тэдний тавьж буй шаардлага
- Тэдний дундаас хэн нэгэн нь барьцаалагдагчидтай зүй бус харьцсан, алах бодит санаа агуулж байгаагаа илэрхийлсэн эсэх
- Барьцаалагдагчдыг үе шаттайгаар суллах /шархдагсад, өвчтөн, өндөр настан, хүүхэд гэх мэт/ боломжтой эсэх
- Тэдний зүгээс гэмт үйлдлээ зөвтгөсөн мэдэгдэл, тайлбар хийж, түүндээ тууштай зогсож байгаа эсэх
- Барцаалагчдын зүгээс барьцаалагдагчдад хандах хандлагын ерөнхий төлөв
- Яриа, хэлцэлийн үед барьцаалагчдын ашиглаж буй тактик, арга, үндэслэл, техник хэрэгсэл, зэвсэглэл
- Барьцаалагчид болон барьцаалагдагчид ямар үндэстэн, ястан, овогт хамаарч байгаа зэрэг орно.

Анхан шатанд яриа хэлцэлийг сунжруулах шаардлагатай. Гэвч

[1] Зверев В. О. Проблемы переговоров с преступниками в условиях захвата заложников в психолого-юридической науке / В. О. Зверев, А. Е. Юрицин, В. Р. Гиль, С. В. Шевченко // Психопедагогика в правоохранительных органах. - 2014.

энэ нь асуудлыг шийдвэрлэх арга биш бөгөөд урьдчилан хэлэлцэж, барьцаалагдагчдын аюулгүй байдалд баталгаа авч, харилцан буулт хийлгүйгээр тэдний тавьсан шаардлагыг үе шаттайгаар биелүүлэх боломжгүй гэдгийг барьцаалагчдад ойлгуулах зорилго агуулсан оператив тоглолт явуулна. Яриа хэлцэлийн үед барьцаалагдагчидтай уулзаж, тэдний сэтгэл зүй, биеийн байдлыг судлах боломжийг олж авахад онцгой анхаарал хандуулах ёстой[2]. Энэ нь барьцаалагдагчдад сэтгэл зүйн хувьд тогтвортой байж, бодлогогүй алхам хийхээс урьдчилан сэргийлэх, ажиллагааны штабт нэмэлт мэдээлэл авах ач холбогдолтой байдаг. Мөн түүнчлэн яриа хэлцэлийн явцад барьцаалагчдад ажиллагааны удирдлагын зүгээс барьж буй бодлого сул байна гэсэн ойлголт төрүүлэхээс сэргийлэхийн тулд зарим тохиолдолд буулт хийх шаардлагатай. Ингээгүй тохиолдолд барьцаалагчдын тавьсан шаардлага нэмэгдэж, яриа хэлцэлийг үр дүнтэй үргэлжлүүлэх боломж хязгаарлагдаж, тэдний зан авир догширч, хүссэн шаардлагадаа хүрэхийн тулд барьцаалагдагчдад сэтгэл зүйн болон биеийн хүчний дарамт үзүүлж, амь нас, эрүүл мэндэд занал учруулах эрсдэлтэй. Онцгой шаардлага тулгараагүй тохиодолд хүч, хэрэгслийн давуу талыг барьцаалагчдад сурталчилах шаардлагагүй. Энэ нь барьцаалагчдын зүгээс хүчний байгууллагуудыг хүч хэрэглэх аргаас татгалзуулахын тулд шийдэмгий хариу үйлдэл үзүүлэхэд турхирч болзошгүй.

Ихэнх тохиолдолд барьцаалагдагчдын дундаас яриа хэлцэл хийх этгээдийг сонгох санал тавьдаг боловч, олон шалтгаан, хүчин зүйлсээс хамаарч хууль сахиулахын байгууллагын ажилтныг томилж, энэ үүргийг гүйцэтгүүлэх шаардлагатай байдаг. Уг ажилтан нь барьцаалагчдыг хүрээлэлд танил байвал тэднээр буулт хийлгэх магадлал өндөр болж, өөрөө биечлэн барьцаалагдагчдын аюулгүй байдалтай танилцах боломжтой болж, барьцаалагчдын байрлал, ямар арга хэлбэрээр барьцаалагдагчдыг хорьж байгаа, хэн нь бүлгийн толгойлогч, хэн хууль сахиулах байгууллагын хөдөлгөөн ажиллагаанд хяналт тавьж байгаа гэх мэтээр бүлгийн гишүүдийн үүргийн хуваарилалт, тэдний зэвсэглэл, барьцаалагчдын хооронд үл ойлголцол үүсэж байгаа эсэхийг тодруулна. Яриа хэлцэл хийгчийн хувьд анхан шатанд өөрийгөө маш сайн хянаж, өөрөө барцаалагдагч болохгүйн тулд ямар нэгэн бодлогогүй үйлдэл хийхээс болгоомжлох хэрэгтэй. Яриа хэлцэлийн санаачлагыг гартаа авч, эсрэг шаардлага тавьж барьцаалагчдад сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлжсэнээр тэдний идэвхийг бууруулах боломжтой. Ингэснээр тэд өөрсдийн төлөвлөгөөг өөрчилж, эсрэг тавьсан саналыг хэлэлцэж, үйл ажиллагааныхаа тактикийг өөрчилж, анхны бодомж болон шаардлагадаа өөрчлөлт, засвар оруулна. Энэ тохиолдолд тэдний жинхэнэ зорилгыг тодорхойлох боломж бүрдэж, хууль сахиулах байгууллагын бие бүрэлдэхүүн барьцаалагдагчдыг чөлөөлөх ажиллагааны арга, хэлбэрийг сонгоход хялбар болно.

Барцаалагчдын зүгээс

[2] Свободный Ф.К. Особенности ведения переговоров в ситуации захвата заложников: Методические рекомендации для курсантов, слушателей и практических работников органов внутренних дел и юстиции. -Барнаул: Барнаульский юридический институт МВД России, 2004.

барьцаалагдагч нарт хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх арга бол тэдний тавьсан шаардлагыг биелүүлэх боломжтой гэж итгүүлэх явдал юм. Яриа хэлцэлийн үйл ажиллагаанд прокурор, хууль сахиулах байгууллага болон орон нутгийн байгууллагын шийдвэр гаргах түвшний дээд удирдлагыг оролцуулахаас зайлсхийх шаардлагатай байдаг. Энэ нь нэгдүгээрт хууль сахиулах байгууллагын алба хаагчид шийдвэр гаргах эрхгүй мэт харагдуулж нэр хүндийг унагаах, хоёрдугаарт чухал шаардлагатай үед шуурхай штабын зүгээс дээд удирдлагатай та нарын тавьсан шаардлагыг зөвшилцөх шаардлагатай байна. Тэд хурал, цуглаанд хамрагдаж байгаа, нааш ирэх замдаа явж байгаа байна гэх зэргээр шалтаглаж цаг хожих боломж хязгаарлагдах эрсдэлтэй.

Барьцаалагчдын зүгээс согтууруулах болон мансууруулах бодис шаардах нь маш их аюултай байдаг. Хамгийн энгийн шийдэл нь барьцаалагдагчаар сольж болох боловч, ямар ч түвшний согтолт нь барьцаалагчийн үйлдлийг таамаглах боломжгүй, ихэнх тохиолдолд тэдний зан авирыг догшин болгодог тул ийм аргаар асуудлыг шийднэ гэж найдах шаардлагагүй. Гэвч бодит байдал дээр согтууруулах, мансууруулах бодисыг барьцаалагчдад шилжүүлж өгөх мөчид, эсвэл эдгээр бодисуудыг ашиглаад тэдэнд үйлчилж эхлэх мөчид нь барьцаалагдагчдыг чөлөөлөх ажиллагааг эхлүүлж байсан тохиолдлууд олон байдаг. Ийм ажиллагааг цаг хугацаа, хүч, хэрэгсэлийн тооцоог маш нарийн тооцож, барьцаалагч нэг бүрийн сэтгэл зүйн онцлогийг нарийн судалсны үндсэн дээр явуулдаг.

Яриа хэлцэл, оператив тоглолт явуулахад зохион байгуулалтын болон сэтгэл зүйн дараах аргыг ашигладаг. Үүнд:

- Яриа хэлцэл хийх аргыг сонгохдоо ухаалаг тохиролцоонд хүрэх боломжтой, эсвэл ядаж эсрэг талуудын хоорондын харьцааг барьцаалагдагчдад халдах түвшинд хүртэл муутгахааргүй байх ёстой.
- Барьцаалагчдын үйлдэл бүрээс сайн талыг нь олж харах, тэднийг гутаахгүй байж, хүн тус бүрийн сайн чанарт тулгуурлаж харьцах
- Барьцаалагчдын зүгээс эсэргүүцэлтэй тулгарсан ч гэсэн ямар ч тохиолдолд санаачлагыг үргэлж гартаа авч, харьцааг хадгалах арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх
- Яриа хэлцэл хийгч нь барьцаалагчдыг үзэн ядах сэтгэлгээнээсээ бүрэн салсан байх шаардлагатай
- Барцаалагчдыг анхааралтай сонсож, тэдний хэлсэн зүйлсийг маш сайн сонсож, ойлгож байна гэж мэдрүүлэх хэрэгтэй. Энэ нь барьцаалагчдад үзүүлж болох хамгийн хямд буулт юм.
- Яриа хэлцэлийг нэгэн зэрэг хэд хэдэн барьцаалагчтай, мөн түүнчлэн гадны хүний дэргэд хийхээс татгалзах
- Барьцаалагчдад тавьсан шаардлагадаа хугацааны хязгаар тогтоохоос зайлсхийх шаардлагатай. Энэ нь тэдэнд гарч чадахааргүй занганд орсон мэт сэтгэгдэл төрүүлсэнээс болж хүчтэй эсэргүүцэл үзүүлж болзошгүй.
- Барьцаалагчидтай хийх ээлжит яриа хэлцэлийг тодорхой хугацаа өнгөрч, тэднийг тайвширсны дараа хийх /үргэлжлүүлэх/ хэрэгтэй

Яриа хэлцэлд дүгнэлт хийж, цаашид барьцаалагчдын үйлдэл тааварлашгүй болж ирвэл яриа хэлцэлийг зогсоолгүй үргэлжлүүлэх шаардлагатай бөгөөд ажиллагааны удирдагч барьцаалагчдыг төөрөгдөлд оруулж, цаг хожих зорилгоор тэдний тавьсан шаардлагыг биелүүлж байгаа мэтээр харагдуулах ямар нэгэн үйлдэл, арга хэмжээг зохион байгуулах оператив тоглолтыг эхлүүлэх команд өгнө.

Яриа хэлцэлийг барьцаалагчдын тавьсан шаардлагыг биелүүлэх нөхцөлийн талаар үргэлжлүүлэн явуулах шаардлагатай. Барьцаалагчид сэтгэл зүйн дайралтад өртөж, олны дунд яриа хэлцэлийг үргэлжлүүлэх тактикийг ашиглан хүндрэл үүсгэдэг. Энэ үед ашиглах боломжтой эсрэг арга нь барьцаалагчдаас өөрийн төлөөлөгчийг сонгож, илүү тайван нөхцөлд яриа хэлцэлийг үргэлжлүүлэх санал тавьдаг. Барьцаалагчдын зүгээс тэдний төлөөлөгч бүлэглэлээс тусдаа байснаар хууль сахиулах байгууллагын нөлөөнд автах магадлалтай гэсэн болгоомжлол үүсдэг. Уг болгоомжлол, эргэлзээг арилгахын тэдний төлөөлөгчтэй хаана, хэзээ, хэрхэн холбоо тогтоох, яриа хэлцэлийн үр дүнг бусаддаа хэрхэн мэдэгдэх журмыг тогтоох боломжийг барьцаалагчдад өөрсдөд нь олгодог. Энэ нь яриа хэлцэлийг илүү тайван урсгалд оруулах магадлалтай.

Энэ үед барьцаалагчдад үзүүлэх сэтгэл зүйн нөлөөллийг идэвхжүүлж, санаачлагыг гартаа авахыг хичээх хэрэгтэй. Энэ үед сөргөлдөгч талуудын идэвх буурч, санаачлагыг авсан тал өөх хариугаа хэлэлцэн бодож, харин эсрэг тал нь өөрсдийн тавьсан шаардлагын дарааллыг алдаж, хориглолтын байр суурийг эзэлж эхэлдэг.

Амжилттай явагдсан яриа хэлцэлийн туршлагаас харахад яриа хэлцэлийн хамгийн чухал утга учир нь барьцаалагчид барьцаалагдагчдын амь нас, эрүүл мэндэд баталгаа гаргаж өгөх явдал байдаг. Ингээгүй тохиолдолд хуулийн дагуу зэвсэг хэрэглэн тэднийг устгах шаардлага тулгардаг. Яриа хэлцэлийн бүх үе шатын туршид барьцаалагчдад барьцаалагдагчдын эсрэг хүчирхийлэл үйлдүүлэхгүйн тулд тэдний тавьсан шаардлагыг биелүүлэх боломжтой гэсэн итгэлийг тасралтгүй төрүүлсээр байх ёстой[3].

Яриа хэлцэлийн явцад барьцаалагч тус бүрийн онцлогт тохируулан харьцаж, тэдний дотроос барьцаалагдагчдад илүү тайван байр суурь барьж, барьцалагдагчдыг суллахын төлөө байгаа этгээдүүдийг зохион байгуулагчийн эсрэг зогсоох байдлаар зохион байгуулагчийн хүч, байр суурийг сулруулруулахад онцгой анхаарч ажиллана. Харин барьцаалагчдын дунд үүссэн үйл ойлголцол, зөрчилдөөнийг яриа хэлцэл хийгч илрүүлж, шуурхай шийдвэрлэхэд нөлөөлөх хэрэгтэй. Батлагдаагүй мэдээлэлд итгэх шаардлагагүй. Энэ нь дахин хүндрэл үүсгэж, яриа хэлцэл тасалдах шалтаг болж магадгүй. Барьцаалагдагчдын тоог цөөлөхийг үргэлж хичээх хэрэгтэй. Ямар ч хамаагүй сэдлээр энэ асуудлыг тавьж, эхний ээлжинд эмэгтэйчүүд, хүүхэд, өвчтөн, өндөр настнуудыг суллуулах шаардлагатай. Барьцаанаас суллагдсан хүн бүр яриа хэлцэл хийгчийн хүрсэн амжилт болж байдаг. Яриа хэлцэл хийгчийн чадвар нь аливааг тооцоолон

[3] Квят Г. Л.Психологические аспекты ведения переговоров при освобождении заложников // Психопедагогика в правоохранительных органах. - 2002.

бодож, яриандаа хэрхэн завсарлага авахаас тодрон харагдаж байдаг. Энэ нь үүссэн цагийн байдлыг тал бүрээс нь судалж, яриа хэлэлцээний шинэ гарцыг нээх, аюулгүй байдлыг хангах боломж олгож байдаг. Яриа хэлцэлд завсарлага хийх нь барьцаалагчид сэтгэл зүйн дарамт үзүүлэх хүчтэй хэрэгсэл болдог. Мэдээллээр дутагдаж байх үедээ барьцаалагч нар өөртөө итгэлгүй болж, зорилгодоо хүрнэ гэдэгт эргэлзэж эхэлдэг.

Барьцаалагчдын жижиг хэмжээний шаардлагыг биелүүлж, тэдэнд хоол, хувцас, уух зүйл, тамхи өгөхдөө энэ нь хууль сахиулах байгууллагын зүгээс та бүхэнд сайн санаж хийж буй алхам гэдгийг цохон тэмдэглэж байх хэрэгтэй.

Нийгмийн төлөөлөл, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, орон нутгийн алдартан, лам хуврага болон барьцаалагчдын төрөл садан, ойр дотны хүмүүсийн төлөөллийг яриа хэлцэлд оролцуулах нь яриа хэлэлцээний явцад эерэг нөлөө үзүүлдэг. Гэвч тэднийг яриа хэлэлцээнд оролцуулахын өмнө тэдний үйл явдалд хандах хандлагыг нарийн судалж сонгон шалгаруулах шаардлагатай.

Барьцаалагчидтай хийх яриа хэлцэлийн хамгийн хүндрэлтэй асуудал нь тэдний тавьж байгаа нөхцөл бөгөөд барьцаалагдагчдын амь нас, эрүүл, мэндийн асуудал яригдаж байгаа тул ямар ч шаардлагыг зайлшгүй хэлэлцэх болдог . Тавьж буй нөхцөл нь тэдний эрх зүйн болон ёс суртахууны үнэлэмжээс хамаардаг. Зарим тохиолдолд хуулийн хүрээнд шийдчих боломжтой нөхцөлийг шаардах тохиолдлууд гардаг. Судалж үзсэн тохиолдлуудаас 34 хувьд нь хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой нөхцөл шаардсан байдаг байна. Үүнд тусгай комисс, прокурор, аюулгүй байдлын ажилтан, төрийн төлөөлөгч ирүүлж хууль, дотоод журам зөрчсөн тухай бодит болон худал мэдээллийг шалгуулах, санал, гомдлыг авч хэлэлцүүлэх, хувийн хүсэлтийг биелүүлэхэд хяналт тавиулах, шийтгэлийн хэмжээг бууруулах, хорих байгууллагын дэглэм, нөхцөлд гаргасан гомдол, өөр хорих байгуулагад шилжих хүсэлт, зарим албан тушаалтны үйлдэлийг үл хүлээн зөвшөөрөх зэрэг олон төрлийн шаардлагууд багтдаг.

Гэвч эдгээртэй зэрэгцэн бодит байдлаас зөрсөн, зохиомол, зөрчилдөөнтэй нөхцөл байдал үүсгэх зорилго агуулсан тохиолдлууд маш олон гардаг. Үндэслэлийн түвшингээсээ үл хамааран тэдгээрийг бүгдийг нь яриа хэлцэлийн аргаар эерэгээр шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгарч байдаг.

Ёс суртахууны талаасаа хуульд харшилсан шаардлагуудад хүн барьцаалж мөнгө, бусад үнэт зүйл нэхэмжлэх, холбооны, тээврийн хэрэгсэл гаргаж өгөх, гадаад орон руу гарах боломж олгох зэрэг шаардлагууд багтдаг. Мөн түүнчлэн зэвсэг, тэсрэх, хорт, бактериологийн бодис нэхэх, гэмт хэрэгтнийг хуулийн шалгалтын шат дамжлагагүйгээр суллуулах, өршөөл үзүүлэх, цагаатгахыг шаардах зэрэг ордог. Шаардлагыг биелүүлсэнээр тухайн үедээ эрсдэлээс урьдчилан сэргийлсэн мэт харагдах боловч, уг шаардлагын дагуу суллагдсан гэмт хэрэгтнүүд нь эрх чөлөөтэй болсноор цаашид нийгэмд ямар хохирол учруулж болохыг тааварлашгүй юм. Иймд хуульд харшилсан шаардлагыг биелүүлэх боломжгүй байдаг.

Бодит байдал дээр барьцаалагчидтай хийсэн яриа хэлцэл ихэнх тохиолдолд

биелүүлэх боломжгүй шаардлагын улмаас мухардалд орж төгсдөг. Яриа хэлцэл мухардалд орох нь хүч хэрэглэх тухай асуудлыг гаргаж ирдэг. Гэвч ийм арга хэмжээг зөвхөн барьцаалагдагчдын амь насыг хамгаалж үлдэхэд хамгийн таатай нөхцөлд авч хэрэгжүүлэх шаардлагтай. Мөн түүнчлэн уг арга хэмжээ нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон бусад иргэдийн амь намыг хамгаалах баталгааг хангасан байх ёстой. Энэ зорилгоор л яриа хэлцэлийг халхавч маягаар ашигладаг. Мөн чанар нь барьцаалагдагчдыг барьцаалагчдаас ялган салгаж, тусгай ажиллагааг амжилттай явуулж барьцаалагдагчдыг чөлөөлөх таатай нөхцөлийг бий болгоход оршдог.

Яриа хэлцэл гэсэн ойлголтын үндсэн утгыг яриа хэлцэлийг дуурайлгах үзүүлэх гэсэн ойлголтоос салгаж ойлгох хэрэгтэй. Үүнд сэтгэцийн өвчтэй этгээдтэй тулгарах тохиолдлыг ойлгож болно. Энд яриа хэлцэлийн субъект гэж байхгүй тул харилцан ярианы логик дараалалд онцгой анхаарах шаардлагатай. Иймд яриа хэлцэлийг дуурайлган үзүүлэх ажиллагааг түрэмгий шинжийг арилгахад чиглүүлж явуулна. Энэ тохиолдолд харилцан яриа нь сэтгэц заслын хэрэгслийн нөлөөллийг үзүүлдэг.

Зарим тохиолдолд хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, шархтан, өвчтөний оронд өөрийгөө барьцаанд үлдээх санаачлага гаргадаг. Гэвч өөрийгөө өргөл барьц болгосон зоригтой, эрсдэлтэй алхамыг зөвхөн тодорхой нөхцөл байдалд сайн дурын үндсэн дээр хийх боломжтой. Тэдний энэ үйлдэл нь барьцаалагчдын хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хандах онцлогт тулгуурлаж, сэтгэл зүйн нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй, барьцаалагчид, хохирогчдын сэтгэл хөдлөлийн ачааллыг бууруулах, тавьсан шаардлагыг биелүүлэх боломжтойд итгүүлэх, бие дааж өөрийгөө болон барьцаалагдагчдыг чөлөөлөх оролдлого хийхгүй байж, цаашид болсон явдлыг мөрдөн шалгахад чухал шаардлагатай үйл явдлыг нарийн тогтоож, баримтжуулахад чиглэгдэх ёстой. Гэвч сайн дураар барьцаалагдагч болсон хууль сахиулах байгууллагын ажилтны дүр нь гэмт хэргийн бусад хохирогчдоос онцгойрч харагдахад бус, харин хүний амь нас эрсдэх болон бусад хүнд үр дагавар гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдэх ёстой.

Хэрэв барьцаалагчидтай тодорхой хэлцэлд хүрч чадсан тохиолдолд хэлцэлцээ тасалдах, хуурмаглал байх, нөхцөл байдал хурцдахаас урьдчилан сэргийлж, барьцаалагдагчдыг аюулгүй чөлөөлөх нөхцөлийг нарийн тодорхойлж, барьцаалагчдыг саатуулах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байх ёстойг анхараарах шаардлагатай.

Дүгнэлт

Барьцаалагчтай яриа хэлцэл явуулах тактик ажиллагааг судалж үзэхэд яриа хэлцэл хийх нь тусгай ажиллагааг амжилттай явуулах гол үндэс болдог бөгөөд барьцаалагдагчийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, цаг хугацаа хожих, гэмт үйлдлээс учирч болох материалын хохирлыг багасгах, урьдчилан сэргийлэх, барьцаалагчдыг саатуулах, аюулгүй болгох зэрэг чухал үүргүүдийг хэрэгжүүлэх боломжийг олгодог. Яриа хэлцэлийг мэргэжлийн

өндөр түвшинд амжилттай явуулсанаар тусгай ажиллагааг ямар нэгэн хохиролгүйгээр амжилттай гүйцэтгэх нөхцөл болж байна. Үүний тулд яриа хэлцэл, оператив тоглолт явуулах аргад тусгай ажиллагааны бүлгийн удирдагч, бүрэлдэхүүн, нэн ялангуяа яриа хэлцэл хийгч алба хаагчийг сургаж дадлагажуулах нь чухал асуудал юм.

Уг тактик ажиллагааг цаашид илүү дэлгэрэнгүй судалж, зарим шаардлагатай ажиллагааг Монгол Улсын Хил хамгаалах байгуулагын Тусгай томилгоот салбар, бүлгүүдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, улсын хил, хилийн зурвас, бүс, хилийн боомтод хүн барьцаалсан гэмт хэрэг үйлдэгдэх, улсын хил зөрчигч, хуулийн байгууллагаас оргон зайлсан гэмт этгээдүүдийг эрсдэл, хохиролгүйгээр саатуулахад ашиглах боломжтой гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Зверев В. О. Проблемы переговоров с преступниками в условиях захвата заложников в психолого-юридической науке / В. О. Зверев, А. Е. Юрицин, В. Р. Гиль, С. В. Шевченко // Психопедагогика в правоохранительных органах. - 2014. - №2. - С. 35-39

2. Свободный Ф.К. Особенности ведения переговоров в ситуации захвата заложников: Методические рекомендации для курсантов, слушателей и практических работников органов внутренних дел и юстиции. -Барнаул: Барнаульский юридический институт МВД России, 2004. - 29 с.

3. Квят Г. Л.Психологические аспекты ведения переговоров при освобождении заложников // Психопедагогика в правоохранительных органах. - 2002. - № 2(18). - С. 109-112.

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

ХҮНИЙ СЭТГЭЛ САНААНЫ БАЙДЛЫГ СУДЛАХ АСУУДАЛД

Б.Эрдэнэ-Очир
Боловсрол судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор, судлаач

Товч агуулга

Хүн бол сэтгэлийн амьтан учраас өөрийнхөө сэтгэл, санааны байдлаа тухайн цаг дор мэдэрч, зөвөөр хандах нь маш чухал юм. Хүний сэтгэлд далд ухаан оршдогийг мэдэрч ухамсраа зөв зүгт залах хэрэгтэй. Хүний сэтгэхүйн доторх инерги нь гаднаа харагддаг.

Түлхүүр үгс: Сэтгэл, сэтгэл-санаа, ухамсар, далд ухамсар, өөрийгөө ялан дийлэхүй, оюун санааны эрчим.

"Ул сэтгэлд суурилсан ухаан бодол сайн сайхныг дуудах шидийн хүчтэй" Кетрин Бондер.

Хүний сэтгэл санааны байдал:

1. Сэтгэл
2. Сэтгэлийн тэнхээ
3. Сэтгэл санааны байдал
4. Биеийн ухаан
5. Хүний нөөц бололцоо

Нэг. Сэтгэл

Хүн оюуны чадвараараа амьдарч, ухамсраа өргөн дээдэлж явдаг сэтгэлийн амьтан юм. Эрүүл, саруул хувь хүн гэдэг нь үйлдэл, билэг ухаан, сүшиг бишрэлийн нэгдэл байдаг.

Хүний сэтгэл гэдэг танин мэдэхүйн асар уудам хязгааргүй орон зай юм. Сэтгэл нь хүний урам зориг, сэтгэцийн байдал ба эрүүл мэндийг тодорхойлдог.

Дорнын анагаах ухааны уламжлал нь сэтгэл ба биеийн зохицлын асуудлуудыг үзэх өөрийн үзлийг санал болгодог. Энэхүү үзлийн гол утга нь "оюун санаа бол биеийн байдлыг тодорхойлдог" гэдэгт оршино.

Хүний оюун ухаан, сэтгэл санаа, ухамсар өөрчлөгдөн, шинэчлэгдэж байгаа онцгой цаг үед бид нар амьдарч байгаа билээ. Энэхүү өөрчлөлт нь бидний гадаад орчинд төдийгүй дотоод ертөнцөд хүчтэй явагддаг. Хүний дотоод гүнд асар их хүч, гэрэл оршдог бөгөөд тэрхүү гэрлийг улам гэрэлтүүлэх хэрэгтэй.

Эрдэмтэд сэтгэлийг "Эрч хүч" хэмээн тэмдэглэдэг. Энэ нь хүний сэтгэл санаа, бодол ба оюун ухаан юм.

"Сайхан сэтгэл гэдэг хүний зүрхэнд орших бурхан юм" Ажаа гэгээн.

"Гаднаа ямагт бусдаас даруу бай!, гайхуулах хэрэггүй дотроо тэнгэр мэт бай!" О.Дашбалбар.

Хоёр. Сэтгэлийн тэнхээ

Хүний сэтгэлийн чадвар бол ертөнцийг танин мэдэх харьцаа, байр суурийн илрэл мөн. Иймээс хүний сэтгэл нь энэрэл хайраар ертөнцийг нигүүлсгэн харж өөрийн гэсэн зорилго, эрмэлзлийг агуулдаг. Хүний ямар ч нөхцөл байдлыг сэрж, даван туулах чадвар нь сэтгэлийн тэнхээ юм.

Сэтгэлийн тэнхээтэй хүн бол алсын хараатай, сэтгэлгээний чадвартай байдаг. Онцгой хүчтэй, хурц, тогтвортой сэтгэл мэдрэмж нь

астраль орон зайд материаллаг эрчим хүчний тогтолцоог бүрдүүлдэг. Сэтгэл нь хүрээлэн буй бүх юманд нөлөөлдөг. Түүний шинж чанар нь бүтээлч хүний эрчим хүчнээс шалтгаалдаг.

Хэрэв бид нар оюун ухааныхаа эелдэг чанарыг нигүүлсгэлтэй хослуулах юм бол хийж буй үйлдэл бүхэн зөв болдог.

Сэтгэл гэдэг хүний хувь заяанд асар их нөлөө үзүүлдэг сансарын онцгой хүч билээ. Хүн сайхан зүйлсийг үргэлж бодож, ном уншиж, өөрийгөө бясалгаж, үргэлж өөдрөг сэтгэлтэй явах юм бол үйл ажиллагаа нь улам сайн, сайхан болдог.

"Ууч сэтгэлд суурилсанаан бодол, сайн сайхныг дуудах шидийн хүчтэй" Кетрин Пондер.

Гурав. Хүний сэтгэл санааны байдал

Хүний тархи янз бүрийн санаа бодлыг тээж явдаг билээ. Харин сэтгэл санаа нь өдөр бүр харилцан адилгүй төвшинд байж, цаг хугацаа, тухайн байдлын аясаар үргэлж өөрчлөгдөж байдаг. Хүн гэдэг сэтгэлийн амьтан учраас сэтгэл санааны хөдлөлтийн байдалдаа тогтмол анхаарал тавьж, хянаж байх шаардлагатай юм.

Сэтгэл хөдлөлөө жолоодохын тулд далд ухамсар юу хэлэхийг хүсэж байгааг ойлгох нь маш чухал байдаг. Зөв арга хэмжээ авч чадахгүй бол сөрөг сэтгэл хөдлөл оршсоор байх болно. Сөрөг сэтгэл хөдлөлөөс ангижрахын тулд далд ухамсрын зорилгыг ойлгоод бодитой арга хэмжээ авсан үед сөрөг сэтгэл хөдлөл байхгүй болно. Ийм учраас сэтгэл санааныхаа өөрчлөлтөд байнга анхаарал тавьж, тайвшруулж, аль болохоор ямарваа нэгэн юманд энэрэнгүй, нигүүлсэнгүй хандаж байх хэрэгтэй.

Сэтгэл санааны хөдлөлтийн хэлбэрүүдийг дараах байдлаар илэрхийлэн үзүүлж байна. Үүнд: Хүснэгтэн мэдээлэл

№	Сэтгэл санааны байдал	Гэмтэх эрхтэнүүд	Илрэх шинж тэмдэг	Эмчлэх арга
	1	2	3	4
1	Стрестэх	Гэдэс, дотор	Хоол боловсруулах эрхтэний хямрал (ходоод, элэг, бөөр)	Амралт, тайвшралт
2	Санаа зовох	Хүзүүний нугаламын мэдрэлүүд	Хуян хөөрөх, мөрчилөх	Сэтгэл санаагаа тайван байлгах
3	Бухамдал	Парасимпатетик мэдрэлүүд	Нойргүйдэл	Тайван байх
4	Эргэлзээ ба тээнэгэлзэл	Автоматик мэдрэл	Нурууны доод үе, ууц нурууны олон ясны уулзварын өвдөлт	Нуруугаа цэх байлгах, эгц цэх суух
5	Хэт их айдас түгшүүр	Бөөр	Бөөрний бүх төрлийн өвчин	Оюун, ухаан санаагаа тайван байлгах
6	Сэтгэлийн дарамт	Ходоод	Хоолны шингэц муудах	Сэтгэлийн дарамтнаас ангижирах

7	Уурлаж хилэгнэх	Элэг	Элэгний бүх төрлийн өвчин, хавдар хатуурал	Энэрэх, итгүүлэх, бусдыг хайрлах
8	Сул дорой байдал, үлбэгэр, хүлцэнгүй, итгэлгүй, үхээнц байх	Нурууны бүх төрлийн өвчин, шаналал	Амьдрах эрч хүчгүй болох, үгүйлэгдэх	Аливаа зүйлд идэвхтэй, сонирхолтой байх
9	Тэвчээргүй зан чанар	Нойр булчирхай	Чихрийн шижин	Тэвчээртэй байх
10	Ганцаардал	Өнчин тархи	Зөнөх	Зугаалах, цэнгэх
11	Уйтгарлах, гуниглах	Цус	Цусны эргэлт, цусны бүх төрлийн өвчин	Баяр хөөртэй байх
12	Гомдол, цөхрөл	Арьс	Арьсны өвчин, өмөн үү, хавдар	Баярлах, талархаж байх

Японы анагаах ухааны эрдэмтэн, доктор Кацузо Нишигуй "Амин шимээр залуужихуйн увидас" гэдэг нэртэй номондоо ... "Өвчний гол үндэс нь хортой бодол санаа, мэдрэмжээс урган гарч байдаг. Элдэв буруу нөлөөтэй бодол санаа, мэдрэмжээ бүтээлч эрчим хүчээр солих шаардлагатай юм" гэж бичсэн байдаг.

Та өөрийнхөө бүхий л бодол, санааг төвлөрүүлж, сайн сайхан байгаагаа мэдэрч байвал хүсэж мөрөөдөж байгаа ирээдүйгээ бүтээж байгаа хэрэг юм.

Дөрөв. Биеийн ухаан:

Биеийн ухаан нь хүний далд ухамсар ба ухамсартай нягт холбоотой байдаг. Биеийн ухаан нь организмын физиологийн төвшинд харъяалагдаж, бидний далд ухамсарт хадгалагдана. Биеийн ухаан нь амьсгал, цусны эргэлт, хоол боловсруулах эрхтнүүд гэх мэт бие махбодийн физиологи үйл явцтай холбоотой далд ухамсрын үүргийг гүйцэтгэнэ.

Хүний сэтгэцэд "Биеийн ухаан" буюу "Доод манас" гэж нэрлэгддэг / тайлбар: "манас" гэдэг нь санскрит хэлээр "оюун ухаан" гэсэн үг юм/ далд ухамсрын өөрийгөө зохицуулах онцгой тогтолцоо байдаг гэж эртний Энэтхэгийн философийн сурвалж бичгүүдэд өгүүлдэг билээ.

Далд ухамсрын тогтолцоо нь өвчинтэй тэмцэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Ийм үед доод манас эхлээд астраль бие (нарийн бие)-д дараа нь физик биед зохицуулах нөлөө үзүүлдэг. Ийнхүү астраль бие бол доод манас, физиологи бие хоёрын хооронд зуучлагч нь болдог.

Астраль биеийн байдал бол биологи бүрхүүлийн хувьд өвөрмөц "эх загвар" юм. Хүний дээд зарчим "ухамсар" бол физик, астраль биеийн байдлыг жолоодох чадалтай эрчим хүч үүсгэдэг.

"Бие эхээс чадвар төгс төрөөгүй билээ. Эртний соёлд суралцаж эрдмийг эрлээр олсон бөлгөө" Хятадын их сэтгэгч Кунз.

Тав. Хүний нөөц бололцоо

Хүн хэмээх бодгаль байгалиас өөрийгөө эрүүлжүүлэх их хүч ба түүний үүсгэлийг авч төрсөн байдаг.

Гагцхүү хүн өөрөө түүнийгээ нээж

ашиглах учиртай юм. Хүн гэдэг оюун ухааныхаа чадварын аравхан (10%) хувийг хагас, дутуу ашигладаг билээ. Үлдсэн 90 хувийн нөөц бололцооныхоо багахан хэсгийг гэгээрэх, эрүүлжихийн тулд ашиглах ёстой юм. Эрдэм ухаанд гэгээрэн, гүн мэдлэг өгөх ном их уншвал хүний цохон дээрх аджна хүрд буюу билгийн нүд нь нээгддэг учиртай юм.

Хүний тамир тэнхээ, оюун болоод сэтгэлийн эрчим хүч, чадал ид шидийн гайхамшиг нь нарны аймгаас ирж байгаа эрчим хүчний давтамжаас ихээхэн шалтгаалдаг. Байгалийн нарны эрчим хүч ба сэтгэлгээний хүчний аль алиныг нь зөв ашиглах хэрэгтэй. Хүн бол орон зйд сэтгэлийн эрчим хүчийг зарцуулж, солилцдог нарийн олон хэмжээст цогцолбор юм.

Дүгнэлт

Хүний сэтгэхүйн дээд үйл ажиллагааны үндэс нь эерэг сэтгэхүй юм. Хүнтэй эелдэг харьцаж, үргэлж эерэг инерги цацруулж явбал үйл хэрэг нь үргэлж бүтэмжтэй байх болно. Хүний таван мэдрэхүй (нүд, чих, хэл, хамар, арьс)-гээс таатай мэдрэмж төрөх тусам мэдрэх чадвар хөгждөг. Хүн бүхэнд аугаа хүч, тэнхээ заяагдсан байдаг бөгөөд сэтгэл санаагаа тогтворжуулж, зоригтой, зорилгодоо хүрэх итгэл төгс, эрмэлзэлтэй байх хэрэгтэй.

Ашигласан ном зүй

1. Б.Эрдэнэ-Очир. Боловсрол судлал, сэтгэл судлалын чиглэлээр бичсэн "Магистрын зэрэг хамгаалсан бүтээлүүд" Улсын Багшийн Дээд Сургууль. УБ.1997 он

2. Доктор, профессор А.Муратхан, Ц.Пүрэв, Б.Эрдэнэ-Очир "Судалгааны арга зүй" Хилийн цэргийн дээд сургууль (ХЦДС). УБ хот, 2004 он

3. Б.Эрдэнэ-Очир "Оюун ухааны чадавхын онцлог" Хилийн цэргийн дээд сургууль (ХЦДС). УБ хот. 2019 он

ХИЛИЙН ТҮҮХ

1911 ОНЫ ЦИЦИКАРЫН ХИЛИЙН ГЭРЭЭ

Цагааны Ганболд
Доктор , профессор

Хаант Орос – Манж Чин улсын хоорондын хил,хилийн харилцаа үүсэх асуудал урт удаан хугацааны туршид бүрэлдэн бий болсон бөгөөд 17 – р зуунд Оросууд анх Сибирь , Амур орчимд ирснээс эхэлсэн.

Хаант Орос – Манж Чин улсын хооронд хилийн болон худалдааны харилцааг тодорхойлсон олон гэрээ байгуулагдсан байдаг бөгөөд тэдгээрийг он дараалаар нь жагсаавал:

- Нэрчүгийн хилийн гэрээ 1689-08-12
- Буурын хилийн гэрээ 1727-08-20 , 1727-10-12
- Хиагтын хилийн гэрээ 1727-10-21 , /1728-06-14/
- Хиагтийн гэрээ 1792-02-08
- Кульджийн гэрээ 1851-07-25, /13
- Айгунийн гэрээ 1858-05-16
- Тяньцзинийн гэрээ 1858-06-13
- Бээжингийн гэрээ 1860-11-02
- Чугучакийн /Тарвагатайн / протокол 1864-09-25,
- Ховдын протокол 1869-08-02
- Улиастай протокол 1869-08-23
- Ливадийн гэрээ 1879-10-20
- Петербургийн гэрээ 1881-02-12
- Москвагийн гэрээ 1896
- Бээжингийн гэрээ 1898
- Боксёрын /Иэтунханы/ протокол 1901
- Цицикарын гэрээ 1911- 12-07

1911 – 12- 07 –ны өдөр Цицикарын гэрээг байгуулсан бөгөөд энэ гэрээгээр Тарваган дахийн 58 дугаар хилийн тэмдэгтээс Авгайт уул дах 63 дугаар овоо хүртэл , цаашлаад Аргунь гол Амур мөрөнтэй нийлдэг уулзвар хүртэлх хилийн хэсгийг техникийн хувьд тодотгон тогтоосон . Энэ гэрээг манайхан огт мэддэггүй бөгөөд уг гэрээг мөн Манжуурын станцийн дэргэд байгуулсан хилийн гэрээ гэж нэрлэдэг,Хаант Орос-Манж Чин улсын хооронд байгуулсан сүүлчийн хилийн гэрээ юм.

1904-1905 оны Орос-Японы дайн нь Алс Дорнотод өөрийн нөлөөллийн хүрээг бий болгоход л чиглэгдэж байсан бөгөөд Оросууд ялагдан Зүүн хойт Хятад дах байр сууриа Япончуудад тавьж өгсөн . Дараагийн жилүүдэд Монголд нөлөөллөө тогтоохын төлөө бүх анхаарлаа тавих нь тодорхой болоод байлаа. Япончууд 1910 онд Солонгосын хойгийг эзлэн авсан нь эх газарт Японы байр суурийг бэхжүүлэв.Үүсэн бий болсон энэ нөхцөл байдлууд нь Нэрчүгийн болон Хиагтийн гэрээгээр тодорхойлон тогтоосон хилийн байдалд нөлөөлөх болсон.Нэрчүгийн гэрээгээр Манжийн харьяанд байгаад 1858 оны Айгуны хилийн гэрээгээр Оросын харьяалалд орсон Амур орчны нутаг дэвсгэр ямар нэгэн өөрчлөлтгүйгээр ,оросын дипломатууд ямар нэгэн асуудал тавьж байсангүй өдий хүрчээ.Ийм байдлаар Манж Чин улс Аргунь голын зүүн эрэг дэх оросын хуучин эзэмшил газрыг хадгалсаар ирсэн.XX зууны эхэн хүртэл Аргунь орчмын хилийн талаар талууд ямар нэгэн маргаангүй ирсэн байдаг.XX

зууны эхний арван жилийн төгсгөлд хил дээрх Монгол харуулуудыг Хятадын хилийн харуулуудаар сольж эхэлсэн нь Оросын засгийн газрын анхаарлыг татаж,Тарваган дахийн уулаас Аргунь гол хүртэлх хилийн шугамын явалтыг дахин тогтоох сэдлийг төрүүлсэн байдаг.

Мөн Нэрчүгийн гэрээний орос,манж хэл дээрх хувиудад нь Аргунаар хил тогтоосон тухайд утга агуулгын ихээхэн зөрүүтэй байдал илэрсэн байдаг. Орос хувилбарт, хилийг Аргунаар " оройд нь хүртэл" гэж тусгасан бол манж болон хятад хувилбарт Аргуны "орой" гэсэн үг огт дурьдагдаагүй байдаг.Энэ нь гэрээ байгуулах үед орос хэлний өвөрмөц хэллэгийг гадаад хэлэнд буулгахдаа анхааралгүйтэй холбоотой .Энэ байдлыг Манжийн тал овжиноор ашиглан Аргуны дээд эхний газар нутагт иргэдээ суурьшуулж эхэлсэн нь хожим Монголийн нутаг дэвсгэрт орос-хятадын эзэмшил газрыг заагласн тогтооход маргаан үүсэх нөхцөл байдлыг бий болгосон байдаг.1727 онд Хиагтын гэрээг байгуулах үед С.Л.Рагузинский Аргуны"орой"-г Манжийн харьяатуудаас чөлөөлөхийг шаардаж,энэ нь Нэрчүгийн хилийн гэрээний 2 дугаар заалтыг зөрчиж байна гэдгийг сануулсан байдаг./ АВПРИ.Ф."Сношения Россий с Китаем".Оп.62/1,1725.Д.12а.Л.213-213 об./

Үүний хариу болгож Манжийн дипломатууд гэрээний заалтын агуулгыг илтээр мушгин гуйвуулсан хариу өгөхдөө " Энх тайванч гэрээнд Аргунь голын хил гэдгийг Манжийн талаас орой хүртэл гэж тусгасан бол Оросын талаас ямарч оройг дурьдаагүй " гэж мэдэгдэл хийсэн байна.1909 оны 5 дугаар сарын эхээр тухайн газар орон дээр хил орчмын газар нутгийг судлуулахаар Эрхүүгийн ерөнхий захирагчаас Жанжин штабын хурандаа Н.А.Ждановыг томилсон байна. Газар орон дээрх судалгааны үйл ажиллагааг Манжийн тал эсэргүүцэн угтсан бөгөөд 1909 оны 6 дугаар сарын 21-нд Хайлаастын харуулын хилийн хэсэгт Аргунь голын хуучин гольдролийг маргаантай хэмээх Хавцгайтын аралд судалгаа хийж байсан Оросын газрын зургийн офицеруудыг Хятадын хилийн харуулын цэргүүд буудсан явдал гарав.Оросын талын хүчтэй эсэргүүцлийн дүнд Манжийн тал энэ будлианы төлөө уучлал гуйсан байна./ АВПРИ.Ф."Китайский стол".Д.1168.Л.26-27,30-31./

Хилийг дахин тодотгох ажил гурван хэсэгт явагдах байлаа. Ажлын төлөвлөгөөнд:Аргунь,Шилка голын уулзвараас дээш Дунд Борзоо хүртэл,энд Аргунь гол хад чулуутай хэсгээр урсдаг учраас хамгийн гүнзгий хэсэг буюу фарватерийг тогтоох ,ингэснээр талуудын арлын харьяалал тодорхой болох, Дунд Борзоогоос Хуучин Хайлаарын адаг хүртлэх хэсгийг тогтоох,энэ хэсэгт гол тал хээрээр урсдаг учраас үндсэн гольдролоо өөрчлөх нь их бөгөөд гол нь Буурийн гэрээгээр хил тодорхойлсон хуучин гольдролыг олж тогтоох,эцэст нь Хуучин Хайлаарын адгаас Тарваган дах хүртлэх хилийн шугамд өөрчлөлт оруулах асуудал байжээ.

Энэ хилийн хэсэгт ойролцоо нэртэй газрууд олон байгаа болон хил хамгаалалтгүй байдал зэрэг нь Оросын газрын зургийг алдаатай үйлдэхэд хүргэжээ. И.Я.Короствцын үзэж байгаагаар бол " Хятадын газрын

зурагт улсын хил арай илүү бодит, зөв чиглэлээр, бидэнд ашигтай байхаар тэмдэглэгдсэн төдийгүй гэрээний заалттай тохирч байна" гэжээ. / Л.56 об./

Нутаг дэвсгэрийн маргаантай асуудал үүсэн бий болсон үндсэн шалтгааныг Оросын тал дараах байдлаар тодорхойлж байсан байна. Архивын ихээхэн материалыг судлан, орос,хятадын газрын зургуудыг харьцуулан жишиж үзэн,газар орон дээр туршуул,үзлэг хийхэд одоогийн байгаа хил нь Буурын гэрээгээр тодорхойлохдоо болон овоо тэмдэгтүүдийг босгосон байрлалаа харилцан зөвшилцөөгүйгээс үүдэлтэй гэжээ,оросын талын саналаар бол Буурын гэрээг байгуулах үед Аргунь голыг Булингарт татуурга / Мутной Проток буюу Куладжа/ гэж нэрлэдэг Далай нуурт цутгадаг голын эхтэй адилтган үзсэнтэй холбоотой гэж тайлбарласан байна.Оросын талын газрын зураг дээр энэ бүх газар орныг Хятадад харьяалалтай гэж тэмдэглэгдсэн боловч үнэн хэрэгтээ Орост харьяалалтай болохыг тогтоожээ. Энэ газар орны төлөө Авгайт тосгоны хасгууд болон хятадуудын хооронд маргаан тэмцэл өрнөж байсан байна.Мөн Манжуурын станц болон Манжуур тосгон Хятадын нутаг дэвсгэр дээр биш харин Оросын нутагт байгааг албан ёсны бүх газрын зураг нотолж байгаа нь тодорхой болжээ. Оросын талын төлөөлөгчдын саналаар бол улсын хил 58 дугаар овоо тэмдэгт болох Тарваган дахаас Цагаан –Уул /59-р овоо/,Таван толгой/60-р овоо/,Сокту толгой/61-р овоо/,цаашлаад Авгайт уулан дээрх 63-р овоо хүрэх бөгөөд Авгайт уул нь Дунд Хайлаарын адгийн эсрэг Булингарт татуургаар өнөөгийн Аргунь голын уулзвар хүрэх байсан. Байр зүйн тэмдэгтүүдийг тодруулахад Авгайт нэртэй уул нь хоёр байх бөгөөд хоёул Аргунь голын баруун эрэгт байгаа нь тодорхой болжээ. Авгайт тосгоны ойролцоо орших эхний Авгайт уулын эсрэг талд Хайлаар голын адаг байхгүй бөгөөд харин хоёр дахь Авгайт нь Буурын гэрээнд заагдсан Дунд Хайлаарын адагт байгаа нь тогтоогдож ,түүн дээр бөөн чулууг овоолж босгосон тэмдэгт байжээ. Ийм байдлаар Эрдэнэ толгойн овооноос цааш хил нь хятадын харуулын ойролцоо орших Авгайт уулаар дайрах байв.Хоёр дах маргаантай хэсэг нь Аргунаас Стрелкийн адаг хүртэл урсгал дагуу байлаа.Аргунь голын хөндий элсэрхэг учраас жил бүр болох үерийн улмаас эргээ идэж,энэ нь Оросын талын налуу эргийн нураан эвдэж өөрчлөлт оруулж байв.Үүний үр дүнд хуучин гольдрол нь зүүн талруугаа шилжиж,олон тооны арал,сайр үүсгэсэн бөгөөд Аргунь,Шилка голын уулзварт Кручина,Степной,Капцугай туевский зэрэг арлууд үүссэн.Голын үндсэн гольдрол зүүн тийш шилжих байдал Буурын гэрээ байгуулах тэр үеэс л үргэлжиж байсныг геологийн шинжилгээ,Нэрчүгийн тойргийн газар хуваарьлалтын төлөвлөгөө зураг зэргээс тодорхой харагдаж байсан. Оросын тал энэ бүгдийг судлан үзээд Аргунь голын гольдрол зүүн эрэг дагуу байх бөгөөд харин хуучин гольдрол түүнтэй зэрэгцээ оршиж байгааг тогтоосон. Баруун буюу Хятадын талын эрэг дагуу Хайгинская гэж нэрлэгдэх хилийн харуулын зам байх ба зам дагуу хилийн овоо тэмдэгтүүдийн зарим хадгалагдан үлджээ. Мөн хятадын харуулын байр байсаар

байлаа.Үүний зэрэгцээ орос,монголын харуулаас хил зөрчигч,хулгайлагдсан мал,хууль бус худалдааны бараа таваар,бичиг баримтгүй этгээдүүдийг хүлээлгэн өгдөг байсан газрын ул мөр Аргунь гоын зүүн эрэг дээр болон арал дээр бус хуучин гольдролын цаана байгааг илрүүлжээ. Өөрөөр хэлбэл,Монголчуудын хил гэж тооцож байсан хилийн шугам дээрх хилийн "овоо" юм.

И.Я.Коростовец ,Буурын гэрээ байгуулснаас хойш хилийн шугамын явалттай холбоотой ямар нэгэн үл ойлголцол,маргаан гарч байгаагүйг онцлон тэмдэглээд "Одоогийн Хятадуудын гаргаж байгаа үйлдэл бол бидний салан задгай,өөрийн улсын хилийн талаарх мэдлэг муутай ,олон мянган га үржил шимтэй газраа ашиглаагүй ирсэн байдлыг ашиглаж байгаатай холбоотой.Энэ байдалд бид өөрсдөө ямар нэгэн байдлаар буруутай бөгөөд манай засгийн газраас сайн хөршийн харилцаат бодлогыг хэрэгжүүлэхдээ өөрийн нутаг дэвсгэрийн эрх ашгийг идэвхтэй хамгаалаагүй нь нэг ёсондоо Хятадуудын газар нутгийн өнгөлзлөгийг дэмжсэн юм шиг ойлгогдож байна.Бидний хувь хамгийн таагүй зүйл бол орон нутгийн хасагууд өөрсдийн газар нутгийг хятадуудад малын бэлчээр,хадлангийн талбайн зориулалтаар түрээслүүлж байсан явдал бөгөөд тэд өөрийн нутаг дээр юм шиг бэхжиж суурьшиж байсанд оршино.Мөн үүний зэрэгцээ манай хасагууд, хэрвээ түрээсэлж буй газар нь Оросын харьяанд шилжвэл ичгүүртэй байдалд орно гэдгээсээ айж эмээн эдгээр газрууд нь Хятадынх гэж батлах оролдлогуудыг хийх болсон" гэжээ./АВПРИ.Л.58./

1910 дугаар сарын 2 дугаар сард Н.А.Ждановыг хил тогтоох комиссын даргаар,түүний туслахаар тухайн үед Хайлаарт томилолтоор ажиллаж байсан Гадаад Явдлын Яамны түшмэл Усатыйг томилсон.

1910 оны 5 дугаар сарын 17-нд Манжуур станцад Орос-Манжийн хил тогтоох комиссийн анхдугаар хуралдаан болж,талууд 1727 оны Буурын гэрээний монгол хэл дээрх эхийг үндсэн бичиг баримт болгох,монгол хэлийг хэлэлцээр явуулах албан ёсны хэлээр харилцан зөвшилцжээ./АВПРИ.Л.129./ Анхны хуралдаан явцад л төлөөлөгчдийн бүрэн эрхийн асуудалд ялгаатай байдал илэрч ,Н.А.Жданов хилийн асуудлыг хэлэлцэх төдийгүй газар орон дээр нь тэмдэглэх хүртэл эрхтэй байсан бол Хятадын төлөөлөгч даотай Сун ийм өргөн эрхгүй бөгөөд зөвхөн хилийн асуудлыг хэлэлцэх эрхтэй байжээ. Үүнтэй холбоотойгоор хятадын тал эхлээд хил рүү явж тэнд үзлэг хийх саналыг тавьсан бол Жданов эхлээд хилтэй холбоотой газрын зураг,бичиг баримтуудыг үзэж судлах саналтайгаа тавьж байв.Гэвч энэ байр суурийг нь удирдлагаас Оросын дипломат бодлогын алдаа гэж үзсэн.

1910-05-23-нд Манжуур станцад ирсэн И.Я.Коростовец ,газар дээр нь комиссийн үйл ажиллагаатай танилцаад, " Хилийг онолын хувьд сулахад бид өөрийн хөзрөө ил болгож, тавих асуудал тодорхой болох юм. Хятадууд манай санал бодлыг мэдсэний үндсэн дээр хил тогтоох асуудлаас цааргалах аюултай" гэсэн зааварчилгаа өгчээ./АВПРИ.Л.129.об.-130./Иймээс И.Я Коростовец , оросын комисст аль болохоор хурдан хил явахыг

санал болгож , ингэснээр Хятадын тал оросын талаас тавих шаардлагыг мэдэх боломжийг багасгаж,ямар нэг шалтгаанаар хилийг хамтран шалгахаас татгалзахаас болон 1881 оны Орос-Хятадын гэрээг дахин хэлэлцэх 1911 он хүртэл сунжруулахгүй байхыг анхааруулсан.

Оросын төлөөлөгчид,Хятадын засгийн газраас Аргунь орчим дах газар нутгийн маргааныг далимдуулж, өмнө байгуулсан хилийн гэрээг өөрчлөхөд хүргэх бий гэдгээс ихэд болгоомжилж байжээ.И.Я.Коростовец,Н.А.Ждановт хятадын төлөөлөчтэй хил рүү хамт явж,маргаантай нутаг дэвсгэрт биечлэн очих,хамтарсан үзлэг хийсэн талаар протокол хийхийг даалгасан байдаг. / АВПРИ.Л.130-130 об./

Хятадын тал,Оросын талын шийдвэрээ гэнэт ингэж өөрчилсөнд ихэд сэжиглэнгүй хандаж, өөрсдийн өмнө тавьсан хил явах саналаасаа татгалзсан ./ АВПРИ.Л.133./

Ийм нөхцөл байдалтай холбоотойгоор хэлэлцээр мухардалд орж,талууд завсарлага авах болсон. Хэлэлцээрийн явцад зарим нэг газар зүйн нэр томьёо,ойлголт болон хилийн шугамын явалтыг тодорхойлсон тэмдэгтэд зөрүү гарч ирсэн бөгөөд оросын талын төлөөлөгчид завсарлагааны хугацаанд өөрсдийн тавьж буй асуудлыг баталгаажуулсан олон бичиг баримтуудыг цуглуулсан байдаг.Тухайлбал,Хайлааст нуурын эрэг дэх 59 дугаар тэмдэгт,Авгайт уул,Хайларын адагтай холбогдох 63 дугаар тэмдэгттэй холбогдох материалуудыг цуглуулсан байна.

1910 оны 7 дугаар сарын 22-нд Усатый Бээжин дэх элчиндээ явуулсан мэдээндээ:" Энэ үед Оросын комисс Владивосток хот дах Дорно дахины хүрээлэнгийн номын сангаас ихээхэн үнэ цэнэтэй материалуудыг олж авлаа. Архивын материалыг олж судлах ,сонгоход энэ хүрээлэнгийн профессор Н.В.Кюнер,Е.Г.Спальвин нар идэвхтэй оролцсон болно.Эдгээр бичиг баримтууд нь цэвэр хятад эх сурвалж учраас хятадууд үгүйсгэхэд хүндрэлтэй байх болно." гэж мэдээлсэн байна.

Би дараах бичиг баримтуудыг олж авлаа.Үүнд:

-" Хэй-лун-цзян-гой-чжи" хэмээх маш ховор гар бичмэл,

- Хэй-лун-цзян-шу-лио – Краткое описание Хэйлунцзянской провинции – Хэйлунцуй мужийн товч бичиглэл,

- Шэн-цзян-гой-туи хэмээх 18 дугаар зууны хятадын газрын зураг,

- 1898 онд Хөлөнбуйрын мужийн захиргаанаас гаргасан Хөлөнбуйрын мужийн нууц тэмдэглэлийн манж хэл дээрх хуулбар,

- Хувийн архиваас олсон Ли-фань-юань-цзэ-ли - Гадаад харилцааны тэнхимийн журамийн орчуулга болон хэд хэдэн чухал ном байгаа болно" гэжээ./ АВПРИ.Л.211об.-213 об./

1911 оны 1 дүгээр сарын 27-нд Оросын ГЯЯ-наас хэлэлцээр хийх төлөөлөгчдийн тэргүүнээр хошууч генерал Н.П.Путиловыг томилсон./ АВПРИ.Л.29-37./

Хятадын талын төлөөлөгчдийн тэргүүнээр Хэйлунцу мужийн амбан захирагч түшмэл Чжоу Шимо томилогджээ. Цицикар хотод 1911-06-10-ны өдөр хэлэлцээр эхэлсэн.Газар зүйн нэр томьёоны ойлголтын зөрүүгээс хэлэлцээр дахин мухардалд орсон нь Хятадын тал 58 дугаар тэмдэгтийн эхлэх цэгээр гэрээнд заагдаагүй Тарваган дах уулыг авч,гэрээний дагуух

хилийн асуудлаас булцсанаас үүдэлтэй ба талууд нэгэнт байгуулсан хилийн гэрээнд өөрчлөлт оруулах,нэмэлт хийх эрх , үүрэг байхгүй байсан.Комисс зөвхөн 1727 оны 10 дугаар сарын 12-ны өдөр солилцсон захидал болон түүний хавсралтын үндсэн дээр тухайн хэсгийн асуудлыг л авч хэлэлцэх байлаа.Солилцсон захидал,түүний хавсралтад Тарваган дах бол уул гэсэн нэгч үсэг ,өгүүлбэр байгаагүй ба харин эсрэгээрээ хавсралтад байх Оросын харуулуудын жагсаалтад 13 дугаар оросын харуул Тарваган дах нуурын дэргэдэх хилийн овооны ойролцоо байрлана гэж заажээ.58 дугаар тэмдэгт,Тарваган дахийн байрлалыг тодорхойлохын тулд хоёр талын комиссарууд гэрээний эхлэлийн цэгээр Тарваган дах нуурыг авах ёстой байв. Тарваган дах уул бол зохиомол бөгөөд 58 дугаар тэмдэгтийг эхлэх цэгээр тооцохгүй байхыг эрмэлзэж байв. Манжийн төлөөлөгч Сун ,Тарваган дахыг уул хэмээн үзэж,үүнийгээ гэрээн дэх Сокту болон Авгайтыг уул гэж тодорхой заагаагүйч тэд бол ууланд хамаарагдахаар байсан гэж шалтаглаж байсан ба тэгээд ч 1910 онд хоёр талын комисс уул гэж тохирсон байжээ. Үүнээс гадна Суны Сокту,Авгайтаар жишээ татсан нь буруу бөгөөд солилцсон захидалд Авгайт бол толгой / сопка/ гэж заасан байсан./ АВПРИ.Ф."китайский стол".Д.1169.Ч.2.Л.58./

1911 оны 8 сар дуустал хэлэлцээрт ямар нэг өөрчлөлт гарсан,урагшилсан зүйл гараагүй бөгөөд талууд бие биеэ буулт хийхийг хүлээсэн байдалтай байв.

1911 оны 8 дугаар сарын 27-ны өдөр И.Я.Коростовец өөрийн сайддаа" Генерал Путиловын мэдээлж байгаагаар бол хэлэлцээр хаашаач хөдлөхгүй таг зогссон ба гарч буй бэрхшээл саадыг харилцан буулт хийх замаар л тухайлбал,маргаантай нутаг дэвсгэрийг тэг дундуур нь хуваан авч болох юм.Таньд сонордуулахад ,хэлэлцээрийн явцад хилийн эхлэх цэгийг Тарваган дах уулаас өмнө зүгт 8 верст газар Тарваган дах нуур луу шилжүүлсэн бөгөөд энэ нь генерал Путиловын үзэж байгаагаар бол тухайн буулт бидний ашиг сонирхолыг хангаж байна.Манай талын шаардлагын хамгийн бага нь л гэхэд Манжуурын орос тосгоны казарм,хувийн орон сууц бүхий хэсэг,мөн станцыг Хятадын талд шилжүүлэн өгөх нь олон улсын маргааныг бий болгохгүй юм" гэжээ./АВПРИ.Ф."Китайский стол".Д.1169.Ч.2.Л.97./

1911 оны 10 дугаар сарын 10-ны өдөр болсон хамтарсан комиссийн 13 дугаар хуралдаанаас Аргунь голын адгаас Аргунь станц хүртлэх 87 арлын 56-г нь Оросын талд,31 арлыг Хятадын талд шилжүүлэх төслийг сайшаасан байна.Хаант Оросын Засгийн газрын урт удаанаар үргэлжилсэн хилийн маргааныг хурдан зохицуулж дуусах,мөн буулт хийхэд бэлэн байгаа нь зөвхөн Хятадын талын баримталж буй хатуу байр сууриас гадна Хятадад хүчээ авч буй хувьсгалт хөдөлгөөнөөс шалтгаалж байсан юм.

Бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан ГЯЯ-ны сайд А.А.Нератов,И.Я.Коростовецоор дамжуулан генерал Н.П.Путиловт эцсийн зааварчилгаа өгсөн. Уг зааварчилгаад:" Манжуур станцын дэргэд явагдаж буй Орос-Хятадын хилийн хэлэлцээрийн явцыг шүүн хэлэлцээд,Сайд нарын зөвлөл дараах

асуудлаар буулт хийх нь зүйтэй гэж үзэв.Куланджинск,Шарасунскийн хөндийгөөр хил тогтоохдоо эдгээрийг Оросын харьяанд үлдээх,харин Манжуур тосгон болон станцыг Хятадын харьяанд үлдээх нь зүйтэй. Чингэхдээ Хятадын талын Манжуур тосгон болон станц орчмын нутаг дэвсгэр угаасаа Хятадынх байсан гэсэн шаардлагыг зөв байсан гэж хүлээн авч буй асуудал огт биш гэдгийг анхааруулах ёстой. Асуудлыг ингэж хүлээн аваагүй тохиолдолд бид дээрх хөндий газрууд болон Манжуур тосгон,станц орчмыг өөрийн харьяанд авах болно гэдгийг сануул "гэжээ./ АВПРИ.Л.231./

Цицикарийн хилийн протоколд 1911-12-07-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан.

Гэрээ байгуулсны дараагийн өдөр генерал Путилов,И.Я.Коросто вецид"Тарваган Дахаас Авгайт уул ,цаашлаад Аргунь голоор түүний адаг хүртэлх хилийг тогтоосон протоколыг байгуулж ,гарын үсэг зуран,тамга тэмдгээр баталгаажуулсан болно. Куладж,Шарасуны хөндий Оросын харьяанд үлдэж,Манжуур тосгон,станц ойр орчмын нутаг дэвсгэрийн хамт Хятадын харьяанд үлдэв.Аргунь голын зарим нэг жижиг арлыг эс тооцвол бүх томоохон арлууд Оросын талд орлоо" гэж мэдээлж байжээ./АВПРИ.Л.239./

Цицикарын протокол,хил тогтоох комиссийн бичиг баримтуудыг соёрхон баталгаажуулах,талууд онцгойлон бүртгэхийг урьдчилан тохироогүй байсан бөгөөд протокол гарын үсэг зурсан тэр цаг үеэс хүчин төгөлдөр болсон байдаг. Бээжин дэх Оросын элчин ба Хятадын ГЯЯ хооронд тусгай гэрээг нот солилцох замаар баталгаажуулжээ. Харин хилийг газар орон дээр тогтоон тэмдэглэх ажил удаан хугацаанд үргэлжилсэн байна. Цицикарын 1911 оны протоколоор улсын хилийг тогтоон тэмдэглэх ажиллагааг техникийн хувьд л нарийвчлан тодорхойлсон байна.

1911 оны Хаант Орос-Манж Чин улсын хооронд байгуулсан хамгийн сүүлийн олон улсын гэрээ гэгдэх Цицикарын хилийн протокол Монгол Улсад ямар үр нөлөө үзүүлсэн бэ? гэдэг асуудал гарах нь зүй ёсны юм.

Түүхийн ухааны доктор Б.Цэдэн – Ишийн " Монгол Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс" номын 219-р талд "Монгол нутгийн хойт захаар 1727 онд тогтоосон хилийн 58-р овоог Тарваган дах гэдэг нэртэй газар босгожээ.Тарваган дахын овоо нь Халх,Баргын нутгийн хоорондох уулзварт тохирч байдаг.Тарваган дахын овооны тэр хавьд тодорхой тэмдэг болох өндөрлөг байхгүй.Гэхдээ тэр хавьдаа сууриараа холбоотой хэдэн намхан толгод байдаг.Тэдний хамгийн өмнө захын бусдаасаа арай өндөр толгой дээр нь Халхын Зах Хөвөлзөх харуул,Баргын Цагаан уулын харуулын хооронд хайчийн овоо байжээ.Энэ хайчийн овоон дээр буюу түүний хойт талын намхан толгой дээр Монголын харуулын эртний овоо байжээ.1727 оны гэрээгээр хил тогтоож,хилийн 58-р овоог Монголын харуулын орхигдсон хоосон овооны хойт зүгт тал газарт босгожээ" гэж тэмдэглэжээ.

Судлаач Г.Хүүжий 2003 онд бичсэн " Монгол улсын хилийн түүхэнд холбогдох зарим асуудлууд" бүтээлийнхээ 133-135 дугаар талд : " Хаант Орос-Манж гүрний хооронд 1727 онд Буурын голд байгуулсан хилийн

гэрээний дагуу Хиагтаас Эргүнэ мөрний Авгайт уул хүртэл 63 хилийн овоо босгосон билээ. Тэдгээрийн 58 дугаар овоог Тарваган дах гэдэг газар босгосон гэж тэр үед үйлдсэн данс бүртгэлд дурьдсан байдаг.

Тарваган дахын овоо нь Хаант Орос, Халх, Барга гурван этгээдийн хилийн уулзварт байсан бөгөөд тэр нь одоо Монгол Улс, Оросын Холбооны Улс, БНХАУ-ын хилийн зүүн уулзвар байх ёстой юм. Гэтэл одоогийн гурван улсын хилийн зүүн уулзварт байгаа Тарваган дахын овоо нь байршил, хэмжээгээрээ 1727 онд босгосон овоо биш болох нь нотлогдсон боловч, бид одоогийн гурван улсын хилийн зүүн уулзвар болж байгаа хөх саарал өнгийн том, том чулуугаар овоолж босгосон ганц овооны дунд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын зүүн уулзварын цэг байна гэж тодорхойлсон болно.Үүний иш үндэслэл нь:

1.БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын 1976 оны хилийн гэрээний "Зүүн хэсэг" дэх улсын хилийн шугамын тодорхойлолтод дурьдсан нь:" Хилийн шугам...зүүн урд зүгт эргэн шулуун шугамаар явж 645.0 тоот өндөрлөг дэх Тарваган дахын /Тарбаган дах/хилийн 58 дугаар овоо хүрнэ" гэжээ.

2.БНМАУ, БНХАУ-ын хилийн гэрээний нэгдүгээр зүйлийн 25-р хэсгийн төгсгөлд дурьдсан нь:"Хилийн шугам нь... Ширчингийн оргил/ Ширчин овоо /хүрч, дараа нь шулуун шугамаар явж Тарган Цагаан нуур / Тарган нуур/-аас зүүн хойно байгаа монгол, хятадын хилийн шугамын зүүн үзүүрийн эцсийн цэг болох 645.0 тоот өндөрлөг бүхий Тарваган дахын овоо/ 645.5 тоот өндөрлөг/-д хүрнэ" гэж тус тус хэлэлцэн тохирсон байна.

3.БНХАУ, ОХУ-ын хоорондын дорнод хилийг тогтоон тэмдэглэх ажил 1993 оноос эхлэн явагдаж байлаа. Хятадын ГЯЯ-ны төлөөлөгч ЛИ Цинь Юань 1992 оны 7-р сард манайд мэдэгдэхдээ "Хятад, Оросын дорнод хилийн шугам нь 645.0 өндөрлөг дээр орших Тарваган дах гэж нэрлэдэг овоо /овоолсон чулуу/ -ны төвөөс эхэлнэ." гэж хятад,оросын гэрээнд заасан гэсэн билээ.

4.Миний бие1993 оны 5-р сард БНХАУ, ОХУ-ын хилийн дагуу Тарваган дахаас Манжуур хот хүртэл явахдаа 1727 онд босгосон Шар толгой, Бор толгойн овоонуудыг олж харах бололцоо олдсон юм. Хятадын надад зааж өгсөн хоёр овоо нь байршил,хэмжээгээрээ дээр дурьдсан овоонууд биш байлаа. Хятадууд, Хаант Орос, Манж гүрний хооронд 1911 онд хийсэн хэлэлцээрээр энэ хэсэгт хилийн шугамыг хятад руу дотогшлуулсан юм гэж ярьж байгаа нь үнэн байж болно. Үүнтэй хамт Тарваган дахын овоо урагшилсан гэсэн дүгнэлт хийж болох боловч 1911 оны хэлэлцээрийн тухай баримт бичиг Гадаад Харилцааны болон Хилийн түүхийн архивт байхгүй байгаа нь албан ёсоор нотлож болохгүй байна.

5.1993 оны 5-р сард БНХАУ-ын Манжуур хотод энэ асуудлаар хийсэн гурван улсын мэргэжилтнүүдийн ажлын уулзалтаар тохиролцсоны дагуу гурван улсын хилийн Баруун уулзварын цэгийг багажаар тодорхойлон 1:25000-ны газрын зураг үйлдэж,хэвлэх ажлыг Оросын тал, Зүүн уулзварын цэгийг багажаар тодорхойлж 1:10000-ны газрын зураг үйлдэж хэвлэхийг БНХАУ-ын тал тус тус хийсэн.

Хилийн Зүүн уулзварын

цэгт босгосон “0” дугаар бүхий тэмдгийн зургийг Монголын тал, хилийн тэмдгийг БНХАУ, суурийн байгуулалтыг ОХУ-ын тал тус тус хийж 1993 онд газар дээр нь босгосны гадна 645.0 тоот өндөрлөг дээр байгаа Тарваган дахын овоо гэж тэмдэглэжээ.

Миний хувьд дээрх судлаачдын тодорхойлолт,дүгнэлтүүдтэй санал нэг байгаа бөгөөд дараах тодотголыг хийж байна. Одоогийн Гурван улсын хилийн Зүүн уулзварт байгаа Тарваган дахын 58-р овоо бол 1727 онд босгосон түүхэн хилийн овоо биш бөгөөд Цицикарийн 1911 оны гэрээ дагуу хуучин байрлалаасаа 8 верст буюу ойролцоогоор 8,5 км дотогш Тарган цагаан нуурын зүг зөөн тэмдэглэгдсэн овоо юм. Тарган цагаан нуурыг тэр үед ,гэрээнд Тарваган дахын нуур гэж үзэж байсан байдаг.1727 онд босгосон түүхт 58-р овоо бол ОХУ-ын нутагт байгаа бөгөөд одоогийн хэрэглэж буй 1:200000 зурагт 742,0 тоот өндөрлөг гэж тэмдэглэдсэн ,Б.Цэдэн –Иш гуайн тодорхойлсноор өмнө захын бусдаасаа арай өндөр шовх толгой дээр байсан байх магадлалтай. Тарваган дахын 58-р овооноос зүүн тийшх 59,60,61,62,63-р овоонуудыг Баргын 5 овоо гэж түүхэнд тэмдэглэсэн байдаг. Овооны нэршлийн хувьд өмнө тодорхой дурьдсан бөгөөд Шар толгойн овоо, Бор толгойн овоо гэсэн нэршил Баргын таван овоонд байхгүй болохыг залруулж байна. 62-р овооны нэршлийг олж тогтоохоор орос,монгол олон эх сурвалжийг шүүрдэн тунгаасан эрлийн эцэст “Эрдэнэ овоо-маяк Эрденэ” нэртэй болохыг А.Н.Хохловын “Российский дипломат И.Я.Коростовец и его роль в подготовке Цицакарского протокола 1911г.” хэмээх 2012 онд бичсэн өгүүллэгт байршил, байдлыг тодорхой тэмдэглэснийг олж харах, тогтоох боломж олдов.

Хэдийгээр хилийн гэрээний заалт, агуулгын дагуу овоо тэмдэгтийн байрлалыг 184 жилийн дараа тодорхой болгож залруулж байгаа боловч Монгол Улсын газар нутгаас багагүй хэсэг Орос, Хятадын нутагт орсон байгаа нь тодорхой юм.

ГАЗАР ДЭЭР НЬ МАГАДЛАН ХЭМЖИХЭД МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ 448 МЕТР ГАЗАРТАЙГАА ХЯТАДЫН НУТАГТ ОРСОН БАЙСАН

Х.Уянга

"Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн баатарын тэмдэг зүүж өгөөд гар барихдаа Ерөнхийлөгч "Улсынхаа тусгаар тогтнолд оруулсан хувь нэмрийг тань үнэлж, энэ шагналыг олголоо" гэсэн" хэмээгээд энэ хүний хоолой зангирч, туулсан замналынх нь ул мөр болж үлдсэн олон гүн үрчлээстэй зовхи нь чийгтээд ирэв. Гурван цаг гаруй хөөрөлдөхөд "Ёстой л баатар ажээ" гэсэн бодол улам лавширч, хүндлэл, хайр цээж дүүргэж, миний нүдэнд ч нулимс цийлэгнэв. Төрийнхөө тэргүүнээс "Улсынхаа тусгаар тогтнолд оруулсан хувь нэмрийг тань үнэлж байна" гэсэн үг сонсоход ямар мэдрэмж төрдөг бол гэж төсөөлөхөд одоо ч бахархал, уярал сүлэлдээд байна.

Хэдхэн хоногийн өмнө Хөдөлмөрийн баатар болсон хүн одон медалиа зүүгээд, найрын ширээний ард сууж байгаа болов уу хэмээн төсөөлсөөр очсон намайг Б.Рагчаа гуай тэс өөрөөр угтсан. Тэрбээр энд тэндээ цоорсон, ажлын хувцас, гэрийн шаахайтай ногооны талбайд ажиллаж байв. Үрээр тарьж буй нялх мод, жимсний бутнуудаа арчилж тордож, тэднийгээ эргэж тойрох нь Б.Рагчаа гуайн хамгийн дуртай ажил гэнэ. 90 нас дөхөж яваа гэхээргүй хөнгөн шингэн тэрбээр "Би өөрийгөө магтах дургүй, дэмий юм" гэсэн Тэгээд дуугаа хураачсан "зөрүүд" өвгөнтэй ийнхүү хөөрөлдлөө.

ХОЁР ХӨГШИН УЙЛААД БАЙХААР НЬ ДОЛООН САРТАЙ БАГА ДҮҮГЭЭ ӨВӨРТӨЛЖ АВААЧААД ӨГЧИХСӨН

-Та Увс аймгийн Цагаанхайрхан сумын хүн юм байна. Бага нас тань нутагтаа өнгөрөв үү?

-Манайх зуугаад бог, хориод адуу, арав гаруй тэмээтэй, Ханхөхийн нурууны ард зусаж, Наадмаас хойш хярд гардаг, наймдугаар сарын дундууд говь руугаа орж, Хяргас нуурын зүүнтээ, Хурган нуруу, Хулжийн гол, Айраг нуур хавиар намарждаг, өвөлдөө Ханхөхийнхөө өврийг бараддаг айл байв. Бага нас минь тэнд өнгөрсөн. Аав минь багийн дарга, нэг их том баадан бүсэлсэн, дуусдаггүй ажилтай хүн л явах. Тэр үед багийн дарга нарт хөлс мөнгө өгдөггүй, зүгээр л томилчихдог, нөгөөдүүл нь сайн дурааараа ажилладаг байсан болов уу гэж би боддог.

Аав өөрөө бүх нийтийг бичиг үсэгтэй болгох хөдөлгөөний ухуулга хийдэг болохоор хүүхдээ юу гэж сургуулиас завсардуулах билээ, намайг яг насанд маань сургуульд оруулсан. Тэр үед онц сурдаггүй ч сахилга бат сайтай хүүхдийг сургуулийн захиргаанаас шагнадаг байлаа. Тэгэхдээ ээж, аавыг нь дуудаж, сумын Улаан булангийн индэрт хоёуланг нь зогсоогоод, хүүхдэд нь дэвтэр, харандаа, чанасан өвчүү зэргийг өгнө. Би нэг бус удаа тийм шагнал авсан.

-Тэр үед ч, одоо ч, хөдөөгийн хүүхдүүд сургуульд сурахад тулгардаг хамгийн том асуудал нь

байр, амьдрах газар. Дотуур байранд суусан, айлд амьдарсантай холбоотой сонин дурсамжаасаа хуваалцаач.

-Би дөрөвдүгээр ангид ортлоо хамаатнуудындаа суугаад, дараа жилээс нь танихгүй шахам айлд байх болов. Тэднийх хүүхэдгүй, нөхөр нь лам байгаад, хожим хар болж, артельд ажилд орсон, эхнэр нь юм оёдог, уран авгай байлаа. Аав минь намайг тэднийд нэг хонины махтай аваачаад орхисон. Манайх олон (долоо) хүүхэдтэй болохоор хайхардаггүй байсан юм уу, хичээлийн амралтаар ч намайг авдаггүй байв. Аав намар тарваганд явахдаа л хааяа морио бариулах гэж дагуулдаг байж билээ. Би тэр айлд гурван жил сууж, бүр хүүхэд шиг нь болсон.

Түлээ мод бэлтгэх, ус, мөс зөөх гээд гэрт, гадаах бүх ажлыг нь хийнэ. Их нямбай хүмүүс байсан болохоор хоол, унд хийхийг надад сайн зааж, сургасан. Би долдугаар ангиа төгсөөд Улаанбаатар руу явна гэхэд хоёр хөгшин "Бид яана вэ" гээд уйлаад байхаар нь би долоон сартай бага дүүгээ өвөртөлж аваачаад өгчихөж билээ. Тэр хоёрыг өрөвдөж, хүүхэдтэй болгож байгаа нь тэр.

-Аав, ээж тань зөвшөөрсөн байдаг байгаа?

-Ээжээс асуутал "Аавдаа хэл" гэсэн. Аав "Ээж чинь л зөвшөөрч байвал яах вэ. Би ороод яриадхъя" гэсэн. Тэгэхээр нь би дүүгээ өвөртлөөд сумын төв рүү шогшчихсон. Манайх сумын төвөөс зүүн хойш арав гаруй км зайтай Ха шаатын аманд нутаглаж байсан юм.

-Та сумандаа долдугаар анги төгсөөд Улаанбаатарт ирсэн юм уу?

-Тийм. Уг нь аймгийн арван жилийн сургуульд хуваарилсан юм. Гэтэл манай сумаас аавын ахын хүү Сэмбээхэй гэж надаас сайн сурлагатай хүү, бас сурлага, сахилгагүйгээрээ алдартай Галбаа хоёр хот руу явна, техникумд сурна гэж байна. Тэгэхээр нь би аймагт очсон ч хүн танихгүй, газар мэдэхгүй, хаана ч адилхан айлын хаяа бараадахаас хойш нэгмөсөн Улаанбаатар явъя гэж шийдээд Холбооны техникумын хуваарь авсан.

Манай сумд амралтаараа хотоос ирсэн МУИС-ийн хоёр оюутан, Мал ба тариалангийн яамны нэг албан хаагч, өөр хаана ч ажилладаг билээ, нэг хүн морин өртөөгөөр явна гэж байсан. Тэдэнтэй хамт явах болоод аймгийн төвд иртэл Өндөрхангай, Зүүнхангайн хэдэн банди нийлчихсэн, хотын машинд сууна гэцгээж байна. Тэдэнтэй нийлж, сар гаруй явж байж хотын бараа харсан даа.

Би аймгаас Холбооны техникумын хуваарьаваадгарсанчГалбаа,Сэмбээхэй хоёрыг дагаад Мал эмнэлгийн техникумын гидротехникийн ангид орсон. Гидротехник гэж юуг хэлдгийг ч мэдэхгүй шүү дээ. Тэнд би онцгой сайн сурлагатай биш, бас муу ч үгүй, Галбаа, Элдэв, Сэмбээхэйгийн араас, дөрөвдүгээрт ордог байв. Нутгийнх юм болохоор Сэмбээ, Галбаа, бид гурав нийлнэ. Галбаа маань Сэмбээхэй, бид хоёрыг зодчихно. Галбаа сурлага сайтай ч аюултай сахилгагүй. Нутагтаа байхад нохой хутгалсан, хүүхэд зодлоо, хүний юм булаасан гээд түүний л тухай дуулдах.

Техникумд ирээд сурагчдын зөвлөлийн гишүүн болчихсон л дээгүүр даналзана. Би болж өгвөл ахиухан хоол олж идчихээд хичээлээ л хийхийг боддог оюутан байлаа. Залуучууд хичээлээ тараад түүнийг хүргэж өгнө, үүнийг дөхүүлж өгнө гээд явчихна, нийлж дарвиж, зодолдоно. Би өрөөндөө хичээлээ л хийж сууна. Намайг хүүхдүүд их бүрэг гэдэг байсан нь ортой байх.

-Таны тодорхойлолтыг уншиж байхад Монгол Улсад геодези, зураг

зүйн салбарыг үүсгэж, хөгжүүлсэн анхдагчдын нэг нь юм билээ. Тэр үед үүнийгээ ойлгож байв уу?

-Юугаа мэдэх вэ. Аав "Сургуулиа төгсөөд нутагтаа ирвэл сайн байна. Увсад хуваарь олдохгүй бол Архангай их сайхан байгальтай нутаг шүү. Бүр болохгүй бол Завханд ирэхийг бодоорой" гэсэн юм. Сургуулиа төгслөө. Увсын хуваарийг Галбаа авчихсан гэж сонсоод "Нутагтаа очно гэж горьдолтгүй боллоо. Хаана хуваарилдаг юм бол" гэж бодсоор очтол "Мал ба газар тариалангийн яамны Усны аж ахуйн хэлтсээс хуваариа аваад Архангай руу яв" гэв.

Хэдэн хувцсаа шуудайд хийж, үүрээд Тээврийн товчоонд шуудангийн машин хүлээж зогстол Архангайн Жигмэд, манай сайн эр Галбаа хоёр "Чамайг Ж.Чогдон багш дуудаж байна" гэсээр гүйгээд ирлээ. Шуудайтай хувцсаа үүрсээр очтол багш "Чамайг Гиваадэмбэрэл авна гэлээ. Төв хорооноос усалгаатай газар тариалан хөгжүүлэх шийдвэр гаргаж, үүнийг хийхийн тулд яаманд Газрын зургийн отряд байгуулсан. Тэнд газрын зураг хийх хүн хэрэгтэй" гэв.

Ингээд 1951 оны наймдугаар сард Мал ба газар тариалангийн яамны Усны аж ахуйн хэлтсийн газрын зургийн отрядад топо техникчээр орсон. Тэгэхэд манайх боловсон хүчин муутай байлаа. Монгол Улсын хэмжээнд долоохон инженер байсан гээд бод доо. Барилгын Б.Мотоо, хар Дорж (механикийн), франц Ж.Дүгэрсүрэн (Налайхын нүүрсний уурхайг нээсэн геологич), газар ухагч Должинжав (өрмийн) герман Цэвэг, дөрвөд Ж.Чогдон (усны) гээд л нэр, хоч, мэргэжлээр нь мэддэг, тоолоход гарын хуруунд багтна.

-Багш үнэлдэг, ажил хийгээд цааш явах боломжтой гэж үзсэн хүүхдүүдээ дуудсан хэрэг байх даа.

-Зөөлөн чихтэй болохоор нь сонгосон хэрэг болов уу даа. 1951 онд Мал ба газар тариалангийн яамны Усны аж ахуйн хэлтсийн газрын зургийн отрядад топо техникчээр орж, инженер, даргаар нь 1965 он хүртэл ажилласан. Энэ хугацаанд усалгаатай газар тариалан хөгжүүлэх зорилгоор 17 газарт, нийт 8562 га талбайд байр зүйн зураг хийсэн.

Булган аймгийн Ингэттолгойн сангийн аж ахуйн Хужир, Бух, Харлаг, Хараацай, Тариахтай, Ингэт голын 364, Төв аймгийн Батсүмбэрийн Сөгнөгөрт 690, Үдлэгт 134, Борнуурын Бороо голд 280, Борнуурын Арангатад 57, Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн Шар талд 61, Шаамарын тохойд 10, Дорнод аймгийн Хэрлэнгийн Цагаан талбайд 10, Баянтүмэнгийн Дээд Чойбалсанд 250, Хэнтий аймгийн Өндөрхаанд 70, Өвөрхангай аймгийн Арвайхээрийн талд 120, Алтан талд 20, Говь-Алтай аймгийн Гуулингийн талд 4000, Баян-Өлгий аймгийн Баяннуурт 160, Ховд аймгийн Онцын хөдөөд 2000, Өвдөгийн аманд 30, Баянхонгор аймгийн Хэрсэнгийн талд 306 га газрын байр зүйн зургийг манай отряд хийсэн. Бид тэр газруудад усалгааны системийн толгойн барилга барих, суваг, шуудуу татах газрын зургийг авч, трассыг тогтоон, зүсэлт гаргасан. Үүний дагуу дээрх томоохон сангийн аж ахуйнуудын усалгааны системийн ажил хийгдсэн.

-Москвад мэргэжлийн хичээл, далага ажлаараа орос оюутнуудад биширэгдсэн гэж сонссон.


-Надад өөрийгөө магтаж ярих юм алга. Хээзээнээсээ тийм сэтгэгдэл ч үгүй явж ирсэн хүн. Би долдугаар анги төгсөөд техникумд элссэн учраас Газрын зургийн отрядад ажиллах завсраа оройгоор 8-10 дугаар ангид сурсан юм. Уг нь тоо, физикийн

хичээлдээ гайгүй, багш маань надад конспектоо үлдээчихдэг, би хичээлийг нь заачихдаг байсан юм. Төсгөлтийн шалгалтад монгол хэл, химийн хичээлдээ үлгэн салган дунд, тоондоо гайгүй, орос хэлний хичээлд муу авлаа. Хамгийн сүүлд физикийн шалгалтад "Юухан байх вэ" гэж ороод муу авчихдаг байгаа. Ингээд гадаадад сургуульд явах өнгөрсөн байх гэж бодож явтал яам хөөцөлдөж байгаад Москвагийн Газар зохион байгуулалтын дээд сургуульд явуулсан.

Эхлээд би газар зохион байгуулалтын ангид хуваарилагдсан юм. Орос хэл муутай хүн лекцнээс юу ч ойлгодоггүй. 14 хоног ийм маягаар яваад дээд курсийн монголчуудаа "Юу ч ойлгохгүй, ёстой хэцүү юм" гэтэл "Би чамаас дор байсан. Тэгж байгаад сурна" л гэнэ. "Ер нь бүтэхгүй нь. Би геодезийн хүн, газар зохион байгуулалтын ангид сурахгүй. Ангиа солих арга байна уу" гэтэл "Элчин сайдтай уулзахаас наашгүй" гэлээ. Элчин сайдтай уулзтал "Төв хороо л шийднэ. Бид Төв хороонд уламжлаад, хариуг нь хэлье" гэв. Ингээд Төв хорооны хариуг хүлээж, өглөө бүр Элчин сайдын яаманд очдог, хашаан доторхыг шүүрдэж, мод услах гэх мэтийн ажил хийдэг боллоо.

Арваад хоногийн дараа ашгүй нэг зөвшөөрсөн хариу ирснээр тэнд 1954-1959 онд сурч, геодезийн инженер мэргэжлээр төгссөн. Мэргэжлийн, шугам зураг, газрын зургийн хичээлд зэгсэн гайгүй, түүх, философи гэх мэтийн хичээлээс оргонгоо алдаад сууж байдаг муухан оюутан байлаа. Дадлагын хичээлд харин манай ангийнхан миний л амыг хардаг байсан нь үнэн шүү.

1959 онд төгсөж ирээд ХАА-ны Усны аж ахуйн хэлтсийн Хайгуул судалгаа, газрын зургийн экспидицэд инженерээр хуваарилагдаж, тэндхийн газрын зургийнхан гэж арав гаруй хүнтэй нийлэн, усжуулалтын талбайн байр зүйн зураг гаргах ажлаа үргэлжлүүлсэн. Жил ажиллаад дарга болж, 1965 он хүртэл ажилласан.



480 ГАРУЙ ГА ГАЗРЫГ МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРУУЛСАН

-Монгол Улс тусгаар тогтнолоо олон улсад хүлээн зөвшөөрүүлээд удаагүй, хоёр хөрштэйгөө хилийн асуудлаа эцэслэн шийдэхээр ид ажиллаж байсан эгзэгтэй он жилүүдэд Та Хилийн комисст ажилласан юм билээ?

-1963-1990 он хүртэл таван удаагийн томоохон ажилд оролцсон. 1963-1964 онд Монгол, Хятадын хилийн гэрээг газар дээр нь тогтоон, тэмдэглэх хилийн хамтарсан комисст шинжээчээр, 1976 онд БНМАУ, ЗСБНХУ-ын хилийн гэрээ байгуулах комиссын гишүүнээр, 1976-1978 онд БНМАУ, ЗСБНХУ-ын хилийн гэрээ байгуулж, түүнийг газар дээр нь тогтоон, тэмдэглэх, хилийн хамтарсан комисст Монголын талын хэсгийн

гишүүнээр, 1982-1984 онд Монгол, Хятадын хилийг газар дээр нь анх удаа хамтран шалгах комисст гишүүнээр, 1989-1990 онд БНМАУ, ЗСБНХУ-ын хилийг анх удаа хамтран шалгах Монгол талын комиссын техникийн асуудал хариуцсан орлогч даргаар томилогдож байв. Товчхон хэлэхэд, Монгол Улсын бүх хилийн шугамын дагуух хээрийн ажлыг удирдан зохион байгуулах ажил гүйцэтгэсэн.

-Тэр жилүүдийн талаар ярих зүйл их бий нь гарцаагүй. Монгол, Хятадын хилийг газар дээр нь тогтоон, тэмдэглэх комиссын гишүүнээр ажилласан тухайгаа хуучлаач?

-1963-1964 онд Монгол Улсын Засгийн газраас байгуулсан Монгол, Хятадын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх комиссын бүрэлдэ хүүнд орж ажилласан. 1962 оны арванхоёрдугаар сарын 26-нд Монгол, Хятад хоёр улс хилийн гэрээ байгуулсан бөгөөд Хилийн комисс тэр гэрээг газар дээр буулгах үүрэгтэй байсан юм.

Өөрөөр хэлбэл зурагт тэмдэглэсэн зураасыг газар дээр нь буулгаж, хилийн шугамаа тогтоон, баганаа босгоно гэсэн үг. Энэ бол геодезийн ажил. Хилийн комисст 13 хүн ажиллаж байсны долоо нь жинхэнэ гишүүн. Надаас бусад нь генерал, хурандаа нар. Гадаад явдлын яамнаас орсон хүн дээрээс өгсөн чиг үүргийг хүлээж авах, хоёр талын хэлэлцээр хийхэд хуралдаан удирдах үүрэгтэй. Хилийн цэргийнхэн материал хангамж, биеийн хүчний ажлыг хийнэ. Цэг хаана тавих, хилийн шугам яг хаагуур явахыг геодезийн хүн, өөрөөр хэлбэл би хариуцна. Манай комиссынхон намайг хөнгөн хөлт гэдэг байлаа. Хэмжих, тогтоох ажлыг би л хийдэг, энд тэнд гүйж явдаг болохоор тэр.

-Хилийг газар дээр нь тогтоон, тэмдэглэх нь амаргүй ажил байлгүй. Хоёр улсын аль аль нь л газраа алдахгүй, болж өгвөл сөөмийг боловч өөрийн нутагт оруулахыг боддог болов уу, яадаг бол?

-Тэгэлгүй яах вэ. Хилийн шугамыг зургаас газар дээр буулгах амаргүй ажил. Нэг см-т нэг км багтдаг. Тэгэхээр нэг мм нь 100 метр, харандааны үзүүр хүрсэн хэсэгт 10-20 метр байгаа шүү дээ. Тэгэхээр хамгийн наад зах нь тэр нарийхан зураасны ард байгаа 10-20 метр газрыг хааш нь оруулах вэ гэдэг асуудал үүснэ. Сөөм газраа авах уу, алдах уу гэдгийг тэнд ажиллаж байгаа геодези, газрын зургийнхан л шийднэ шүү дээ.

Шугам, газар хоёрын зөрүү, маргаантай газар үргэлж гарна. Тодорхой уулын орой, нуруу, худаг, усны голдиролтой, тодорхой координаттай, геодезийн цэгтэй газарт маргаан харьцангуй бага. Тал, хээрт бол хэ цүү дээ. Хоёр улсын геодезийнхон өөр өөр газарт, заримдаа бүр 5-10 метрийн зайтай очоод зогс чихно. Наанаа "Зургийн нарийвчлал таарахгүй байна" гэж буй ч цаанаа бол ганц ам мерт газар боловч улсынхаа талд авчих санаатай байгаа нь мэдээж. Тэгээд л координат буюу газар зүйн солбицлын системээс шалгана. Тэгж байж хоорондын зайгаа ойртуулна, дундаа нийлнэ.

-Хилийн шугамаа хаагуур явуулах вэ гэдэг дээр санал зөрөлдөөд хоорондоо тохиролцохгүй удах, олон удаагийн хэлэлцээ хийх тохиолдол тэр үед нэлээд гарсан гэдэг. Монгол, Хятадын хилийг газар дээр нь тогтоон, тэмдэглэх үед тийм зүйл тохиолдож байв уу?

-Байлгүй яах вэ. Хоорондоо тохиролцохгүй, хэлэлцээ хийгээд, хоёр сар шахам болсон газар ч бий. Хамгийн их эвгүйдсэн нь 1963 онд манай 448 метр төмөр зам Хятадын

хилийн цаана гарчихсан асуудал. Монголын төмөр зам зохих газраар хил гарахгүй байна гэсэн асуудал үүсэж, Хилийн комиссын Монголын хэсгийн ахлагч Б.Цэдэн-Иш гуайн даалгавраар би газар дээр нь багажаар магадлан хэмжихэд Монголын төмөр зам 448 метр газартайгаа Хятадын нутагт орсон байсан. Хилийн гэрээнд хавсаргасан зургаар бол хилийн шугам бүр хагас км-ийн наагуур байгаа юм.

Манай газрын зургийг оросууд анх хийхдээ алдаа гаргаснаас болоод ийм зүйл болсон. Түүн дээр бид 59 хоносон. Хоёр орны хамтар сан комисс хуралдаад ч нэмэргүй, Төв хороо, Засгийн газарт хэлээд ч шийдэж чаддаггүй. Нэгэнт хилийн гэрээнд хавсаргасан газрын зурагт ингээд заачихсан болохоор айлын тал юу гэж хагас км газрыг "Нээрэн танайх юм байна" гэх вэ. Яах аргагүй 448 метр газраа алдах дээрээ тулаад байлаа.

Хилийн гэрээнд "Хилийн шугамыг Халх голын үндсэн урсгалаар, Монгол Улсын хуучин газрын зураг дээрх хар хилээр" гэсэн байдаг юм. Гэтэл тухайн газар ерөнхийдөө цаашаа хазгай, наагуураа гол байхгүй байв. Тэгээд Цэдэн-Иш гуайд "Өмнө нь үүгээр гол урсаж байгаад гол нь байгалийн жамаар голдирлоо өөрчилж, Цагаан арлынхаа цаагуур урсчихсан шиг байна" гэтэл "Үзээд ир" гэсэн. Ингээд нэг цэрэг дагуулан, хоёр хөтөлгөө морьтой Халхын голын адгаас эх хүртэл явлаа. Яг миний бодсоноор гол голдрилоо өөрчлөөд урссан байсан.

Халх голын үндсэн урсгал Харгайт уулын хормойгоор урсаж байгааг үзэж, хилийн гэрээнд хилийн шугамыг хоёр өөр газраар тогтоохоор алдаатай заалт байгааг Хилийн комисст танилцуулснаар хоёр улсын комисс дахин хэлэлцээрт орж, маргаантай газар болон төмөр замынхаа хоёрны нэг буюу 86 га газрыг Монголын талд авсан.

-Газар нутаг, тусгаар тогтнолыг зөвхөн цусаар хамгаалдаг биш, ажлаа мэддэг, сайн мэргэжилтнүүд энх цагт бас хамгаалж байдгийн тод жишээ, сэтгэл хөдөлгөм түүх байна. Таныг 480 гаруй га газрыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулсан гэж сонссон. Бусад тохиолдлуудын тухай ч сонсмоор байна?

-1978 онд Монгол, Оросын хилийн шугамыг газар дээр нь тодосгон тогтоох ажлын хүрээнд Баян-Өлгий, Увс, Хөвсгөл аймгуудын чиглэл дэх хилийн хамтарсан нэгдүгээр салбар комиссын хээрийн ажлыг би хариуцаж байлаа. Хилийн шугамыг газар дээр нь шалгаж яваад Дөрвөд даваа орчимд 2.8 ам км талбайн зургийг буруу зурж, Оросын талд оруулсан байсныг тогтоож энэ газрыг буцааж авсан. Тэнд их олон толгод байдаг. Хилийн гэрээнд "Толгод хоорондох хоёр хөтлийн өндөр хөтлөөр нь Монголын хилийн шугам явна" гэсэн. Гэтэл өндөр хөтлийн наад талын хөтлөөр хилийн шугамыг явуулсан байв. Ингэснээр 2.8 ам км талбай Оросын тал руу орчихож байгаа юм.

Би газар дээр нь ажиллахдаа багажаар хэмжиж, манай хилийн шугам явж буй хөтлөөс Оросын талын хөтөл 1.78 метрээр өндөр байгааг тодорхойлсон. Түүнийгээ Оросын талын мэргэжилтэнүүдэд танилцуулан, хамтарсан хэмжилт хийхэд минийх батлагдсан. Ингээд энэ хэсэгт хилийн шугам өөрчлөгдөж, Монголын талд 230 га газар орохоор байгааг хоёр улсын хамтарсан Хилийн төв комисст мэдэгдсэн. Төв комисс Дөрвөд даваанд ирж хуралдан, хилийн шугамын өөрчлөлт үнэн зөв болохыг протоколоор баталгаажуулснаар энэ газар манай нутагт орсон.

Б.РАГЧАА: Ерөнхийлөгч "Монгол Улсын газар нутаг, тусгаар тогтнолд оруулсан хувь нэмрийг тань үнэлж энэ шагналыг олгож байна" гэсэн

1983 оны хилийн хээрийн ажлын үед Сүхбаатар аймгийн Ар гурван бургастайд бас сүрхий маргалдсан. Хятадын тал хилийн шугам зүүн Могнон уулын орой дээрх хилийн 444 дүгээр тэмдгээс шулуун шугамаар Ар гурван бургастай толгойн оройг дайран, 5.3 км үргэлжилж, хилийн 446 дүгээр тэмдэгт хүрнэ гэсэн. Минийхээр хилийн шугам Ар гурван бургастайн оройгоор биш, Хятадын тал руу хазайж орох ёстой байв. Ингэж маргалдсаар хоёр улсын хилийг шалгах төв комиссоос төлөөлөгч томилон, Могнон уулын оройд уулзаж, газар дээр нь шалгах боллоо.

Хятад талаас комиссын гишүүн Жан Руйлянь тэргүүтэй таван хүн, Монголын таван хүнийг би тэргүүлэн, Могнон уулан дээр хоёр талаасаа уулзав. Ингээд газар дээр нь геодезийн багажаар шалгаж, хилийн шугам толгойн оройгоос урагш (Хятадын тал руу) 61.6м зайд байгааг нотолсон. Ингэснээр Монгол Улс 1.65 га газраа авч үлдсэн.

Ийм газар олон бий. Ямаатын гол, Өмнөговийн Цагааннуур, хойд хил дээрх Дөрөө нуур гээд л үргэлжилнэ. Хилийн гэрээ, зурагт ганц нуур гэчихсэн, очихоор хоёр нуур байдаг. Тэгээд л маргалдана. Мэргэжлийн хүн дутагдалтайгаас зураг буруу, тэгээд хилийн гэрээнд буруу тусгасан байх нь элбэг. 1940, 1958 онд хилийн хэлэлцээрт аймгийн дарга, малчин, худалдаачин оруулж байсан нь мэргэжлийн хүнгүйнх шүү дээ. Ямар сайндаа 1940 онд хилийн гэрээ хийхэд газрын зургийн мэргэжилтэн хэрэгтэй гэхэд Төрийн шагналт, Ардын зураач О.Цэвэгжав гуайг явуулсан байгаа юм. О.Цэвэгжав гуай оччихоод "Энэ чинь миний хийх ажил биш, шугам зургийн ажил байна" гээд буцсан гэж Б.Цэдэн-Иш гуай ярьж байсан.

-Хойд, урд хилээ тогтооход хэцүүхэн маргаан олон удаа гарсан, хоёр хөршдөө багагүй газраа алдсан тухай манайхан ярьдаг. Түүнээс хамгийн их дурдагддаг, жишээ болдог нь Давст уул. Тэгэхэд юу болсныг Та мэдэх үү?

-Давст уулыг Цэдэн-Иш, Рагчаа нар алдсан гэж 1990-ээд онд их бичсэн. Тэр худлаа шүү. 1958 оны хилийн хэлэлцээрт би ороогүй. Давст уул яах аргагүй манай нутагт байсан. Давст уулын ард манай Чацарганын, Тээлийн, Хүрмэн уулын, Хандгайтын харуулын овоонууд бий. 1905 онд хоёр зээр юм долоож байхыг тува хүн хараад очиж үзтэл давс байж. Тэгээд тэд тэндээ хоёр жижиг байшин бариад давс олборлож эхэлсэн байдаг.

1958 онд хилийн хэлэлцээр хийхэд оросууд Давст уулыг авах гэж маргалдсан. Тэгэхэд нь "Ийм юм болоод байна. Энэ талаар мэддэг чаддаг, асуудлыг шийдэх бүрэн эрхтэй хүн ирүүлээч" гэтэл Төв хорооноос эдийн засаг хариуцсан Рэнцэнсэнгэ гэдэг хүнийг явуулсан. Тэрбээр очоод яг газар дээр нь хоёр талын төлөөлөгч байхад "Өө, энэ чинь Тувагийн давсны үйлдвэрийн газар байна шүү дээ" гэж балайрсан байгаа юм. Энэ үг нь протоколд ороод бүх зүйл дууссан гэдэг юм.

Газар алдсан тухайд гэвэл, манайхан хил орчимдоо нутагладаггүй. Хил тогтооход иргэдийнх нь суурьшил, газар нутгаа эзэмшсэн байдал их чухал байдаг. Өвөлжөө бууц, орогнож байсан газар, хадлангийн талбай ч байна уу, ямар нэг ул мөр, ором байвал ямар ч асуудалгүй. Гэрээ, хэлэлцээрийн

үед тэрнээс болоод л хамаг газраа алддаг. Манайхан одоо хилээ сүрхий хамгаалаад буй боловч хил хавираа суурьшиж, нутагладаггүй хэвээрээ. Хойд, урд хөрш бол хүн нутагладаггүй байсан ч банзан саравч, хашаа бариад орхидог. Тэр нь тухайн газрыг эзэмшиж байсан баримт болдог. Ийм явдал нэлээд гарсан. Үүнийг л бодож явах ёстой шүү гэж залуустаа зориуд захиж хэлмээр санагдаад явсан юм, хэлж санаа амарлаа.

Газраа алдсан гэж байгаа асуудлуудын цаана үнэн хэрэгтээ түүхээ мэддэггүй, гэрээ байгуулахдаа хайш яйш хандсан, газрын зургаа өөрсдөө хийдэггүй, оросуудын гарыг хардаг зэрэг шалтгаан байдаг. Гэхдээ Оросыг муу хэлэлтгүй дээ хөөрхий, манай батлан хамгаалахад их юм хийж өгсөн. 1932 оноос эхлээд 600-гаар цэрэгтэй отряд бууж, 1:200 000, 1:1 000 000-ны машстабтай зургаар хангаж, улсын сэт хийж өгсөн. 1956 он хүртэл манайд байр зүйн зураг хэрэг болоход оросууд л хийж өгдөг байлаа. Тэгээд 1958 онд ХАЯ-ны усны аж ахуйн ортяд байгуулснаар манайхан бие дааж ажиллаж эхэлсэн шүү дээ.

-1982-1984 онд Монгол, Хятадын хилийг газар дээр нь анх удаа хамтран шалгах нөр их ажил болсон гэдэг?

-Монгол, Хятадын харилцаа маш муудсан үе шүү дээ. НАХЯ-наас биднийг Хятадын талаас бэлэг сэлт авахыг, тэр ч бүү хэл ганц, хоёроороо явж байгаад хятад хүнтэй ярилцахыг хориглосон байлаа. Хилийн хамтарсан шалгалт хийж байгаа юм чинь хятад хүнтэй уулзах, харилцах хэрэг гарна шүү дээ. Тийм үед заавал гурваас дээш хүн хамт байна. Уулзаад хэрхэн харилцах нь хүртэл дүрэм, журамтай. Манай талаас Цэрэнбат гэдэг залуу юм тэмдэглэх гээд хятад хүнээс 24 төгрөгний үзэг аваад, бэлэг авсан хэргээр арга хэмжээ авхуулж, ажлаасаа халагдсан явдал ч гарсан.

Хятадтай харилцаа хүйтэрснээс болоод манайд Зөвлөлтийн 12 мянган цэрэг ороод ирсэн. Хаа сайгүй орос цэргийн анги байсныг залуу үеийнхэн мэдэхгүй л байх даа. Тийм хүнд үед бид өмнөд хилийн хянан баталгаа хийж, 1:100 000-ны зургаа 1:50 000-ны нарийвчлалтай болгосон. Нэг см-т 500 метр багтдаг болгож нарийсгасан гэсэн үг. Өмнөх геодезийн цэг арван хэдэн метрийн зөрүүтэй гардаг байсан бол түүнийг 1-2 метр болгосон. Хятадууд бол аль хэдийн нарийвчилсан сэт хийчихсэн, түүнийгээ өтгөрүүлж, шинэчлээд, баганаа тодорхойлоод байж байв. Гэтэл манайхан арай хийж л тэр ажлыг хийсэн. Тэгэхэд манай Геодези, зураг зүйн газар байгуулагдаад, хөл дээрээ босчихсон байлаа. Энэ ажилд манай 400-гаад хүн гурван отряд болж оролцсон. Хилийн шугамны дагуу геодезийнхон нижигнэж байв шүү дээ.

-Энэ том ажлыг хийхэд таныг их зориг гаргаж, зүтгэсэн гэдэг юм билээ?

-Харилцаа муудсан үед хоёр улсын хилийг шалгах Монгол, Хятадын төлөөлөгчид Улаанбаатарт уулзсан. Хятадын талынхан манайхыг хилийн дагуух байр зүйн газрын зургаа 1:50 000-ны масштабтай болгох, хоёр улсын хилийн дагуу тус бүр геодезийн өндөр нарийвчлалтай сүлжээ байгуулж, түүгээр хилийн бүх баганыг нэгдсэн солбицлын системтэй болгох санал дэвшүүлсэн. Үүнийг сонсоод Монголын талын хилийн комиссынхон үнэндээ цочирдсон. Энэ ажлыг хийх нь Монголын талд хэрэгтэй боловч ийм нүсэр ажлын ард гарч чадна гэдэгтээ манайхны олонх нь эргэлзсэн.

Би Геодези, зураг зүйн газрын даргаар ажиллаж байлаа. Энэ газрыг

байгуулж, өдий зэрэгт хүргэсний хувьд дээрх ажлыг хийж чадна гэдгээ би мэдэж байсан. Тэгээд энэ ажлыг хийнэ, чадна гэж зоригтой хэлсэн юм. Манай Хилийн комиссынхноос Б.Цэдэн-Иш гуай л намайг дэмжсэн. Харин хэсэг нөхөд чадахгүй гэж, тухайн үед Хилийн комиссын даргаар ажиллаж байсан Г.Нямдоо нарын хүн аль ч талд нь орж чадахгүй, дуугүй байсан.

Ингээд шийдэлд хүрэхгүй байсан тул ЗХУ-ын БХЯ-наас зөвлөгөө авъя гэтэл Төв хороо ч зөвшөөрлөө. Хилийн комиссын дарга Г.Нямдоо, БХЯ-ны хэлтсийн дарга Л.Лувсан, бид гурвыг оросууд хэчнээн сайхан хангамжинд байлгав даа. Тав хоног тааваар минь тарвалзуулчихаад "Албан ёсны хариуг Гадаад явдлын яамаар дамжуулж өгнө" гээд буцаасан. Гэтэл биднийг ирээд ганц хонож байхад ЗХУ-ын БХЯ-наас "Та нар энэ нүсэр ажлыг хийж чадахгүй, хүчрэхгүй. Хойшлуулах нь зүйтэй" гэсэн зөвлөгөөг нууц бичгээр Гадаад явдлын яаманд ирүүлсэн байв. Гэсэн ч би "Чадна" гээд л зүтгээд байсан.

Тэгэхэд дээрээс, дэргэдээс, доороос намайг зэмлэсэн хүн олон. Хилийн комиссын зөвлөхөөр ажиллаж байсан Б.Цэдэн-Иш гуай л "Энэ бол заавал хийх шаардлагатай ажил. Нэгэнт хийж гэмээн нарийвчлалыг ёсоор нь сайжруулаад авсан нь дээр. Одоо харилцаа ийм муу байгаа юм чинь цаашид юу ч болж мэднэ" гэж байлаа.

Дээрээс Лувсангомбо, Дүгэрсүрэн, Моломжамц гуай нар байсхийгээд л биднийг дуудна. Нэлээд юм болсны эцэст Майдар, Лувсан, Цэдэнбал дарга нар хоорондоо ярьсан юм уу даа, Сайд нарын Зөвлөлд "Бүх хангамжийг өг, тэгээд ажлыг нь хийлгэ" гэсэн бололтой юм билээ. Сайд нарын Зөвлөл шийдвэр гаргаж, ЗХУ миний хийсэн ажлыг хянан баталгаажуулах зөвшөөрөл өгснөөр би энэ нөр их ажлыг хариуцаж хийх болсон. Улс ч бас том юм билээ. Манай Геодези, зураг зүйн газар Сайд нарын Зөвлөлийн харьяанд байсан.

Би "Энэ ажлыг хийхийн тулд надад Хятадтай тэнцэх багаж, газрын зураг хэвлэх материалууд хэрэгтэй" гэхэд Англи, Японоос техник хэрэгсэл, цахим тооцоолуур гээд хэрэгтэй бүхнийг авч өгсөн. Одоогийнхоор бол компьютер шүү дээ. Түүнийхээ программыг нь мэдэхгүй, тоо, физикийн бодлого боддог тусгай хүмүүсийг экспедицийн дарга нартай түр ажиллуулж, ажлынхаа тэгштгэн бодолтыг нууцаар хийлгэж байлаа. Хятадтай 1984 онд уулзаж, хийсэн ажлаа тулгасан.

Энэ ажлын төлөө төр намайг үнэлсэн байх гэж би бодож суугаа. Ерөнхийлөгч гар барихдаа "Монгол Улсын газар нутаг, тусгаар тогтнолд оруулсан хувь нэмрийг тань үнэлж энэ шагналыг олгож байгаа юм шүү" гэсэн (хоолой нь зангирав). Би "Баярлалаа" гэхээс өөр үг хэлж чадаагүй.

ГУРВАН УЛСЫН ХИЛИЙН ЗААГ ДАХЬ ОРГИЛД ОРОСУУД ТУСГАЙ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛТЭЙ, ХАРИН БИД ХӨВӨНТЭЙ ХҮРЭМТЭЙ Л ГАРЧИХСАН

- Хөдөлмөрөө үнэлүүлэн шагнуулсан хүн болгон ийм сайхан үг сонсохгүй. Тэгэхээр үнэхээр бахархмаар юм. Та яриандаа Б.Цэдэн-Иш гуайг олон дурдлаа. Алтан хамтрагч байжээ дээ?

-Бид олон жил хамт ажиллаад, сүүлдээ ах, дүү шиг болсон. Энэ улсын хилийг газар дээр нь тогтооход яг гардаж, удирдаж ажилласан хүн бол яах аргагүй Б.Цэдэн-Иш гуай. Харин Хөдөлмөрийн баатар цолоо над шиг эрт авч чадаагүй дээ, хөөрхий минь, 98 бил үү, 99 настайдаа авсан санагдана. Оройтсон ч гэсэн төр, засаг нүдээ

олдог юм байна.

-Та 1989-1990 онд хийсэн БНМАУ, ЗСБНХУ-ын хилийг анх удаа хамтран шалгах Монгол талын комиссын техникийн асуудал хариуцсан орлогч даргаар ажилласан гэсэн. Энэ ажлын үг дүнгийн талаар ярьсангүй?

-Энэ ажлаа бүрэн дуусгаж амжаагүй. Хээрийн ажлаа хийж дөнгөж дуусаад байтал ардчилал гэж үймээд, биднийг халсан. Надаас ажил авч, Салданд өгсөн. Тэд тийм ч сайн ажиллаагүй. Бидний хийж байсан юмыг алдсан. Нарийны голд оросууд эргээ хааж, хамгаалах ажлаа хийгээгүйгээс голдирлоо өөрчилсөн байхад хилийн шугамаа хуучин ховилоор нь явуулаагүй. Увс нуурын цаад хэсэгт хилийн баганыг 100 шахам метр дотогшлуулж, усан дотор зоочихсон. Сэлэнгэд ч бас асуудал бий.

-Та нар тэдгээрийг цэгцлэх гэж байсан юм уу. Таны илрүүлсэн алдааг засаагүй гэсэн үг үү?

-Бид хээрийн ажлыг нь хийсэн ч үр дүнг нь үзэж чадаагүй. Ажил авсан хүмүүс эцсийн байдлаар протокол болгож тохиролцохдоо л тэгээд тогтоочихгүй юу. Бидний хийснээс газрын ч алдагдалтай, усны ч алдагдалтай.

-Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх өндөр оргилуудын өндрийг хэмжиж тодорхойлсон гэсэн. Үүнийг өөрөө санаачилж хийсэн юм уу, дээрээс үүрэг даалгавар өгсөн юм уу?

-Геодезийнхон газар нутаг хэмжээд л явдаг. Уулын спорт гэсэнчийн талаар юу ч мэдэхгүй нөхөр Хилийн комисст ортол хилийн дагуух уулуудын өндрийг тодорхойлох шаардлага гарсан. Ингээд Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх 4000 метрээс дээш өндөртэй 18 уулын өндрийг тодорхойлсон. Улсын хилийн дотор байгаа Их Түргэн 4029, Хархираа 4037, Түргэн (Усан цайлуур) 4048, Цаст уул 4193, Цамбагарав 4165, Мөнххайрхан 4204, Сутай 4090, Отгонтэнгэр 4021, Гаран 4068 метр өндөр. Монгол, Хятадын хилийн шугаман дээр байгаа өндөр уулс гэвэл Тооног 4092, Хүйтэн уул 4374.3, 4073-4371.4 метр өндөртэй дөрвөн нэргүй оргил, Монгол, Оросын хилийн шугам дээрх 4118 мерт өндөртэй нэргүй оргил, Малчин уул 4027 метр өндөртэй, гурван улсын хилийн уулзвар цэг далайн түвшнээс 4104 метр өргөгдсөн гэдгийг би тогтоосон.

Эдгээрээс хилийн доторх Хүйтэн, Мөнххайрхан, Отгонтэнгэр, Түргэн, Сутай, Хархираа, Малчин, Цамбагарав, Цаст зэрэг есөн уулын оргилд хөл тавьсан тул 1984-1985 оны үед уулын спортын мастер цол хүртээд зогсохгүй Уулын спортын холбооны даргаар сонгогдож явлаа шүү дээ. Сая шагнал авсны дараа уулчдын төлөөлөл ирж, баяр хүргээд явсан. Хилийн ажлаар явж байгаад л гарсан болохоос ууланд авирах хоббитойдоо биш л дээ. Гурван улсын хилийн зааг дахь оргилд оросууд тусгай хувцас хэрэгсэлтэй, уулчидтай ирж байхад бид өдөр тутам өмсдөг нимгэн хөвөнтэй хүрэм, ажлын гуталтайгаа, ямар нэг тусгай хэрэгсэлгүй гарчихсан.

-Улсын нутаг дэвсгэрийн талбай, хилийн уртын хэмжээ, дөрвөн талын цэгийг таны тогтоосноор монгол хүн бүр мэддэг гэхээр бахархмаар юм. Монгол Улсын баруун захын цэг Мааньт уулын нэрийг та оноож өгсөн гэл үү?

-Монгол орны баруун цэг Мааньт уулын нэрийг би оноосон юм. Энэ уул нэргүй байсан. Хуучин орос газрын зургийн ноорог дээр уг уулыг Мануту гэсэн байсныг нь Мааньт байж магадгүй гээд өгчихсөн. Энд нэг хэлүүштэй зүйл санаанд орж байна. Манайхан хойд цэгээ Монгол шар даваа

гэж ярьж, бичдэг. Тийм шүлэг ч бий. Гэтэл Монгол шар даваа маань одоо Монголын хилийн гадна байгаа. 1727 онд Орос, Манж хоёр хил тогтоохдоо гэрийн чинээ 58 том овоо босгосон.

"Б.Рагчаа л шийдвэл тэр Монголын талын эцсийн шийд болдог байсан"

Тэгэхэд Тува манай нутагт байлаа. Гэтэл хэзээний манай нутагт байсан Тува 1940-өөд онд туурга тусгаарлаж, манайхан ч хүлээн зөвшөөрч, Элчин сайдаа илгээсэн. Тэр үед долоон овоо нь Тувагийн нутагтай хамт тасарсан. Монгол шар даваа ч тэндхийнх болсон. Харин одоо манай хойд цэг бол Тэнгис даваа. Хойд захын цэг Тэнгис даваа, урд захынх Орвог гашууны Бор толгой, хоорондох зай нь 1259 км.

Баруун захын цэг Мааньт уул, зүүн захынх Модот хамар, хоорондох зай нь 2392 км. Энэ хэмжээг эрдэмтэн Галсан, бид хоёр тогтоосон. Мөн улсын хилийн шугамын урт ЗХУ-тай 3480 км, БНХАУ-тай 4673 км, гурван улсын хилийн баруун уулзварын цэг 4104 тоот өндөрлөг. Зүүн захын уулзварын цэг Тарваган дахын овооны 645 тоот өндөрлөг. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хамгийн өндөрлөг цэг Таванбогд уулын Найрамдал оргил 4374 метр.

Хамгийн нам цэг Хөхнуурын хонхор 560 м, Монгол Улсын нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ 1566.5 ам.км гэх мэтчилэн Монгол орны нутаг дэвсгэрийн захын цэгүүдийн хоорондох зай, оноосон нэр, байршил, солбицол зэргийг тогтоох ажлыг санаачлан, хамт ажиллаж байсан хүмүүстэйгээ судалж, тодорхойлсон. Үүнийг маань Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 149 дүгээр тогтоолоор баталгаажуулсан.

"ЭНЭ БАЙГУУЛЛАГАД ЧИ ӨРТЭЙ" ГЭХЧИЛЭН БААХАН ЗАГНАЖ, ӨРГӨДЛИЙГ МИНЬ УРААД НҮҮР ӨӨД ШИДЧИХСЭН

-Улсын геодези, зураг зүйн газрыг үүсгэн байгуулах ажлыг таныг гардсан гэдэг юм билээ?

-Яалт ч үгүй энэ ажлыг хөөцөлдсөн. ЗХУ-д сургууль төгсөж, 1959 онд ирээд Дорнод аймагт багшаар түр томилогдон, ажилласан юм. Тэгж явахдаа "Монгол Улсад геодези, зураг зүйн салбарын ажил нь тархай бутархай байна. Арван хэдэн газар дур дурандаа өөрийн хэрэгцээнд тааруулан зураг зүйн ажил хийж байна. Цаашид ингэж явж болохгүй. Геодези, зураг зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхийн тулд эднийг нэгтгэсэн газар байгуулж, бүх нутаг дэвсгэрээ газрын зурагжуулах ажил хийх хэрэгтэй" гэсэн саналаа бичиж, 1961 онд Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалд танилцуулсан.

Тэгэхэд дарга "Зөв зүйтэй санал байна. 2-3 жил сайн судалж, боловсруулаад оруулж ир" гэсэн хариу өгсөн юм. 1964 онд урд хилийн ажлаа дуусгаад, геодези, зураг зүйн асуудал хариуцсан газар байгуулах саналаа дахин бичиж, гурав хувилан Майдар, Лувсан, Жагварал гуай нарт өгсөн. Нэг өдөр Майдар гуай дуудаж байна. Тийм том хүнтэй анх удаа уулзсан нь тэр. Өрөөнд нь ороод суутал өвдөг минь чичрээд байж билээ. Майдар гуай түүнийг анзаарчихаад "Тайвшир. Би чамайг яах ч үгүй" гэсэн. Ширээн дээр нь өөрөө иддэг бололтой ааруул, өрөм тавьчихсан, энгийн хүн байлаа.

Тэрбээр "Чи зөв санал тавьсан байна. Хоёулаа хамтраад нэг газар байгуулъя. Энэ улс ингэж задгай байж болохгүй" гэсэн. Би ч овоо тайвшраад, тавган дахь ааруулаас амсахтайгаа боллоо. Миний бичсэн юмыг надаас асуугаад, би хариулаад л байлаа. Тэгээд "Үүнийг сайн хийх хэрэгтэй. Барилга, эдийн засгийн улсын хорооны дарга нь би, орлогч нь Мотоо гэдэг

хүн бий. Мотоотой уулзаад, эцсийн байдлаар боловсруулаад ир" гэж байна. Тэнд нь очоод яг хэдэн орон тоотой, ямар газар байгуулахаа тодруулах гэж бөөн юм болов. Бүх газрын зураг зүйн мэргэжилтнүүдийг цуглуулж, тооллоо. Ингэж боловсруулсан саналаа Мотоотой тохиролцоод Майдар гуайд өглөө. Сайд нарын Зөвлөлөөр оруултал яамдын сайд нар орлогчтойгоо нийлээд бидний саналыг бут ниргэдэг юм байна. Моломжамц, Рагчаа, Пэлжээ, Гунгаадорж, Жамц гуай нар бүгд л эсэргүүцлээ.

Үдээс өмнөжин хуралдаад олигтой шийд гарах янзгүй болов. Үдээс хойш үргэлжлүүлэн хуралдаж, дахиад баахан маргав. Тэгтэл Лувсан гуай "Энэ асуудлыг Сайд нарын Зөвлөлийн гишүүд шийднэ. Та нар гарч бай" гэлээ. Тэгтэл Улсын геодези, зураг зүйн орон тооны бус зөвлөл гээч юм байгуулаад, намайг нэг гишүүнээр нь оруулчихаж. Тэнд нь яам тус бүрээс нэг хүн оруулсан, орон тооны бус есөн гишүүнтэй. ХААЯ-наас Жамц, ШУА-иас Бадамжав гуай ч гэх шиг. Геодезиэс, зураг зүйгээс, агаараас зураг авдаг гээд нэг нэг хүнийг орон тооны мэргэжилтнээр авсан байгаа юм.

Улсын геодези, зураг зүйн орон тооны бус зөвлөлийн даргаар М.Пэлжээ сайд ажиллах боллоо. Гэтэл М.Пэлжээ гуай намайг зөвлөлдөө авна гээд болдоггүй. Би тэгэхэд УААЯ-ны Усны хайгуул судалгаа, зураг төсөл, эрдэм шинжилгээний институтийн ерөнхий инженерээр ажиллаж байв. Жил хагасын хугацаанд хэд хэдэн удаа дуудахаар нь мэргэжилд ойр газар ажиллавал зүгээр ч юм уу гэж бодоод өргөдлөө бариад УААЯ-ны Дэмбэрэл сайдтай уулзлаа. Өргөдлөө өгтөл намайг зодчих шахсан. "Чи хэний хөрөнгөөр сурсан гэж бодож байна. Энэ байгууллагад чи эцсээ хүртэл ажиллах өртэй" гэхчилэн баахан загнаад, өргөдлийг минь ураад нүүр өөд шидчихдэг юм байна.

Орлогч сайд Чогдон, институтийн дарга Барс гуай нарт өмнө нь хэлээд, сайд зөвшөөрвөл бид татгалзах зүйлгүй гэдэг үгийг нь сонсчихсон байсан юм. Ингээд сайдын өрөөнөөс гарсны дараа учир байдлаа Чогдон багшид хэлэхэд "Энэ асуудлыг ТЭЗ-өөр хэлэлцүүлье. Дахиад өргөдөл бичээд ир. Мэргэжлийнхээ дагуу ажиллая гэж байгаа чиний зөв. Тэнд очоод чи их ажилтай, ядрах л байх. Цалин энд 850 төгрөг бол тэнд ихээр бодоход л 750 шүү дээ. Үүнийгээ бодсон уу" гэв. "Би усны чиглэлийн хүн биш, мэргэжлийнхээ газарт л ажиллая гэж бодож байна" гэлээ. Ингээд дахин өргөдлөө өгч, арай гэж чөлөөлөгдсөн.

Улсын геодези, зураг зүйн зөвлөлдөө 1968 онд очсон. Гэтэл надад 700 төгрөгийн цалин өгдөг байна шүү. Би цалин мөнгөний тухай огт яриагүй, "Үүсгэж хөөцөлдсөн ажлынхаа эцсийг үз. Геодези, зураг зүйн алба байгуул" гэхээр нь л яваад очсон юм. Уг нь ч цалин нэг их чухал санагдахгүй байсан л даа. Гэвч олон нялх нойтон хүүхэдтэй болохоор амьдралын эрхээр нэг өдөр сайдад "Би 700 төгрөгийн цалин авч байгаа шүү дээ" гэтэл М.Пэлжээ гуай инээгээд "Би чиний цалинг ойрын хэдэн сардаа багтаагаад 750 болгоно. Үүнээс цааш чадахгүй. Чи энд ирснийх, Геодези, зураг зүйн газраа л байгуул, би дэмжинэ" гэсэн.

Ингээд хоёр жил зүтгэж байж, 10 гаруй яам, тусгай газрын харьяанд, хоорондоо уялдаагүй, нэгдсэн системгүй, зөвхөн өөрсдийн хэрэгцээг хангадаг геодези, газрын зургийн байгууллагаас ТЭХҮГЯ-ны улсын геодези, картографийн зөвлөл, мөн яамны топо зургийн анги, ХААЯ-ны агаарын зургийн экспедиц, ББМҮЯ-ны газрын зургийн товчоог нэгтгэн,

Сайд нарын Зөвлөлийн 1970 оны 232 дугаар тогтоолоор ББМҮЯ-ны сайд О.Телеханы шууд удирдлагад Улсын геодези, зураг зүйн газрыг 105 хүн, 16 автомашин, хоёр сая төгрөгийн үйлдвэрлэлийн ажилтайгаар байгуулсан.

-Бүтэн арван жил хөөцөлдөж байж байгуулжээ?

-Тэгсэн шүү. Арван жил хөөцөлдөж байгуулсан газрынхаа даргаар 20 жил ажиллаж, хөл дээр нь бат зогсоосон. Улсын геодези, зураг зүйн газрыг байгуулаад О.Телехан сайд "Майдар чамайг даргаар тавь гэсэн" гээд намайг дарга болгосон. 1970-1990 онд Улсын геодези зураг зүйн даргаар ажиллахдаа тус байгууллагыг 28 сая төгрөгийн геодези, газрын зургийн бүх төрлийн үйлдвэрлэлийн ажлыг аж ахуйн тооцоон дээр хийдэг, 26 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, хоёр хэлтэс, дөрвөн товчоотой, агаар мандал сансраас авсан газрын гадаргуун зураглалаар бүх масштабын байр зүйн зураг зохиох, нийтийн болон сургалтын хэрэгцээний байр зүйн газрын зураг, сэдэвчилсэн газрын зураг, атлас зохиож хэвлэх хоёр үйлдвэр, улсын геокартын фонд, АН-30 онгоц, 132 автомашин бүхий авто баазтай болсон.

Ховд, Баян-Өлгий, Хөвсгөл, Дорнод аймагт, аймаг дундын Геодези, зураг зүйн байнгын экспедиц, орон тооны 765 инженер, техникийн ажилтан, албан хаагчтай болтол бэхжүүлж, улсынхаа бүх нутаг дэвсгэрийг газрын зургаар зурагжуулан, геологи, ус, газар, ой, зам, барилга, шинжлэх ухаан, батлан хамгаалах салбаруудын эрэл хайгуул судалгаа, шинжилгээний зураг төслийн хэрэгцээг бүрэн хангадаг байгууллага хүлээлгэж өгсөн дөө.

-Ардчиллын дүйвээнээр ажлаа өгсөн тухай дээр дурдсан. Ид хийж бүтээх насандаа явсан хүн ажлаа өгөх тийм ч сайхан биш байсан болов уу?

-Улс ажлаа авъя гэж байхад өгөлгүй яах вэ. Дандаа ажил гэж явсан хүн гэнэт ажилгүй болох яаж сайхан байх вэ. 1990-1991 онд НАХЯ-ны Хил хамгаалах газрын Хилийн түүхийн секторт мэргэжилтнээр ажилласан. Энэ үедээ улсын хилийн газрын зургуудыг цэгцлэх, Цэдэн-Иш гуайн номын ажилд туслах, улсын хил, аймаг, хязгаар, харуулын нутгийн хилийн түүхэн газрын зургийн альбомыг Цэдэн-Иш, Ламзав гуай нартай хамтран зохиох гээд хэрэндээ их ажил амжуулсан.

Тэндээсээ гараад малчин болох гэж үзсэн. Хоёр үнээ, цөөхөн богтой хотын захад гарсан. Чингэлтэйн ууланд хонь хариулж явтал ХААИС-иас "Багшилж өгөөч" гэсэн урилга ирдэг юм байна. Тэнд 12 жил ажиллахдаа Газар зохион байгуулалт, Газрын кадастрын тэнхмийг байгуулж, сургалтын материаллаг баазаар бэхжүүлэн, бие даалгаж өгсөн. Өөрөө ч доктор, профессор цол хүртлээ. Үгүй нээрэн, амьдрал баян гэж үнэхээр үнэн үг шүү.

-Малчин болох гэж байснаа одоо мод үржүүлэгч, ногоочны ажилд урваад байгаа юм аа даа?

-Малаа хүргэнийндээ өгчихсөн. Тэгэхдээ "Жилд идэшний шүдлэн юм уу, хязаалан үхэр, нэг ууцны хонь, нэг идэшний хонь авна" гэсэн болзолтой. Угаасаа зүгээр сууж сураагүй хүн өтөлсөн ч хөдлөхгүй байна гэж үгүй юм. Хүүхдүүдээ өөрсдийн тарьсан жимс, ногоогоор хооллодог болгочих юм сан гээд л энд (СХД-ийн 335 дугаар гарам буюу Ногоонтолгой) үзэж тараад байна. Арваад төрлийн мод сөөг, жимсний бут, хүнсний ногоо тарьсан. Газраа хүүхдүүддээ хэсэг, хэсгээр нь хувааж өгөөд, өөрсдөө тарих юмаа тарь гэсэн. Зарим нь ажил төрөлтэй гээд ирэхгүй юм. Зарим нь ганц нэг

мөчир авчирч суулгасан нь ургасангүй. Харин би бүх модоо үрээр тарьсан. Маш сайн ургаж байгаа шүү. Би нүүрс түлэх дургүй учраас зундаа аргал түүж, өвлийнхөө түлшийг базаадаг.

Тэднийх элсэн чихэр, жимсний чанамал, молоко, гурил, будаа зэрэг цөөхөн төрлийн хүнсний бүтээгдэхүүн л дэлгүүрээс худалдаж авдаг бөгөөд бусад бүх хүнсээ өөрөө бэлтгэдэг гэнэ. Хүүхдүүдээ ч амьдралын ийм хэвшилд сургахыг хүсэж, газрыг нь бэлдэж өгөөд буй аж.

-Таны энгэрт Төрийн дээд одон, медаль бараг бүгд байна. Энгэртээ зүүгээгүй шагналууд бас бий юү?

-Хөдөлмөрийн хүндэт медалийг 1968 онд, Алтангадас одонг 1976 онд, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонг 1981 онд хүртсэн. 2008 онд Гавьяат барилгачин болсон. Гадаад, дотоодын найман салбарын тэргүүний ажилтан гэсэн цол бий. Удахгүй ес дэх нь ирэх бололтой. Хөдөлмөрийн баатар болсны дараа уулсын спортынхон ирж баяр хүргээд, салбарын тэргүүний ажилтан болгоно гээд анкет аваад явсан (инээв). Шагналд дуртай өвгөн байна уу. Би шагнал авъя гэж хөөцөлдөж явсан удаагүй. Харин хүн таныг шагная гэвэл авчихаад л сууж байна даа.

Монгол, Хятадын дипломат арга хэмжээнд 40 гаруй жил орчуулга хийсэн, алдарт дуун хөрвүүлэгч Д.Алмаас номондоо "Б.Рагчаа л шийдвэл тэр Монголын талын эцсийн шийд болдог байсан" хэмээн дурдсан, Монгол Улсын дархан хилийг тогтооход ухамсарт амьдралаа зориулсан Хөдөлмөрийн баатар Б.Цэдэн-Иш агсан дуртгалдаа аавынх нь талаар "Хойд хил тогтооход ЗХУ-ын талаас газар авсан гэж буруудаж, арга хэмжээ авхуулсан удаатай" хэмээн дурссан талаар Б.Рагчаа гуайн хүү хуучилсан. Харин шинэхэн Хөдөлмөрийн баатар өөрийнхөө талаарх иймэрхүү зүйлсийг ярих дургүй даруухан нэгэн аж.

МАНЖИЙН ДАРЛАЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГЧ ,ЗҮҮНГАРЫН ХААН, ХОЙДЫН НОЁН ГАЛСАНДАНЗАНГИЙН АМАРСАНААГ ГУРВАНТАА ОРШУУЛСАН ТҮҮХИЙГ ТОДОТГОХУЙД

Цагааны Ганболд
Доктор , профессор

Өнөөгийн Буриад Улсын нутаг дэвсгэрт Монголчуудын түүхтэй холбоотой газар нутаг , дурсгалт газрууд олон байх бөгөөд заримаас нь товчхон дурьдвал: Хиагт хотноо орших МАХН-ын анх дугаар их хурал хуралдсан байшинг , тухайн үеийн бүхий л тавилга хэрэгсэлтэй нь хадгалсан музей, жанжин Д.Сүхбаатарын 1921-1922 онд нуугдаж байсан байшин, мөн дурсгалын хөшөө , Манж чин улсын үед босгож байсан хилийн түүхэн овоо , Кабанск раойнд Байгаль нуурын эрэг дэх Посолье тосгонд орших Монголчуудтай холбогдох элчүүдийн дурсгалд зориулсан хөшөө , Галуут нуурийн эрэгт орших 1741 онд монгол лам Хатигин Лувсан Жамбаа Лхалдаевын байгуулсан Тамчийн дацан , Буриадын үндэсний түүхийн музейд байх Занабазар гэгээний бүтээсэн Цагаан дарь эх бурхан, Монгол Улсын баатар Гэлэгбаатар, Монгол Улсын хөдөлмөрийн баатар , генарал Б.Цэдэн-

Иш, зохиолч Ринчин Бямбаа, Сэнгийн Эрдэнэ нарын төрсөн газар гэвд л хөвөрч өгнө .

Миний гол дэвшүүлэн тавьж буй асуудал бол Г.Амарсанаа баатрын оршуулсан газрыг нарийвчлан тогтоох, тэнд дурсгалын хөшөө босгох асуудал болой.

Г.Амарсанаагийн талаар Оросын эрдэмтэн В.Владимирцев, В.С.Кузнецов, И.Я.Златкин, П.А.Словцев, Н.Я.Бичурин, Ш.Б.Чимитдоржиев болон Монголын эрдэмтэн Н.Ишжамц, Л.Энхбаяр нар судлан олон бүтээл туурвисан байдаг.

2018 онд "Жангар туулийн жимээр" гэдэг нэвтрүүлэг гарч , манай судлаачид судалгааныхаа ажлын явц, явсан газар орныхоо талаар танилцуулахын зэрэгцээ Семиплатинскаар орохдоо Амарсанаа баатарын шарилыг хайна гэх утгатай зүйлийг ярьсанд нь гайхаж, өөрт байгаа мэдээллээ хуваалцахыг, сохор эрэлд хатаахгүй байхыг хүссэнд оршино.

1757 оны 07 дугаар сарын 28 –нд Г.Амарсанаа Оросын хил даван орогнол гуйж өнөөгийн Казакстан Улсын нутаг дэвсгэрт орших Семипалатинск хот оржээ. Энд байхдаа цэцэг өвчний шинж тэмдэг илэрсэн тул эмнэлгийн тусламж үзүүлэн Тобольск хот руу явуулсан бөгөөд Тобольск хотод 1757 оны 08 дугаар 20-ны өдөр ирээд 1757 оны 09 дүгээр сарын 21 –нд нас баржээ.

Нас барснаас нь хойш Г.Амарсанаагийн шарил Хаант Орос Улс, Манж Чин Улс хоорондын харилцаанд ээдрээтэй байдлыг бий болгож эхэлсэн байдаг.

Сибирийн нэрт түүхч П.А.Словцев "Манжийн засгийн газрыг тайвшруулахын тулд Сибирийн губернатораас хятадын комиссаруудад Амарсанаагийн шарилыг хэд хэдэн удаа үзүүлжээ."[1] гэжээ.

Х.Трусевич 1882 онд бичсэн " Орос-Хятадын дипломат ба худалдааны харилцаа /19 дүгээр зуун хүртэл/ " бүтээлдээ " 1758 онд Селенгийскд хятадууд Амарсанаагийн шарил мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөнч , эхнэр , хүүхэд , хамт зугтаасан албатууд болон шарилыг буцаан өгөхийг шаардсан бөгөөд Оросын тал, Амарсанаагийн шарилыг дорожилно, хилийн дагуу доромж тайлбартайгаар шонд өлгөж, энэ талаар Оросын хааны бүх нутаг дэвсгэрээр тараах болуузай гэдгээс үүдэн өгөөгүй"[2] гэжээ.

Мөн И.Я.Златкин " Манж Чин улсын цэргийнхэн Амарсанаагийн шарилыг зогсолтгүй хайж байсан бөгөөд Иртыш мөрөнд живж үхсэн[3] гэсэн мэдээллийг аваад , урсгал дагуу салаар хөвөн голын ёроолыг шүүрдэж хайсан байдаг.

Амарсанааг Оросын тал саатуулсан , хамгаалалтанд байгаа, цэцэг өвчний улмаас нас барсан гэх Оросын талын албан ёсны мэдээг аваад, Манжийн тал шарилыг шилжүүлж өгөх шаардлага тавьжээ.

Хаант Оросын Засгийн газар 1757 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр Сибирын губернаторт Амарсанаагийн шарилыг Хиагт руу , хил руу илгээж , Чин Улсын төлөөлөгчдыг урин , шарилыг таниулахыг , нас барсаныг нь баталгаажуулах даалгавар өгсөн байна.

1758 оны 02 дугаар сарын 18 –нд Чин Улсын тал Хаант Оросын талд захидал илгээж , шарилыг өгөх

[1] Словцев .П.А.Историческое обозрение Сибири. СПб.,1882.Кн.2.

[2] Трусевич .Х.Посольские и торговые сношение России с Китаем..С.52-56

[3] Златкин .И.Я.Русские архивные материалы об Амарсане...-С.309-313.

өөрсдийн шаардлагыг дахин нотолсон байдаг.

1758 оны 03 дугаар сарын 13-нд Хиагтад Манжийн төлөөлөгчид ирж шарилыг таниулах ажиллагаанд оролцож баталсан хэдий ч үүнд сэтгэл ханалгүй,1758 оны 03 дугаар сарын 28-ны өдөр дахин захидал илгээж , " Манай бүх иргэд , энэ хорт могойн хүүрийг харж , үхсэн гэдэгт итгэхийг хүсэж байна " гэж бичсэн байдаг. Оросын талын шарилыг өгөхийг татгалзсан хариу хоёр талын харилцааг дахин хурцатгав.

1757-1759 оны хооронд Петербург- Бээжин хоёрын хооронд харилцсан , солилцсон бүх захидал зөвхөн "Амарсанаагийн шарилыг болон Орост зугтан гарсан ойрадын босогчдыг буцаан өгөх, буцаан өгөхгүйд зориулагдсан байна ". Ийм байдлаар , Оросын сенат , Манжийн засгийн газрын бүдүүлэг шаардлагыг няцаан 1757 оны 11 дүгээр сарын 01-нд Сибирийн Губернатор Саймоновт Амарсанаагийн шарилыг хил рүү таниулахаар явуулахыг зөвшөөрсөн байна.

1757 оны 12 дугаар 17 –ны өдөр Амарсанаагийн шарилыг түрүүч Глазов дагалдан Селенгийскт комендат В.В.Якобид хүргэж иржээ.

Шарилыг энд оршуулсан хэдий ч хоёрдугаар хөндөн Манжийн үл итгэгч , хартай ноёдуудад таниулах ажиллагааг хийжээ. Бодит баримтаар бол, эхний удаад Монголын түшмэдүүдэд , хоёр дахийг Манжийн ноёдуудад үзүүлэхээр хөнджээ.Манж нар түүнийг сайн мэдэх засаг Лимпилдорж ноёныг явуулахад тэрбээр замдаа нас барсан тул чин ван Чиваг-Яримпилийг манж сайд Сэдийн хамт очиж үзүүлсэнд " Амарсанаагийн



ясыг байцаан үзвээс арьс мах бүхэл,огт хувилсан газаргүй.Тийм бөгөөд бие нүүр хэвээр адил танигдмуй[6]" гэж айлтгажээ.

Доктор Л.Энхбаатар энэ ажиллагааг Монгол Улсын анагаах ухаан , шүүх эмнэлгийн түүхэн дэх анхны шарил таниулах ажиллагаа / эксгуамаци / байсан гэсэнтэй санал нийлэхийн зэрэгцээ Монгол Улсын магадлан шинжлэхүй /криминалистика / болон хилийн төлөөлөгчийн ажиллагаан дах анхны тохиолдол гэж нэмж хэлэх байна.

Архивын эх сурвалжид тулгуурлан бичсэн И.Я.Златкин, Н.Ишжамц,.Б.Чимитдоржиев нарын болон бусад судалгааны материалууд , орон нутгийн иргэдийн ам дамжин хадгалагдсан мэдээлэл зэрэгт дүгнэлт хийхэд, Г.Амарсанаагийн шарил Селенгийскийн шивээ буюу өнөөгийн Селенгийск раойны Новоселенгийск тосгоны хуучин оршуулгын газар оршуулсан болох нь тодорхой бөгөөд харин яг энд гэдгийг тодорхойлох нь хүндрэлтэй бөгөөд боломжгүй юм.

Монгол - Оросын найрамдал, нөхөрлөлийн тод гэрч болсон, тухайн ээдрээтэй нөхцөлд энэ их хүний шарилыг гутаан доромжлох боломж олгоогүйд одоо ч бид талархах учиртай.

Г.Амарсанаагийн шарил энд байдаг болон хамтран дурсгалын

самбар, хөшөө босгох асуудлыг Буриад Улсын Селенгийск раойны тэргүүн Гармаев Станислав Дашиевич анх санал болгосныг онцлон тэмдэглэх нь шударга ёсонд нийцнэ. 2018 оны 05 дугаар сард Уулын Алтайгаас олдон тэнд хадгалагдан шүтэгдэж байсан Г.Амарсанаа хааны тугны сүлдийг Хуучин Селенгийскт орших Г.Амарсанаа хааны нутаглуулсан газарт тахих , сүнсийг нь амарлиулах төр , шашны хүндтэй ёслолыг Буриад Улсын Селенгийск раойны тэргүүн С.Д.Гармаев, түүний тамгын газар , Гусиноозёрск хотын дарга , тус раойны казак цэргийн атаман, цэргүүд болон Уулын Алтайн Улсын Бурхан шашны "Ак Бурхан" төв , "Ак Бурхан" төвийн тэргүүн Өвөр Байгалийн хязгаарын Агийн дацангийн зурхайч лам Арам Кыпчаков болон Халимаг , Тува ,Уулын Алтай, Буриад Улсын буддын шашны лам нар, БУ-ын Улаан-Үүд хотод суугаа Монгол Улсын Ерөнхий Консулын газрын Ерөнхий консул Д.Чадраабал , дэд консул Ц.Ганболд , Галдан бошигт төвийн тэргүүн Н.Батболд , "Өөлдийн хийморь" ТББ-ын тэргүүн Б.Бат - Амгалан болон Ойрад түмний төлөөлөл болсон 10 гаруй иргэд Монгол Улсаас оролцон хамтран зохион байгуулсан юм.

Энэ арга хэмжээ нь Г.Амарсанаа хаанд анх удаа хүнлэг ёсны хүндэтгэл үзүүлэх , олон дахин хөндөгдсөн сүнс , сүлдийг нь амарлиулах , алдар гавьяаг нь мөнхжүүлэх гэсэн анхны алхам болсон бөгөөд энэ их хүний дурсгалыг мөнхжүүлэх дараа дараагийн томоохон арга хэмжээг зохион байгуулах сэдэл өгч буйг мэргэн уншигчид болгооно биз дээ .

Миний эрхэм анд , Сэлэнгийн хилийн хэсгийн Монгол Улсын Хилийн бүрэн эрхт төлөөлөгчөөр олон жил ажилласан , хурандаа Л.Батсүх , Гусиноозёр орчимд Монголын нэгэн баатрын шарил байдаг гэсэн яриа явдаг ба энд ажиллаж байгаагийн хувьд тодруулахыг чармайгаарай гэсэн хүндэт даалгавар , үүргийг нөхөр ёсоор биелүүлсэндээ баяртай байгаагаа дашрамд илтгэж байна .

Ашигласан бүтээлийн жагсаалт :

1. Словцев .П.А. Историческое обозрение Сибири. СПб.,1882.Кн.2.

2. Трусевич .Х. Посольские и торговые сношение России с Китаем..С.52-56

3. Златкин .И.Я. Русские архивные материалы об Амарсане...- С.309-313.

4. А.С.Гатапов. Монгольская историческая энциклопедия . 2016. С. 27

5. Э.В.Демин. "Золотая россыпь" Селенгинска -2- 2010. С.81-89

6. С.Чулуун.Монголчууд XVII-XX зууны эхэн үе,зураг түүх .УБ. Монсудар.2014.Х.198.

АСУУДАЛ ДЭВШҮҮЛСЭН ӨГҮҮЛЭЛ

ХИЛЧИН ЭРС, ХҮЛЭГ МОРЬ ХОЁР ХҮЙН ХОЛБООТОЙ

Цагааны Ганболд
Доктор, профессор

Хил, хилчдийг хүлэг морьгүйгээр төсөөлөхийн аргагүй гэдэгтэй маргах монгол хүн байхгүй биз ээ.

Багш хүний бахархал нь сайн сайхан хөдөлмөрлөж, амьдарч яваа шавь нар нь байдаг билээ.

Хилээ ч хамгаалан манасан, хүлэг морио ч хайрлан дээдэлж яваа нэгэн шавийнхаа талаар бичиж байгаа минь энэ болой.

Энэ эрхэмийг Монгол Улсын Тод манлай уяач Дайдийхүүгийн Баяраа гэх бөгөөд Завхан аймгийн Дөрвөлжин сумын уугуул, Хилийн цэргийн дээд сургуулийг 2001 онд төгссөн, Хилийн 0218 дугаар ангид шалгагчаар ажиллаж байсан бэлтгэл дэслэгч, 1999 онд сонсогч ахуйдаа Увс, Завханы чиглэлд явуулсан хилийн операцид оролцон,улсын хил хамгаалалтанд гаргасан амжилтаараа“ Онц хилчин “ цол, тэмдгээр шагнагдаж байсан хилчин юм .

Хүүхэд ахуй цагаасаа хүлгийн зоон дээр дарцаглаж, эцгийн уясан хурдны морьдыг сум, баг,бригад, овооны наадамд унан хурдалж, дааганд хүнддэх үеэсээ эцгээ бараадан уяачийн хүнд хэцүү хөдөлмөрийг нь хөнгөвчлөхөд өөрийн хэрээр туслахын зэрэгцээ унаган хүлгүүдээ уях ,сойх нарийн эрдэмд дагалдан суралцжээ.

Хүлэг морьтой ойр нөхөрлөж, хүлгийн тоосонд дарагдаж явсан он жилүүд дардан, шулуун байгаагүй, амжилт, ололт, алдаа, харуусал ээлжилж байсан бөгөөд алдаагаа сургамж болгон хатуужиж, амжилтандаа хөлчүүрч яваагүйн хариу сайхнаар тусдагийн буянг одоо эдэлж явна.

Монголчуудын хэлдгээр ”Дөч хүрсэн эр, дөрвөө дарсан ат” гэдэг шиг амьдрал, ажлын хат суун чухам л өөрөө Монгол морин уралдааны оргилд хүрэхийн зэрэгцээ өрөөлийг, бусдыг өөд нь татах үе иржээ.

Баг,бригад,овоо,сумын наадмын уралдааны зурвас хатуудаа хатуу,зөөлөндөө зөөлөн байсаар , туршлага,дадлага хуримтлагдсаар Монгол төрийн наадмын дэвжээнээс болон Монголын Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрээр зохион байгуулагддаг улс, бүсийн чанартай наадам , уралдаанаас 21 айраг, түрүү авсан бахархам амжилтыг үзүүлээд байна.

Жилээс жилд дэгжин дэвшиж өөдлөн дээшилж байгаа нөр их хөдөлмөр шингэсэн амжилтаараа, морины соёлыг хөгжүүлсэн хувь нэмрээрээ 2014 онд Монгол Улсын Алдарт уяач, 2016 онд Монгол Улсын Манлай уяач, 2019 онд Монгол Улсын Тод манлай уяач цолоор тус тус шагнагдсан.

Адуун сүргийнхээ хурдан удам угшлыг сайжруулах үржил сонголтын ажлыг мэргэжлийн хүмүүсийн туслалцаатай ,шинжлэх ухааны үндэслэлтэй явуулахын зэрэгцээ нөгөө алдарт Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас “Махны чиглэлийн ашиг шимт адуун сүргийг бий болгох нь” төсөл бичиж зээл аван уг ажлыг шат дараатай хэрэгжүүлсэн нь үр

дүнд хүрч хамгийн сайн хэрэгжиж буй төслөөр шалгараад байгаа нэгэн сайхан амжилтын эзэн болоод байна .

Эрхэлж буй ажил үйлс амжилттай байхын зэрэгцээ "хурдан хүлэгтэй, хувь заяатай хүнийг хур бороо дагадаг "-ийн адилаар хурдан морины Тод манлай уяач цолоо ,хүн ёсны хоёр ихэр үрийн эцэг алдраар нэмээд байна .

Хилийн цэрэг гэдэг хийморьтой эрчүүд,хүлэг морьд цугларсан их айлаас адууны соёлыг хөгжүүлэх үйлст шимтэн , ярианы хэлний "моринд орох" гэдэг албанд зүтгэн алба хааж буй сум, аймаг төдийгүй төрийн наадамд торгон жолоо өргүүлсэн хурандаа Г.Цогмандал, Д.Батцэнгэл, Ганбилэг, М.Нэргүйбаатар, дэд хурандаа Л.Амарсанаа гэзд олон хилчин уяачид бий . Отряд,заставын хэмжээний олон өсөх ирээдүйтэй уяач –хилчдийг энэ удаад дурьдсангүй.

.Өөрөө морь малгүй ч хилчин нөхдийн уясан морьд уралдах ,тэр тусмаа айраг түрүү авах, дээгүүр давхихыг харж баясах, хилийн цэргээр овоглуулан цоллуулж байхыг сонсох ч бас л урамтай шүү.

Хилчдын давуу бол Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэрт тархан байрласан олон түмэн адуун сүрэгтэй ,сонголт,шилэлт хийх, өсгөн үржүүлэх өргөн боломжтой, билчээр,усны гачаал багатай, Галшар, Говь шанх, Тэс, Дархадын цагаан гэзд удам угшил сайтай цөм сүргийн эзэн байдагт , өндөр үнэ өртөг шаардахгүй өөрийн удамт сүрэгтэйд,мал аж ахуйн чиглэлийн мэргэжлийн албад, бэлтгэгдсэн боловсон хүчинтэйд оршино.Гагцхүү уяачийн эрдэм, морь таних билгийн нүд,идэвх санаачлага л мэднэ.

"Хилчин" спорт хороо маань сонгодог спортыг хөгжүүлэн дэлхийн чансааны олон алдартнуудыг төрүүлсний зэрэгцээ Монголын уламжлалт спорт наадам болох үндэсний бөх,сур харваа ,шагайн харваа, хурдан морь уралдуулах үндэсний спортод ч амжилттай байгаач шагай,хурдан морины тал дээр арай л дутуу анхаарч байна уу гэж ойлгогддог.

Энэ шалтгааныг мэргэшсэн уяач – дасгалжуулагч, зааж чиглүүлчих чадвартай хүн байхгүй байгаатай холбон тайлбарлаж болох юм .

Хилийн цэргээс төрсөн Тод манлай уяач алдартнаа уяач - дасгалжуулагчаар аван ажиллуулж, тэр их хуримтлуулсан мэдлэг, туршлагыг нь ашиглаач, олон хилчин уяачдаа дагалдуулан сургаасай, "Хилчин" угшлын хурдны цөм адуун сүрэгтэй болоосой, үүлдэр угсааг нь сайжруулаасай, өргөн наадмын дэнж дээр өрсөлдөөсэй гэдгийг энэ ялдамд хэлэх гэсэн юм.

Монгол Улсын Тод манлай уяач , Монгол Улсын "Онц хилчин" эрхэм бэлтгэл дэслэгч Дайдийхүүгийн Баяраа энэ саналыг дэмжин хүлээн авна гэдэгт итгэж байгаа .

Одоо яг л "Өөрөө алдрын оргилд хүрсэн бол өрөөлийг оргил өөд чиглүүлэх ариун үүрэг хүлээх, ачаа даах" цаг чинь,үе чинь ч иржээ, Шавь минь.







ГАДААД ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

ХЯТАД, ТАЖИКСТАНЫ ХООРОНД ҮҮССЭН АСУУДЛЫГ СОНИРХОЖ ҮЗВЭЛ

Т. Баяр-Эрдэнэ

ShareTweetShareЗөвлөлтийн 15 бүгд найрамдах улсын нэг болж, ингэснээр Иран, Афганистанаас өөр нэгэн перс хэлт үндэстэн улс болсноор түүх үргэлжилжээ

Өнөөгийн БНХАУ болон хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан Тажикстан улсын хооронд үүссэн асуудал, харилцааны талаар интернэт, сошиал орчинд ихээр бичих болсон. Тэнд бичигдэж байгаа Тажикстанд тулгараад байгаа Хятадын аюул занал гээч нь үнэндээ бодит асуудал бөгөөд хятадууд юу юугүй цэрэг оруулаад эзлэн түрэмгийлдэггүй юм аа гэхэд өөрийн нөлөөний бүс болгох сонирхол агуулж байгаа, агуулсаар ч ирсэн юм. Энэхүү бүс нутаг нь аль эртний Тан улсын үеэс л өмнө зүгийн суурин иргэдийн ашиг сонирхолд өртөж түрж ирсэн газар нутаг юм.

Энэ тухай бичихээс өмнө тажикууд хэмээгдэгч улс, үндэстний түүхийг танилцуулъя. Тажик хэмээгч хүн ард нь эртний перс гаралтай хүмүүс бөгөөд түүхийн явцад Төв Азид идэвхтэй улс төр явуулж байсан олон үндэстэн, улс гүрнүүд янз бүрийн үндэстнүүдийг өөрсдийн зүгээс тажик хэмээн нэрлэдэг байж. Нийтийн тооллын өмнөх 4-р мянганд Тажикт хүрэл зэвсгийн үеийн соёл иргэншил оршин байжээ хэмээн археологийн судалгаагаар тогтоожээ. Бичиг сударт тэмдэглэгдсэнээр Тажик орны зарим хэсэг НТӨ 6-р зуунд Персийн Ахеменидийн хаант улсын харьяанд байсан ба Македоны Александрын байлдан дагуулалтаар грек Бактрийн улсын мэдэлд оров. Нутгийн умард хэсэг эртнээс эдүгээ хүртэл Согд хэмээгдэх газар орон бөгөөд энд худалдаа наймаа, газар тариалан, шилэн болон модон эдийн дарх эртнээс хөгжсөн. Эртний согдууд арабуудыг тазиг хэмээн үзэж байсан бол Түрэгийн хойч үе болох харлугууд, огузууд, сельжукууд эсрэгээр нь Хорасаны персүүдийг тажик гэж нэрлэжээ. Кушаны (30–375) мэдэлд байж будда, несторын христ, зороастр, манихейзм зэрэг шашин дэлгэрчээ. Цагаан хүннү (408–670)-гийн үед арабууд ирж ислам шашныг дэлгэрүүлсэн ба өрнө дорныг холбосон Торгоны зам бий болсон байв. Дараагийн зуунуудад араб, төвд, перс, түрэг, монгол хаадын мэдэлд явсаар 14-р зуунд Төмөрийн улс, 16-р зуунд Бухарын хант улсын харьяа нутаг болов. Бухарын эмирт улс, Хокандын хант улсын мэдэлд орж байв. Энэ үед Дундад Азийн нийт перс хэл соёлт угсаатнуудыг тажик хэмээн нэрлэх болсон ба он жилүүдийг өнгөрөөсөөр 1868 онд Самарканд, Бухарыг Хаант орос эзлэхэд бүрэлдэхүүнд нь оржээ. 1910-1913, 1916 онд бослого гарсныг оросууд тухай бүр дарж байсан ба Хаант Оросын хөвөнгийн тариалангийн бүс нутаг болсон юм. Оросын иргэний дайны үед тусгаар тогтнохыг санаархсан ч Зөвлөлтийн улаан цэрэг ирж эзлэн Зөвлөлтийн төрийн бодлогоор элдэв зүйл шашныг хориглож, сүм хийдийг хааж, хамтралжуулах аян эхэлжээ.

Зөвлөлтийн 15 бүгд найрамдах улсын нэг болж, ингэснээр Иран, Афганистанаас өөр нэгэн перс хэлт үндэстэн улс болсноор түүх үргэлжилжээ. 1930-аад онд олон хүнийг улс төрийн хэргээр хилсээр ялласан. Оросууд 1926-1959 онд 1%-иас 13% болтол олноор нүүн ирж, төрийн гол албан тушаалд түлхүү ажилладаг болов. Нийслэлээ Сталинабад хэмээн нэрлэж байгаад 1960 оноос Душанбе гэх болж. Тажикт 1992-1997 онд иргэний дайн дэгдэж 100000 хүн үрэгдсэн.

Төв Азийн 143 мянган км2 газрыг эзэлсэн Тажик орон Дундад Азийнхаа Хиргис, Узбек болон төрөл хэлтний Афган, уулын цаадах Хятад гэсэн дөрвөн улсын нутгаар хүрээлүүлж, Вахан уулын жимээр таслагдан Пакистантай маш ойр оршдог. Үндсэндээ уулархаг, ялангуяа дорнод хагаст нь Памирын нуруу сүндэрлэн бий. 7.4 сая хүн амтайгаас нийслэл Душанбед 10 хувь нь оршин сууж байна. 84 хувийг өмнө зүгийн иран төрлийн хэлтэй тажик үндэстэн, 14 хувийг умар зүгийн түрэг төрлийн хэлтэй узбек үндэстэн бүрдүүлдэг. Аль аль нь ислам шашин шүтнэ.

Хилийн маргаан уу, их гүрнийг түшихээр шийдсэн үү?

Нутаг дэвсгэрийн маргааны түүхэн уг сурвалж нь 19 дүгээр зууны үеэс эхэлдэг. Тухайн үед хүч нь суларсан байсан Манж Чин гүрэн, колоничлолоо Ази руу идэвхитэй тэлж байсан Хаант Орос улсуудын ашиг сонирхол энэ бүсэд тулжээ. Хил тогтоолт Хаант Оросын давамгайллаар өндөрлөж Манжийн тал сэтгэл дундуур үлдсэн. Энэ асуудал 100 гаруй жил үргэлжилж ЗХУ-ын үед ч шийдэж чадаагүй юм. Харин 1990-ээд оны үед ЗХУ бутарснаар олон салангид бие даасан улсууд бий болж хилийн маргааныг шийдвэрлэхэд Хятадад илүү хялбар болсон байна. Нөгөө талаас БНХАУ нь өөрийн хамгийн тогтворгүй эмзэг бүс нутаг болох Шинжаантай залгадаг хилийнхээ асуудлыг яаралтай тодорхой болгож авах сонирхолтой байжээ. Иймээс Казахстан, Киргизстан улсуудтай маргааныг шийдвэрлэснийхээ дараа 2011 оны нэгдүгээр сард Тажикстан улстай 1877 оноос хойш тодорхойгүй байсан Памирын уулсын бүс дэх хилийн зурвасыг асуудлыг өрийн асуудалтай уялуулдан шахалт үзүүлэн тохиролцож чадсан байна. Тохиролцооны дүнд 1358 хавтгай дөрвөлжин км нутаг БНХАУ-ын харъяанд орсон түүхтэй. Тажикстаны гадаад хэргийн сайдын мэдээлснээр энэ нутаг нь Хятадтай маргаантай байсан нийт газрын 5.5 хувь болж байгаа аж.

Дахин түүх

Горно-Бадахшан нь хөрш Хятад, Тажикистаны хилийг бүрхэн оршдог 64200 км хавтгай дөрвөлжин газартай бүс нутаг юм. Душанбегийн эрх баригчид үүнээс 1500 гаруй км хавтгай дөрвөлжин газар нутгийг Бээжингийн захиргаанд шилжүүлсэн бөгөөд Душанбегийн эрх баригчдын энэ үйлдлийг түр шилжүүлсэн байх гэж олон улсын ажиглагчид таамаглаж байна. Памирын нуруунд байрладаг Горно-Бадахшан /Уулын Бадахшан/ нь хэдийгээр уулархаг бүс нутаг ч Хятадын хувьд стратегийн маш чухал ач холбогдолтой. Тажикистаны газар нутгийн 45 хувийг эзэлдэг ч хүн амынх нь ердөө гурван хувь тэнд оршин суудаг. Өөрөөр хэлбэл Горно-Бадахшаны уугуул иргэд энд голдуу суурьшдаг байна. Тажикстаны удирдлага болон Горно-Бадахшаны хооронд 1992-1997 оны хооронд хамгийн олон хүн амь үрэгдсэн тулаан болсон юм. Таван жил үргэлжилж 50-100 мянган хүний

аминд хүрсэн уг мөргөлдөөн ОХУ-ын эрх баригчдын зуучлалаар төгссөн юм. Арваад жилийн дараа Горно Бадахшаны автономит мужийн зэвсэгт бүлгийн толгойлогч Толиб Аёмбеков болон Душанбегийн эрх баригчдын хооронд дахин үл ойлголцол үүсч цус урсгасан зэвсэгт мөргөлдөөн дэгдсэн. Уг тулаан Тажикистаны тагнуулын ерөнхий газрын Горно-Бадахшан дахь салбарын тэргүүн, хошууч генерал Абдулло Назаровын үхлээс үүдэн дэгджээ. Түүнийг 2012 онд Горно Бадахшаны Ишкошим хотод үл таних этгээдүүд автомашинаас нь гаргаж амь насыг нь хөнөөжээ. Уг хэрэгт Засгийн газар Толиб Аёмбековыг буруутгасан бол тэр үүнийг эсэргүүцсэн юм. Хятадын Засгийн газар энэ бүс нутагт өөрийн цэргүүдээ оруулж эхэлсэн нь Хятадын аж үйлдвэрлэл хөгжих, хятад иргэдийн суурьших урьдач нөхцөл болж байгаа нь хэнд ч ойлгомжтой. Гэхдээ Тажикистаны эрх баригчид дээрх олон зуун га газраа гадаад өрөө төлтлөө Бээжингийн талд шилжүүлж хөгжүүлээд авья гэсэн бодол тээж магад. Учир нь Тажикийн эрх баригчид 20 гаруй жилийн салан тусгаарлах тэмцлийн дүнд захиргаандаа нэгтгэсээр байгаа томоохон хэмжээний газар нутгаа Бээжинд тийм ч амархан өгчихгүй байж мэднэ. Эсвэл Душанбегийн эрх баригчид Горно-Бадахшанаас 1500 гаруй км хавтгай дөрвөлжин газар нутгийг Бээжинд нэг мөсөн шилжүүлж олон тэрбум ам.долларын гадаад өрөө тэглэхийг зорьсон байж магадгүй юм. Одоо хилийн хяналт гэхээр юмгүй Тажикстаны Хятадтай хиллэдэг энэ бүс нутагт хятад иргэд хэдийнэ суурьшиж эхэлж, Хятадын цэргийн бааз ч байгуулагдаж.

Олон улсын валютын сангаас анхааруулсаар байтал Тажикстан улс Хятадаас авах зээлийнхээ хэмжээг бууруулж, зогсоон төлж эхлэх нь битгий хэл нэмж авсаар, Бээжин ч тэднийг улам “эрхлүүлж, тансаглуулсаар” Горно-Бадахшаныг түүхий эдийнхээ суурь, барааныхаа зах зээл болгон хувиргаж байна. Одоогийн байдлаар Хятад улс Тажикистаны гадаад өрийн 50 орчим хувийг дангаараа бүрдүүлж байгаа. Энэ нь үндэсний аюулгүй байдлын хэмжээнээс хэдийнэ давсан үзүүлэлт бөгөөд Хятад улс хөнгөлөлттэй зээл, худалдааныхаа нийлүүлэлтээр Тажикстаныг өөрөөсөө бүрэн хараат болгох эхлэл тавигдаж байна.

Эдийн засгаараа нэгэнт хараат болсон Тажикистан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын таван гишүүний нэг болсон бөгөөд энэ байгууллагын эдийн засаг ялангуяа эрчим хүч, дэд бүтцийн салбарынх нь хамгийн том хөрөнгө оруулагч нь маргаангүй Хятад улс юм. 250 мянга орчим хүн амтай Горно-Бадахшан нь байгалийн баялгийн нөөцтэй. Гэхдээ олборлоход тун хүнд бөгөөд Тажикистаны хамгийн бага судлагдсан газар нутаг гэнэ. Мөн мал, ан амьтан, уул, ус, ой мод, газар шорооны нөөцтэй. Ялангуяа үнэт чулуу, ашигт малтмал, эрдсийн олон том ордтой. Хятадын Засгийн газар Тажикистаны хяналт жилээс жилд суларч буй маргаантай бүс нутаг Горно-Бадахшаны багахан хэсгийн аюулгүй байдлыг хянаж, хяналтаа тогтоох нь цаашлаад бүхэлд нь хяналтаа тогтоож эзэмшихээс гадна Афганистан руу тэлэх боломжтой.

Афганистан нь газар тос, хар тамхи, очир алмазын өлгий нутаг Ойрхи-Дорнодын томоохон газар нутагтай орны нэг ч олон жил үргэлжилсэн дотоодын тэмцлийн улмаас хилээ хянах чадваргүй байгаа юм.

Ээж Жамьяаны Лхаасүрэндээ.

ЭЭЖДЭЭ

Цэцэгсийн шүүдрийн усны дуслыг цуглуулан
Цай чанаж өгч чадаагүй ч гэсэн
Санаанд орсон бодлын үгсээ тэрлэн байж
Сайхан ижийдээ шүлэг болгон барьж байна
Ээж минь
Бурхан минь
Жаран жилээр цаг хугацаа өнгөрөвч
Жамьян тайжтаны ганц бүсгүйн үр сад олширсоор л
Жаргалтай оронд олон жил амьдравч
Жаахан биетэй ээжийгээ дандаа зүүдлэх юм
Ээж минь
Бурхан минь
Эрдэнийн зандан эрхэндээ маанна уншиж
Энхрий олон хүүхдүүдээ бурхандаа даатгадаг
Энгийн мөртлөө их буянтай ээжий таньдаа
Энэ л насаараа залбирч мөргөе
Ээж минь
Бурхан минь

Б.Эрдэнэ-Очир.АНУ. Чикаго хот
2017-03-08

Амьдралын минь алтан хань
Амгаарагчаагийн Энхтуяадаа.

АМИН ЭРДЭНЭ

Аав,ээжий хоёртоо заяагдсан
Анхны хайртай Амин Эрдэнэ
Араасаа дагуулсан дүү нартаа
Ачлалт эгч,Ажаа Эрдэнэ
Хорвоод ханилсан ханьдаа
Халамжит гэргий ,Хайр Эрдэнэ
Булбарайхан хэдэн хүүхдүүддээ
Бурхнаас илгээгдсэн Эжий Эрдэнэ

Задарсан дүрсгүй шавь нартаа
Заазуур багш Алмааз Эрдэнэ
Захиргаагүй сургуулийн удирдлагадаа
Заан зөвлөгч Шударга Эрдэнэ
Анхны зээ хүү Тэддигийнхээ
Амин хайртай Эмээ Эрдэнэ
Өгөөмөр сэтгэл,уужуу ухааны
Өндөр ээж-Буянтай Эрдэнэ

Б.Эрдэнэ-Очир.АНУ. Чикаго хот.
2018-03-08


ХОНГОР НУТАГ

Холын энэ газраас эх орноо санан дурсахад
Хонгор нутаг минь нүдэнд үзэгдэх шиг болдог
Аавын минь олон жил шавилан сууж байсан
Алдарт "Ламын гэгээний хийд" номын өргөө нь
Азай буурлуудын минь шүтээн мөргөлийн газар байсан юм
Буурал ээж минь өглөө бүр цайныхаа дээжийг
Баян-Овоо,Номгон хайрхан ууландаа өргөж
Энхрий олон хүүхдүүд ач,гуч,зээ нарынхаа
Эрүүл мэнд,сайн сайхны төлөө
Эрихээ эргүүлэн,маниа уншиж л суудагсан
Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошуу
Эрдэнэцогтын хангай,Баян-Овоо,Түйн гол
Энэ л миний хүн болж хүмүүжин төлөвшсөн өлгий
Хангай ,Говь хосолсон Хонгор сайхан хутаг минь
Хаана ч гэсэн зүүдэнд уяатай мөнхийн шүтээн билээ

Б.Эрдэнэ-Очир.АНУ.Чикаго хот.
2017-09-15.

ХИЛЧНИЙ ШИРЭЭНИЙ НОМ

Энэхүү арга хэмжээ нь "Хил дагасан амьдрал" номын үзэсгэлэн, "Булган хангайн хилчин баатар" номын нээлт, эрдэм шинжилгээний хурлаар үргэлжилсэн юм. Баатарын алдар гавьяаг ном болгон мөнхөлсөн энэхүү номын зохиогч нь хурандаа Ш.Доржбал, зөвлөхөөр цэргийн



түүхийн ухааны доктор Н.Дававадорж ажиллаж, Д.Ганболд хянан тохиолдуулсан байна.

Арга хэмжээний үеэр Их сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор, хошууч генерал Ш.Лхачинжав "Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид, доктор профессор, зочид төлөөлөгчид өө


Эрхэм хүндэт генерал, офицер, ахлагч, сонсогч, суралцагчид аа. Та бүхэнд орчин цагийн Хил хамгаалах байгууллага үүсч хөгжсөний 86 жилийн ой, хилчдийн өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын тусгаар тогтнол, хилийн халдашгүй дархан байдлын бодит илэрхийлэл, сургамж бахархал болсон өнгөрсөн үеийн түүхээ бид мартах учиргүй.


XX зууны Монголын ард түмний тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, үйл хэрэгт үнэтэй гавьяа байгуулсан нэгэн эрхэм хүн бол одоогийн Булган аймгийн Сайхан сумын уугуул БНМАУ-ын баатар, хилчин ахмад Самданжамцын Лхагвадорж билээ.

Эгэл жирийн малчин ардын хүү С.Лхагвадорж нь Дотоод Явдлын яамны сайдын 1941 оны есдүгээр сарын 19-ний өдрийн 692 тоот тушаалаар Хязгаарын цэргийн төв сургуулийг төгсөж, Японы тагнуул, туршуул байнга улсын хил зөрчин өдөөн хатгаж байсан өмнөд хилийн Дорноговь аймгийн Замын-Үүдийн отрядын дугаар заставын даргаар томилогдон хилчин офицерийн гараагаа эхэлж байсан түүхтэй.

Тэрээр эх орон ард түмэндээ өргөсөн тангараг, эх орны дархан хилээ хамгаалах ариун үүргээ нэр төртэйгээр биелүүлж, Монгол Улсын баруун хязгаар болох Ховд аймгийн Булган сумын нутаг дахь Мэргэний уулын сав газар Оспанийн дээрэмчидтэй улсынхаа тусгаар тогтнол, аюулгүй байдлын төлөө баатарлагаар тулалдан алтан амиа өргөсөн Хязгаарын цэргийн баатруудын нэг билээ.

БНМАУ-ын баатар, ахмад С.Лхагвадоржийн байгуулсан баатарлаг гавьяаг хойч үе, хилчдэд сурталчилан таниулах, үлгэр дуурайл болгох үүднээс эрхэм баатрын мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан түүний намтар түүх, дурсамж, дурдатгал, шүлэг, найраглал, үр хүүхдүүдийн сэтгэгдэл, яриа зэргийг түүвэрлэн "Булган хангайн хилчин баатар" номыг эмхэтгэн гаргаж та бүхний оюуны бүтээл болгож байгаад бид баяртай байна" хэмээн онцолж, тус бүтээл нь хилчид, сонсогч, суралцагчдад эх орноо хайрлан хамгаалах, ахмад үеэрээ бахархах, эх оронч дайчин үзлийг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа хэллээ.





“Оюун ухааны чадавхын онцлого”
“Оюун ухааны онцлого чанар” номнуудыг доктор Б.Эрдэнэ-Очир түүрвэж, доктор профессор Ц.Ганболд ариутган шүүж хилчэн та бүгдэд оюуны хөрөнгө оруулалт хийж байна. Хүний оюун ухаан чадавх, онцлого чанарын талаар үндсэн ойлголт өгөх ба тэдгээрийн ангилал, зарим нэг сэтгэл зүйн чадваруудыг сонирхон судлах, хүмүүсийн туршлагаас суралцаж, ажил амьдралаа сайжруулах нөхцөл боломжуудыг эрж хайх, бие амьдралаа сайжруулах нөхцөл боломжуудыг эрж хайх, бие даасан хүн болон төлөвших бага ч гэсэн тус нэмэр болох болно.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Тэмдэглэл

Тэмдэглэл